Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн ХШҮ-ний тайлан
Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газар
2024 оны жилийн эцэс

| Шийдвэрийн д/д | Заалтын д/д | Шийдвэрийн нэр, огноо, | Холбогдох заалтын агуулга | Нэгдсэн дүгнэлт | Үнэлгээ |
|---|---|---|---|---|---|
| МУ-ын хууль | | | | | |
| 1 | 1 | БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН УДИРДЛАГА ЗОХИЦУУЛАЛТЫН ТУХАЙ 2003-05-30 Дугаар 2003_01 | 15.2.3. бүс нутгийн хөгжилд улсын төсвөөс оруулж буй хөрөнгө оруулалт болон санхүүгийн бусад дэмжлэгийг зориулалтын нь дагуу үр ашигтай ашиглах; | Бүс нутгийн хөгжилд том хувь нэмэр оруулах 2 том төсөл хэрэгжих шийдвэр гарсан. Хөөт-Бичигт чиглэлийн төмөр зам барих ажлын ТЭЗҮ хийгдэж байна. ТЭЗҮ-тэй холбоотой санал, холбогдох мэдээлэлийг хүргүүлж хамтран ажиллаж байна. Газрын тосны дамжуулах хоолой барих ажил аймгаар дамжин өнгөрч байгаатай холбоотойгоор Чойбалсан-Баруун-Урт чиглэлийн 110 кв-ын ЦДАШ -ыг шинээр баригдаж байгаа соёл амралтын хүрээлэнг тойруулан шилжүүлэх ажлыг орон нутгийн төсвийн 389,3 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөн төсөвт батлуулсан. Хувийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй Эрээнтолгой нүүрсний уурхайгаас Бичигт боомт чиглэлийн 110 км хатуу хучилттай авто зам барих ажил эхэлсэн. Үүнтэй уялдуулж орон нутгаас түгээмэл тархацтай ашигт малтмал хайх ашиглахтай холбоотой асуудалд ЗД-ын 2023 оны А/680 захирамжаар холбогдох дэмжлэг үзүүлж байна. Улсын төсвөөр хэрэгжүүлж буй авто зам барих, сургууль, цэцэрлэг болон бусад хөрөнгө оруулалтын ажлууд хууль дүрмийн дагуу хэрэгжиж байгаа ба гүйцэтгэгчийн буруугаас 1 соёлын төв, 1 цэцэрлэгийн барилга царцсан байдалтай байгааг орон нутаг төсвийг ахин шинэчлүүлж үргэлжлүүлэх арга хэмжээг авч ажиллаж байна | 70% |
| | 2 | | 15.2.4.. бүс нутгийн хөгжлийн талаар хийж байгаа ажлын үр дүнг Зөвлөлд тайлагнах; | Зүүн бүсийн зөвлөлийг  Дорнод аймгийн ЗД-аар ахлуулсан ажлын хэсэг, орон тооны ажилтан Дорнод аймгийн ЗДТГ-д ажиллаж байгаа жил бүрийн эхэнд жилийн төлөвлөгөөгөө батлуулан ажиллаж байна. Аймгийн зүгээс бүсийн ажлын төлөвлөгөөнд орон ажлын санал хүсэлтийг тухай бүр хүргүүлж, хамтран ажиллахын хамт зөвлөлд тухай бүрийн тайлан мэдээллийг хүргүүлэн ажиллаж хэвшсэн.<br><br>Үр нөлөө : Бүсийн зөвлөлд холбогдох тайланг тухай бүрт хүргүүлж хамтттран ажиллаж байна. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2 | 3 | ТӨСВИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ 2011-12-23 Дугаар 2015-10 | 14.2.11. Төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардал, эсхүл хийдлийг арилгах, бүтээмжийг дээшлүүлэх, төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн бусад байгууллагад 3-5 жил тутамд нэг удаа чиг үүрэг, үр дүнгийн иж бүрэн шинжилгээ хийж, үр дүнг Засгийн газарт | Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх хүрээний агентлаг, төсвийн бусад байгууллагад 3-5 жил тутамд нэг удаа чиг үүрэг, үр дүнгийн иж бүрэн шинжилгээ хийх ажлыг 2025 оны хяналт шалгалт, дотоод аудитын төлөвлөгөөнд тусгаж, хийхээр төлөвлөсөн. Жил бүр агентлаг, төсөв байгууллагын үйл ажиллагаанд үр дүнгийн шинжилгээ хийж, холбогдох алдаа зөрчлийг, арилгуулах арга хэмжээг авч ажиллаж хэвшсэн.<br><br>Үр нөлөө : Агентлаг төсөвт байгууллагуудад зөрчил гарах нь багассан. | 100% |
| 3 | 4 | Ойн тухай /Шинэчилсэн найруулга/ 2012-05-17 Дугаар 2022.06.03 | 39.7. Ой, хээрийн түймрээс хамгаалах арга хэмжээний зардлыг аймаг, сум, нийслэл, дүүрэг жил бүрийн төсөвтөө тусгана. | Хээрийн түймэртэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх , бэлтгэл бэлэн байдлыг хангуулах талаар 14 заалттай төлөвлөгөө боловсруулан Аймгийн Засаг даргаар батлуулж, Онцгой байдлын газрын даргын 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн А/116 тушаалаар Эрэн хайх, аврах салбарын 12 алба хаагчийн бүрэлдэхүүнтэй бүлэг томилогдон эрсдэлтэй үе, хээрийн түймэр гарах эрсдэл өндөр Дарьганга суманд 14 хоног үүрэг гүйцэтгэж тус сумын Бадрах 2 дугаар багийн нутаг Бор овоо, Баянцагаан, Бичигтийн шахаа, Баруун үнэгт, Өвөр хүрэм зэрэг газраар болон Хилийн цэргийн 0184 дүгээр ангийн 8 дугаар застав, Шилийн богдын ойр орчимд үйл ажиллагаа явуулж байгаа 21 хадлан тариалан, 22 айл өрх, 249 иргэн болон тээврийн хэрэгслийн жолооч нарт хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх санамж материал хүргэн зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэн ажилласан. Мөн Түмэнцогт сумын 2 дугаар багийн нутаг үйл ажиллагаа явуулж байгаа 11 хадлан тариалангийн үйл ажиллагаа явуулж байгаа 53 иргэнд хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэн ажилласан хээрийн түймэр гарах эрсдэл өндөр Асгат, Дарьганга, Сүхбаатар, Түмэнцогт, Эрдэнэцагаан | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 5 | | 19.1.1.. Харьяалах нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах, хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх;<br>(19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлье”, “Насанд хүрээгүй хүнийг болзошгүй осол гэмтэл, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх”, “Хичээл эхэллээ” “Хүүхэд хамгаалал” Гэр бүлийн хүчирхийллийн албадан сургалт”, зэрэг томоохон арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулсан. Гэнэтийн, болзошгүй аюул, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ХГБХГ, ЦГ, ОБГ зэрэг төрийн байгууллагууд хамтран эргүүл шалгалт зохион байгуулж, телевиз, фейсбүүк зэрэг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол зохион байгуулж, эрсдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэргэжүүлж ажиллсан.<br>Зөрчлийн хэргийн дагуу шүүхээр шийдвэрлэгдсэн иргэдийг давхардсан тоогоор 2980 цагийн албадан сургалтад хамруулсан ба 51 хохирогчийн мэдээллийг “Холбон зуучлах хуудас”-аар Хүүхэд, гэр бүл хөгжил, хамгааллын газар болон хамтарсан багт хүргүүлж, аюулын зэргийн үнэлгээг харгалзан 55 хохирогчийг хамгаалах байранд байрлуулан, нийгмийн ажилтны тусламж үйлчилгээ үзүүлэн ажилласан. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч болон согтууруулах ундаа | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 6 | | 19.1.2.. Хамтарсан багийг нэгдсэн удирдлагаар хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | Хамтарсан багийн хариу үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, удирдлагаар хангах зорилгоор кейс хэлэлцүүлгийг цахимаар 13 удаа, танхимаар 19 удаа, нийт 32 удаа зохион байгуулсан. Аймгийн хэмжээнд 22 хамтарсан баг үйлчилгээ үзүүлж байгаа ба “Хамтарсан баг” тус бүрт 1,0 сая төгрөгийн дэмжлэг, өвөлжилтийн байдал хүндэрсэнтэй холбогдуулан алслагдсан өрхүүдэд ажилласан хамтарсан багийн гишүүдэд 4,4 сая төгрөгийн урамшуулал нийт 2 удаа 26,360,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. ХГБЗГ-ын даргын тушаалаар "Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээ"-гээр 7 сумын 15 "Хамтарсан баг"-ийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийж, Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг үүрэг хүлээгчдэд таниулах үйлчилгээг үзүүлсэн. ХГБЗГ-ын даргын тушаалаар "Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээ"-гээр 7 сумын 15 "Хамтарсан баг"-ийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийж, Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай ху Сургуулийн хүүхэд хамгааллын багаар нийт 76 кейс дээр, сумын хамтарсан багаар 37 кейс дээр ажилласан байна. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 7 | | 19.1.3.. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр байгуулах саналаа иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | Аймгийн ИТХ-ын 2017 оны 66 дугаар тогтоолоор ГБХЗХГ -ын дэргэд "Хүүхэд, гэр бүлд зөвлөгөө өгөх төв"-ийг байгуулан улмаар Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр баригдсан Түр хамгаалах байрыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны 09 дүгээр тогтоолоор Аймгийн Цагдаагийн газарт шилжүүлэн гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байгаад 2023 оны 6 дугаар сараас эхлэн Түр хамгаалах байрны үйлчилгээг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар хариуцан үйл ажиллагаа, үйлчилгээг тасралтгүй зохион байгуулж байна. 2024 оны жилийн эцсийн байдлаар 41 хүүхэд, 14 насанд хүрэгч нийт 55 иргэнийг 973 хоног аюулгүй байдлын үйлчилгээнд хамруулсан.<br>Үйлчилгээнд хамрагдсан 41 иргэний гэр бүлд нөхцөл байдлын үнэлгээ хийж холбогдох хууль тогтоомж, гэр бүлийн харилцаа, хүмүүжлийн эерэг аргын талаар зөвлөмж зөвлөгөө өгч хяналтандаа авч ажилласан.<br><br>Үр нөлөө : Нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр байгуулагдаж, үйл ажиллагаа хэвийн, тогтвортой явагдаж байна. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4 | 8 | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/ 2016-12-22 Дугаар 2017.02.01 | 19.1.4.. Орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл болон төсөвт гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа, түүнд шаардагдах зардлын төсөв, ойрын ба хэтийн төлөвийг тодорхойлсон хөтөлбөрийн төсөл боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | Аймгийн ИТХ 2020 оны 03 дугаар тогтоолоор "Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл"-ийг батлан, Хүний хөгжил бүлгийн 2.6, 2.7 -д 10 арга хэмжээг төлөвлөн жил бүр 150,0 сая төгрөгийг төлөвлөн зарцуулж байна. Үндсэн чиглэлийн хүрээнд 2021 оны 01 дүгээр тогтоолоор "Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх дэд хөтөлбөрийг батлуулж, Засаг даргаар батлуулсан төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажилласан.ИТХ-ын 2022 оны 01 тоот тогтоолоор "Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх" дэд хөтөлбөр батлагдсан. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд "Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээ", "Төрийн үйлчилгээ малчны хотонд", "Түр хамгаалах байр"-ны үйл ажиллагаа, "Өвөлжилт хүндэрсэн үед малчидад хүрч ажиллах", "Өвөлжилт хүндэрсэн үед алслагдсан гэр бүлд хүрч ажиллах", "Хүлцэхүй" киног орон нутгиийн телевиз болон байгууллагын цахим хаягаар иргэдэд хүргэх, "Кейс хэлэлцүүлэг"-г тогтмолжуулах зорилгоор цахим болон танхимаар нийт 32 удаа, "Бид хамтдаа", эмэгтэйчүүдийн уулзалт зэрэг "Эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхдүүдийн илрүүлэг" хийх, "Шинэ жил-шөнийн эргүүл" ЕБС-д болон Спорт заал, дотуур байруудын орчин зэрэг 61 арга | 100% |
| | 9 | | 19.1.5.. Хохирогчид үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зардлыг төсөвт тусгуулах саналыг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | Хохирогчид үйлчилгээ үзүүлэх түр хамгаалах байрын урсгал зардлыг жил бүрийн орон нутгийн төсөвт тусган батлуулж , мэргэшсэн төрийн 6 албан хаагч ажиллаж, үйлчилгээгээ хүргэж байна. Иргэдийн Төлөөлөгчдийн 2023 оны 03 тоот тогтоолоор 2024 онд орон нутгийн төсөвт 150,0 сая төгрөгийг баталсан. Хохирсон иргэдийн хоол хүнсний зардлыг Хүүхэд гэрийн бүлийн хөгжил хамгааллын газраас санхүүжүүлэн ажиллаж байна. Аймгийн хэмжээнд 22 хамтарсан баг үйлчилгээ үзүүлж байгаа ба “Хамтарсан баг” тус бүрт 1,0 сая төгрөгийн дэмжлэг, өвөлжилтийн байдал хүндэрсэнтэй холбогдуулан алслагдсан өрхүүдэд ажилласан хамтарсан багийн гишүүдэд 4,4 сая төгрөгийн урамшуулал, нийт 2 удаа 26,4 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.<br><br>Үр нөлөө : Хохирогчид үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зардлыг орон нутгийн төсөвт жил бүр тусгуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 10 | | 19.1.6.. Хохирогчид үйлчилгээ үзүүлэх ажлыг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах, нийгмийн ажилтныг хохирогчтой ганцаарчлан уулзах өрөө, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;<br>19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ: | Хохирогчид үйлчилгээ үзүүлэх түр хамгаалах байрын урсгал зардлыг жил бүрийн орон нутгийн төсөвт тусган батлуулж , мэргэшсэн төрийн 6 албан хаагч ажиллаж, үйлчилгээгээ хүргэж байна. Иргэдийн Төлөөлөгчдийн 2023 оны 03 тоот тогтоолоор 2024 онд орон нутгийн төсөвт 150,0 сая төгрөгийг баталсан.<br>Хохирсон иргэдийн хоол хүнсний зардлыг Хүүхэд гэрийн бүлийн хөгжил хамгааллын газраас санхүүжүүлэн ажиллаж байна.<br>Аймгийн хэмжээнд 22 хамтарсан баг үйлчилгээ үзүүлж байгаа ба “Хамтарсан баг” тус бүрт 1,0 сая төгрөгийн дэмжлэг, өвөлжилтийн байдал хүндэрсэнтэй холбогдуулан алслагдсан өрхүүдэд ажилласан хамтарсан багийн гишүүдэд 4,4 сая төгрөгийн урамшуулал, нийт 2 удаа 26,4 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.<br>Түр хамгаалах байранд Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Нийгмийн ажилтны хохирогчтой ганцаарчлан уулзах өрөө, сэтгэлзүйчийн өрөөнүүдийг тохижуулж өгсөн тул үйлчилгээ явуулах орчин нөхцөл бүрдсэн.<br>Гэрч хохирогчид нийгэм, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх ХГБХХГ-ын дэргэдэх “Гэр бүлд зөвлөгөө өгөх төв”, Баруун-Урт сумын ЗДТГ-ын болон “Нэг цэгийн үйлчилгээний төв”-ийн дэргэд, "Түр хамгаалах байр"-ны дэргэд 3 төв иргэдэд | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 11 | | 19.1.7.. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг дэмжих, гэрээний үндсэн дээр санхүүжүүлэх;<br>(19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | Үүрэг хүлээгчдийг чадавхижуулах сургалтыг магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллагуудтай гэрээлэн гүйцэтгүүлэх ажлын хүрээнд “Хамтдаа” ТББ-тай гэрээ байгуулан Өсвөр насны хүүхдүүдэд бэлгийн цогц боловсрол олгох “Үе тэнгийн сургагч багш” бэлтгэх сургалтыг зохион байгуулж, сургалтад хамрагдаж буй оролцогч сурагчдад нийгэм, сэтгэл зүйн зөвлөгөөнүүдийг өглөө. Сургалтад Баруун-Урт сумын ЕБ-ын 4 сургууль, МБС-ын 1 сургуулийн нийт 30 суралцагч хамрагдлаа. Мөн ганцаарчилсан зөвлөгөөнд 3 суралцагч хамруулсан. Монголын Эмэгтэйчүүдийн холбоо үүсэн байгуулагдсаны 100 жилийн ой хүрээнд Сүхбаатар аймгийн эмэгтэйчүүдийн холбоотой хамтран “1000 ЭЭЖИЙН БАЯР”-ын арга хэмжээг 9 дугаар сарын 20-ны өдөр Баруун-Урт хотноо зохион байгууллаа. Тус арга хэмжээнд 12 сум , аймгийн төвийн 9 багаас, салбар салбарын, нас насны төлөөллийн 1000 эмэгтэйчүүд оролцож, ахмадууддаа хүндэтгэл үзүүлэх, гэр бүл, хамтын амьдрал, хайрын талаар лекц сонсож, харилцан бие биенээсээ суралцах, эмэгтэйчүүдийн оролцоо, нөлөөлөл ямар байх талаар хэлэлцсэн үр дүнтэй арга хэмжээ боллоо. “Бага насны хүүхдийн цогц хөгжил” хүүхэлтэй ажиллах арга зүйн | 100% |
| | 12 | | 19.1.8.. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулах, энэ чиглэлээр идэвх санаачилгатай ажиллаж байгаа этгээд, хамт олон, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах;<br>(19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | Аймгийн Засаг даргын 2021 оны А/271 дүгээр захирамжаар " Шилдэг хамтарсан баг" "Хүүхдэд ээлтэй сум", "Хүүхдэд ээлтэй эцэг эхийн зөвлөл" шалгаруулах уралдааны болзлыг батлуулан жил бүр хэрэгжилтийг 12 сард дүгнэн хэрэгжүүлж байна. Шилдэг хамтарсан багаар жил бүр 3, Хүүхдэд ээлтэй эцэг эхийн зөвлөлөөр жил бүр 3 , нийт 13 баг байгууллагыг шалгаруулж урамшуулал олгож байна.<br><br>Үр нөлөө : Засаг даргын 2021 оны А/271 дүгээр захирамжаар гэр бүлийн хүчирхийллээс  урьдчилан сэргийлэх ажил арга хэмжээг эрчимжүүлэх, иргэд, олон нийтийн оролцоог дэмжин, сайшаах шийдвэр гарсан ба хэрэгжилтийг хэнган ажиллаж байна. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 5 | 13 | Хоршооны тухай /Шинэчилсэн найруулга/ 2021-05-06 Дугаар 2021.05.06 | 43.2.1. хоршоог дэмжих, хоршооны үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; | "Шинэ хоршоо" хөдөлгөөний хүрээнд 2024 оны 4 дүгээр улирлын байдлаар эрчимжсэн мал аж ахуй , сүү цагаан идээ боловсруулах, мах боловсруулах зэрэг үйл ажиллагаа эрхлэх 170 хоршооны 430 малчинд 14,5 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгоод байна. Мөн хоршоо хөгжүүлэх сангаас 2 сумын 3 хоршоонд 110 сая төгрөгийн зээл олгосон. ЖДҮХСангаас загвар хоршооны чиглэлээр Баруун-Урт сумын “Аз дэлгэрэх мөнх” хоршоо 296,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Жижиг, дунд үйлдвэрийн газар, Сүхбаатар аймгийн ЗДТГ, аймгийн ХХААГ, Зээлийн батлан даалтын сан, АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг /USAID/-ийн “Жижиг Дунд Бизнесийн Тогтвортой Хөгжлийг Сайжруулах, Ил Тод Байдлыг Нэмэгдүүлэх” BEST хөтөлбөртэй хамтран Аймгийн хоршоологчдын чуулган зохион байгуулсан. Сүхбаатар аймгийн 13 сумын 200 гаруй малчин, хоршоологчдын төлөөлөл оролцсон.<br>ХХААХҮ-ийн Сайдын А/26 дугаар тушаалаар Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн яамны хооронд байгуулсан гэрээний дагуу “”Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл”-ийн эх үүсвэрээс орон нутагт түүхий эдийн | 70% |
| | 14 | | 10.1. Үйл ажиллагааны чиглэл, ашигт ажиллагааны түвшнийг харгалзан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсний нийтлэг жишгийг төрийн өмчит хуулийн этгээдийн хувьд Засгийн газар, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хувьд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно. | Аймгийн ОНӨААТҮГ-ын дарга нарын цалин ИТХ-ын 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсний нийтлэг жишгийг тогтоох тухай” 05 дугаар тогтоолоор баталсан. Энэ онд 5 орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаа, эдийн үзүүлэлтийг нь дүгнэж, цалинг 10 хувиар нэмэгдүүлсэн.<br><br>Үр нөлөө : ИТХ-ын 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн тогтоолоор төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсний нийтлэг жишгийг тогтоосон шийдвэр гарсан | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 15 | | 13.1.2. энэ хуулийн 13.1.1-д заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусгаагүй бол төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцох; (13.1.1.батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах; 22.1.Энэ хуулийн 13.1.1, 13.1.2 дахь заалтыг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.) | Хуулийн 13.1.1, 13.1.2 дахь заалтыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. | Х.Б |
| 6 | 16 | Төрийн хэмнэлтийн тухай 2022-04-29 Дугаар 2022.04.29 | 8.1. Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно. (Энэ хуулийн 8.1-д Үндсэн хуулийн цэцийн гишүүний болон шүүгчийн өмсгөл, эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах, зам тээврийн салбарын ажилтнуудын хуульд заасан тусгай хувцас болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 15.1-д заасан тусгай хувцас хамаарахгүй) | Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авсан зөрчил гараагүй. Хуулийн хэрэгжилт хангагдсан | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 17 | | 8.2. Энэ хуулийн 8.1-д Үндсэн хуулийн цэцийн гишүүний болон шүүгчийн өмсгөл, эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах, зам тээврийн салбарын ажилтнуудын хуульд заасан тусгай хувцас болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 15.1-д заасан тусгай хувцас хамаарахгүй. | Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авсан зөрчил гараагүй. Хуулийн хэрэгжилт хангагдсан | 100% |
| | 18 | | 14.2. Худалдан авах бараа, үйлчилгээний төрөл нэмэгдэх тохиолдолд энэ хуулийн 14.1-д зааснаар хүсэлтийг тухай бүр хүргүүлнэ | Хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар чиглэл хүргүүлж, хэрэгжилтийг хянаж ажиллаж байна. | 70% |
| | 19 | | 14.4. Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно. | Орон нутаг дахь төрийн байгууллагууд цахим дэлгүүрт байршсан бараа үйлчилгээг авч хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар чиглэл, зөвлөмж өгсөн ба хяналт шалгалтын ажил хийгдэж байна | 70% |
| | 20 | | 14.5. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар зарлана. | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахим, олон нийтийн мэдээллийн системээр зарлаж сонгон шалгаруулалтыг хийж байна. | 100% |
| | 21 | | 15.2.1. Байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх; (15.2.Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд дараах арга хэмжээг авч ажиллана) | Бүх сумд, ААНБ, иргэдэд өвлийн бэлтгэл хангах, дулааны алдагдалгүй байх, болзошгүй эрсдлээс сэргийлэх зөөвөр зөвлөгөө зөвлөмж, сануулгыг мэргэжлийн байгууллагуудаар өгүүлсэн. Зохистой хэмнэлттэй хэрэглээг төлөвшүүлэх талаар мэргэжлийн зөвлөмжүүдийг тогтмол өгч байна. | 100% |
| | 22 | | 15.2.2.. Нэгдсэн халаалтын системд холбогдсон барилга байгууламжийг хэмнэлтийн горимд тохируулах, тоолуур ашиглах; | Нэгдсэн халаалтын системд холбогдосон бүх барилгуудад тоолуур ашиглаж байна | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 7 | 23 | Үндэсний их баяр наадмын тухай /шинэчилсэн найруулга/ 2022-06-28 Дугаар 2022.06.28 | 5.4. Энэ хуулийн 5.3-т заасан нөхцөлд аймаг, сумын баяр наадмыг тэмдэглэх хугацааг 08 дугаар сарын 10-ны өдрөөс хэтрүүлэхгүй байхаар тогтооно. (5.3.Онцгой нөхцөл байдлаас шалтгаалан энэ зүйлийн 5.2-т зааснаас өөр өдрүүдэд улс, аймаг, сумын баяр наадмыг тэмдэглэх бөгөөд улс, аймгийн баяр наадмын хугацааг Засгийн газар, сумын баяр наадмын хугацааг аймгийн Засаг дарга тогтооно.) | Аймгийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн А/292 дугаар захирамжаар Сүхбаатар, Уулбаян, Эрдэнэцагаан сумд үүсэн байгуулагдсаны түүхт 100 жилийн ойн баяр наадмыг 2024 оны 07 дугаар 27,28-ны өдрүүдэд бусад сумдын наадмыг 07 дугаар сарын 05,06-ны өдрүүдэд тус тустэмдэглэн өнгөрүүлж хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | 100% |
| 8 | 24 | Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/ 2022-07-05 Дугаар 2023.01.01 | 15.7. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн тоог тухайн нутаг дэвсгэрт оршин сууж байгаа хүн амын тоо, нутаг дэвсгэрийн хэмжээ, эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал, эрүүл мэнд, соёл, спортын байгууллага, оюутан, сурагчдын хичээлийн болон дотуур байрны байршил, аймаг, нийслэлийн саналыг харгалзан хүнс, эрүүл мэнд болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд хамтран тогтооно. | Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн тоог аймаг, суманд 1000 хүн ам тутамд 4 хүртэл байхаар тогтоосны дагуу 2023 оны 04 дүгээр улиралд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл бүхий 233 аж ахуй нэгжид мэргэжлийн байгууллагуудын төлөвлөгөөт хяналт шалгалтыг хэрэгжүүлж ажилласан. Ажлын хэгсийн дүгнэлт, саналыг үндэслэн 2024 оны 1 дүгээр улиралд дээрхи эрх бүхий аж ахуй нэгжүүдээс 46 тусгай зөвшөөрөл хүчингүй болгож, 18 тусгай зөвшөөрлийг түтгэлзүүлсэн<br><br>Үр нөлөө : хуулийн хэрэгжилт бүрэн хангагдсан | 100% |
| УИХ-ын тогтоол | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 9 | 25 | Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай 2001-06-14 Дугаар 2001№57 | 2.3.. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлын эх үүсвэрийг эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэл, улсын төвлөрсөн төсөвт тусган шийдвэрлэж байх. (Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг баталсантай холбогдуулан дор дурдсан арга хэмжээг хэрэгжүүлэхийг Засгийн газар /Н.Энхбаяр/-т даалгасугай.) | 2024-2025 оны аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, Хөгжлийн жилийн төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичгүүдэд бүсчилсэн хөгжлийн үзэлэ баримтлалыг тусган шаардагдах зардлуудыг тусгасан. | 70% |
| | 26 | | 3. газар хөдлөлтөөс хамгаалах арга хэмжээг хот төлөвлөлтийн бодлогод тусгаж хэрэгжүүлэх, төвлөрлийг сааруулж, суурьшлын бүс, дагуул хотыг газар хөдлөлтийн эрсдэл багатай бүс рүү төлөвлөж хөгжүүлэх арга хэмжээг авах; | Сүхбаатар аймаг нь газар хөдлөлтийн хувьд харьцангуй эрсдэл багатай бүсд хамаардаг ба болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэхийн тулд баригдаад олон жил болсон, мэргэжлийн байгууллагын дүгнэлт гарсан байшин барилгуудыг ашиглахыг зогсоож, сургууль цэцэрлэгийг шинээр төлөвлөж буй суурьшлийн бүсүүдэд төлөвлөн байрих ажлуудыг хийж байна. Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын 1-р багийн нутаг дэвсгэрт Амгалан гэр хорооллын дахин төлөвлөлт, тандалт судалгаа, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг орон нутгийн төсвийн хөрөнгөөр "Ланд овнер" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлж эцсийн шатны тайланг хүлээн авсан. Инженерийн дэд бүтцийн ажлын зураг төсөл боловсруулах даалгаврыг хийж гүйцэтгэн баталгаажуулаад байна. 3-р багийн нутаг дэвсгэрт 2013 онд дахин чөлөөлөлтийн ажлыг 17 га газарт хийсний үр дүнд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулж Музей, Цэцэрлэг, Номын сан, Худалдаа үйлчилгээ, Зочид буудал бүхий 960 айлын орон сууцны хороололыг төлөвлөгдөн батлагдсан | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 10 | 27 | Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2016-04-14 Дугаар 2016 №34 | 7. газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөлтийг боловсронгуй болгох, бэлэн байдлыг хангах, гамшгийн аюулыг эрт зарлан мэдээлэх тогтолцоог өргөтгөх, улсын болон байгууллага, аж ахуйн нэгжийн нөөцийн удирдлага, чадавхыг бэхжүүлэх, урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэл, иргэд, олон нийтийн байгууллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх; | Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 67 дугаар тогтоолоор батлагдсан “Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр”-ийг Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуулийн бэлтгэл ажлыг хангуулах ажлын хүрээнд 13 сумд, болон гамшгаас хамгаалах орон нутгийн 11 алба, 20 мэргэжлийн анги, аж ахуйн нэгж, байгууллагуудад Онцгой байдлын газрын даргын 2024 оны 32/67 тоот албан бичгээр үүрэг чиглэлийг хүргүүлж, заавар зөвлөгөө өгч удирдлагаар хангаж ажилласан. Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339 дүгээр тогтоол “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам”, 340 дүгээр тогтоол “Гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах журам” “Гамшгийн аюулын тухай” зарлан мэдээллийн дохиогоор ажиллах сургалт, дадлага сургуулийг зохион байгуулж “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, тохиолдсон үед авах арга хэмжээ” сэдвээр гамшгаас хамгаалах орон нутгийн 11 алба, 20 мэргэжлийн ангийн төлөөлөл, төрийн болон төрийн бус байгууллагын ажилтан, албан хаагчдын хамруулан 27 удаагийн 29 цагийн сургалтыг 837 хүнд танхимаар зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө | 100% |
| | 28 | | 8. “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө”-г батлан, төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний зардлыг жил бүрийн улсын төсөвт тусган шийдвэрлүүлж байх. | Газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх Байнгын ажиллагаатай салбар зөвлөлийг аймгийн засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 26 өдрийн А/71тоот захирамжаар шинэчлэн томилгоожуулсан. Салбар зөвлөлөөс 2024 онд хэрэгжүүлэх 4 бүлгийн 15 заалт бүхий төлөвлөгөө боловсруулж, батлуулж, хэрэгжилтийг 90%-тай хангуулж ажилласан. Аймгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийлгэж, газар хөдлөлтийн гамшгийн үед ажиллах хүн хүч, техник хэрэгслийн судалгааг шинэчлэн гаргаж, салбар дундын хамтын ажиллагааг сайжруулж ажилласан. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 29 | | 1.5/. Орон сууц, сургууль, цэцэрлэг, эмнэлгийн барилга байгууламжийн чанар, газар хөдлөлтөд тэсвэрлэх байдлыг шалгаж, барилга байгууламжийг паспортжуулах ажлыг 2017 онд багтаан дуусгах, газар хөдлөлтөд тэсвэргүй барилгыг буулгаж шинээр барих, ашиглах боломжтой барилгын судалгааг гаргаж, тэдгээрийг үе шаттайгаар бэхэлж хүчитгэх ажлыг зохион | 2008 оноос 2023 он хүртэл Сүхбаатар аймгийн хэмжээнд шинээр ашиглалтад орсон барилга байгууламжийн дэлгэрэнгүй судалгааг нэгтгэн гаргасан. 2021 оноос хойш ашиглалтад орсон 17 барилга байгууламжид гэрчилгээ олгосон.2023 оноос хойш шинээр ашиглалтад орж буй барилга байгууламжуудын паспортжуулах шаардлагатай материал бэлтгэн хүлээн аваад байна. ХББОСЯ-д салбарын хяналтын газраас гэрчилгээний загвар шинэчлэх ажил хийгдэж буй тул гэрчилгээ шинээр олгогдоогүй зогсонги байдалтай байна. | 70% |
| 11 | 30 | “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай 2020-05-13 Дугаар 2020 №52 | 3.1/. Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх зохион байгуулалтын дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т үүрэг болгосугай:<br>1/Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үндэсний, салбарын, салбар хоорондын болон бүс нутаг, аймаг, нийслэлийн түвшний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгаж, шаардагдах хөрөнгийг улс, орон нутгийн төсвийн болон санхүүжилтийн бусад эх үүсвэрээс төлөвлөн үе шаттайгаар хэрэгжүүлэх; | ХБТТУТХуулийн дагуу урт хугацааны бодлогын баримт бичиг Алсын хараа 2050 д үндэслэн Хөгжлийн зорилтот хөтөлбөр түүнд үндэслэн Улсын Таван жилийн Үндсэн чиглэл үүнд үндэслэн аймгийн Таван жилийн үндсэн чиглэл боловсруулагдахаар заагдсаны дагуу орон нутаг Таван жилийн Үндсэн чиглэлээ боловсруулж батлуулсан. Аймгийн энэ таван жилийн Үндсэн чиглэлд үндэслэн Засаг дарыгн үйл ажиллагааны хөтөлбөр, хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулагдаж байгаа нь эцэстээ Монгол улсын урт дунд богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүд уялдаатай боловсруулагдаж байна. | 70% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 12 | 31 | МОНГОЛ УЛСЫН 2023 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ БАТАЛСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2022-11-11 Дугаар 2022 №72 | 1.2. Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого", 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т туссан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний бэлтгэл ажил, зураг төсөв болон техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлыг 2023 онд шуурхай зохион байгуулах; | хасах саналтай<br><br>Хяналтаас хасуулах санал : 2023 оны төсвийн дууссан тул хасах салтай | Х.Б |
| | 32 | | 1.3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төсвийн хөрөнгө оруулалтын сахилга бат, хариуцлага, үр ашгийг сайжруулах зорилгоор төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зураг төсвийг санхүүжилтийнх нь эх үүсвэр батлагдсан тохиолдолд боловсруулах; | УТХО-ын төлөвлөлтөнд зураг төсөв , магадлалаар баталгаажсан зураг төсөлтэй ажлын санхүүжүүлэхээр төлөвлөлтөнд тусгаж байна. Аймгийн хэмжээнд ОНТ, ОНХС-ийн хөрөнгөөр ирэх онд хэрэгжүүлэх ажлын Зураг төсөл ТЭЗҮ боловсруулахад 936,0 сая төгрөг баталж хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Өмнөх онд хэрэгжсэн 4 зөвлөх үйлчилгээнд 135,5 сая төгрөгийн санхүүжилт, шинээр батлагадсан 34 зураг төсвөөс 24 зураг төсвийн гэрээ байгуулан гүйцэтгэлээр 456,5 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Үүнд: 5-р тойргоос чонотой хөшөө хүртэл 2.5 км авто зам, гүүр 2-р тойргийн авто замын их засвар шинэчлэлтийн ажлын зураг төсөв боловсруулах 88,0 төгрөг, сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, 7 худаг малчдын хороолол чиглэлийн 1.6 км, 3 дугаар тойргийн авто замаас барилачдын талбайн чиглэлийн 1.1км хатуу хучилттай авто зам барих ажил, Уртын голын цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажил гэх мэт. | 100% |
| | 33 | | 1.10. Холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн тухайн аймгийн байнгын оршин суугч иргэдэд орон нутгийн нислэгийн тийзийн үнийн хөнгөлөлтийг үзүүлэх. | орон нутагт онгоц нисдэггүй<br><br>Хяналтаас хасуулах санал : онгоц нисдэггүй тул хэрэгжих боломжгүй | Х.Б |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 13 | 34 | ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ТУХАЙ ХУУЛЬ БАТАЛСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2023-05-04 Дугаар 2023_32 | 1.3. төрийн албан хаагчийн Ёс зүйн дэд хороог байгуулах ажлыг мэргэжил, арга зүй, зохион байгуулалтын удирдлагаар хангаж, үйл ажиллагааг жигдрүүлэх. | Ёс зүйн дэд хорооны ажиллах журмын төслийн хэлэлцүүлэг 3 сарын 01-нд цахимаар болсон зарыг агентлаг төсөвт байгууллага, сумдын төрийн байгууллагын алба хаагчдаас санал авч нэгтгэн altanbagana@csc.gov.mn хаягаар саналаа хүргүүлсэн. Мөн “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн төсөлд санал нэгтгэн хүргүүлсэн. Ёс зүйн дэд хороо байгуулах чиглэлээр зөвлөн тусалж ажиллаж байна. Төрийн албаны зөвлөлөөс цахимаар болон танхимаар Төрийн албан хаагчийн ёс тухай хуулийг дагаж мөрдөх, нэг мөр ойлгож хэрэглэх, ёс зүйн хэм хэмжээг сахиулах чиглэлээр ёс зүйн дэд хороодод арга зүйн дэмжлэг үзүүлэх сэдвээр 3 удаа сургалт хийсэн ба танимын сургалтад 350 албан хаагч оролцсон. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Ёс зүйн дэд хороог 7 хүний бүрэлдэхүүнтэй томилон тус бүр 10 байгууллагыг хариуцан ёс зүйн дэд хороог байгуулах, гишүүдэд арга зүйн зөвлөгөө өгөх, тайлан мэдээ нэтгэн хүргүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. аймгийн хэмжээнд 120 гаруй төрийн байгууллагад ёс зүйн дэд хороо байгуулагдах ба ёс зүйн дэд хороо байгуулах ажил 50 хувьтай байна. | 70% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 14 | 35 | АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ 2023-06-30 Дугаар 2023_59 | 3. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагааг улсын болон аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар ханган хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, Авлигатай тэмцэх газар /З.Дашдаваа/-т тус тус үүрэг болгосугай. | Авлигын эсрэг хуулийн 21 дүгээр зүйлд “Улсын Их Хурал Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах бөгөөд түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт заасан хугацаагаар батална.” гэж заасны дагуу хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлагдаж, 2024.05.27-ны өдрийн 03/9364 тоот албан бичгээр ирсэн бөгөөд уг төлөвлөгөөнд аймгийн Засаг даргын хариуцан гүйцэтгэх арга хэмжээнүүдээс 2 арга хэмжээг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгуулан, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Мөн АТГ-аас ирүүлсэн албан бичгийн дагуу уг хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, тайлангах чиг үүрэг бүхий албан хаагчаар тус хэлтсийн эрх зүйн сургалт, сурталчилгаа, хууль зүйн зөвлөгөө, хүний эрхийн бодлого хариуцсан мэргэжилтэн томилогдож, мэдээллийг АТГ-т хүргүүлсэн. 2024.09.04-ний өдөр Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн мэдээг АТГ-ын АТҮХ хэрэгжүүлэх хэлтэст хүргүүлсэн. ЭБАТ Авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэрэгт хүлээлгэх хариуцлага сэдэвт сургалтыг 6 удаа 108 төрийн албан хаагчидад, АТГ-аас Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг танилцуулах сургалтыг аймгийн ЗДТГ, ИТХ-ын ажлын | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 36 | МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ БАТАЛСАНТАЙ ХОЛБОГДУУЛА | 1.2. хөдөөд орон сууцны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээнд шаардагдах санхүүжилтийг төр, хувийн хэвшлийн түншлэл, улс, орон нутгийн төсөв, олон улсын байгууллагын хөнгөлөлттэй зээл, тусламжийн эх үүсвэрээс бүрдүүлэх замаар олон талын оролцоог хамарсан хамтын санхүүжилтээр шийдвэрлэх; | Жилийн эцсийн байдлаар Баруун-Урт суманд хувийн хөрөнгө оруулалтаар 4 барилга 248 айлын орон сууц ашиглалтад ороод байна. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтай төр хувийн хэвшил хамтран түрээссийн орон сууцны хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд орон нутгийн төсвөөр инженерийн шугам сүлжээний ажлыг шийдвэрлэн "Голден би ти эс" ХХК-ний Шинэ тэмүүлэл хотхоны 1 ээлжийн 56 айлын орон сууц Улсын комисс ажиллан байнгын ашиглалтад ороод байна. Хоёрдугаар ээлжийн 56 айлын орон сууцны барилга угсралтын ажил гүйцэтгэгдэж байна. Орон сууцны барилга нь иргэдийн худалдан авалт ипотекийн зээл авахад хүндрэлтэй малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч, шинэ залуу гэр бүлийг дэмжсэн зээлийн хүүгүй хувь лизинг нэвтрүүлж шинэ байртай болох боломжийг бүрдүүлж байна.Наран суманд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 600,0 сая төгрөгийг төсөвт тусган 4 айлын орон сууц барих зураг төсвийн ажлыг хийж гүйцэтгэж байна. Мөн Мөнххаан суманд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 24 айлын орон сууцны барилгын ажлыг Өдрийн аз ХХК-н хийж гүйцэтгэж байна. | 70% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 15 | 37 | ХОЛБОГДУУЛА Н АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2023-11-10 Дугаар 2023_93 | 1.10. төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих, ашиглалтад хүлээн авах, өмчид хүлээн авах үйл ажиллагаанд ногоон байгууламжийн стандарт болон тусгай хэрэгцээт иргэдийн хэрэгцээнд нийцсэн стандартыг чанд мөрдөж хэрэгжүүлэх, зохион байгуулах; | 2024 онд Улсын болон орон нутгийн төсөл хөтөлбөрөөр 28 төсөл арга хэмжээ, хувийн хэвшлын хөрөнгө оруулалтаар 12 төсөл арга хэмжээ буюу барилга байгууламж баригдсан. Барилга байгууламжийн архитектур төлөвлөлтийн даалгавар боловсруулах шатанд Барилгын тухай хууль тогтооомж, норм дүрмийн дагуу нийт газрын 30 хувь нь авто зогсоол, 10 хувь ногоон байгууламж хийгддэг. Барилгын хөгжлийн төв нь гүйцэтгэсэн зураг төсөвт магадлал хийж хянаж ажилладаг ба батлагдсан зураг төсвийн дагуу улсын комисс ногоон байгууламжийн стандартыг мөрдүүлэн ажиллаж байна.<br>Баруун-Урт суманд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 960 хүүхдийн сургуулийн барилгыг аймгийн Засаг даргын А/239 тоот захирамж, Спорт цогцолборын барилга угсралтын ажлыг аймгийн Засаг даргын А/302 тоот захирамж, Түвшинширээ суманд баригдсан 100 ортой дотуур байрны барилгад А/373 тоот захирамж, Дарьганга сум 150 ортой цэцэрлэгийн барилга А/664, Үйлдвэр технологийн парк дэд бүтэц барилга угсралтын ажлуудад томилогдсон ажлын хэсгүүд ажиллаж байнгын ашиглалтад оруулсан. Өмч бүртгэлд тусгах ажлыг хийж гүйцэтгэхээр комиссын бүрэлдэхүүнд орон нутгийн өмчийн газрын | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 16 | 38 | Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 2024-01-12 Дугаар 2024_05 | 1.6. төрийн цахим үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд операторын горимоор хүргэх цэгийг аймаг, сум, нийслэл, дүүрэг, хороонд байгуулах. | "Цахим Сүхбаатар" дэд хөтөлбөрт цэгүүдийн тоог нэмэгдүүлэх, 24/7 үйлчилгээний төвийг нэвтрүүлэх, төрийн үйлчилгээний тоо хэмжээг нэмэгдүүлэх талаар арга хэмжээнүүдийг тусган өгч ажиллаж байна. 2024 оны 12 дугаар сарын байдлаар Төрийн үйлчилгээний хурдан төвийн үйл ажиллагааг сайжруулах, иргэдэд төрийн үйлчилгээг хурдан шуурхай хүргэх чиглэлээр сумдын Засаг дарга нар Аймгийн засаг даргатай байгуулсан гэрээнд "Хурдан" цэгийг сумдад нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр 1 арга хэмжээ тусган өгч, сүхбаатар аймаг дахь төрийн цахим үйлчилгээний хэлтсээр дамжуулан 12 суманд нэгдсэн хаягтай болгоход сумдын ЗДТГазраас нийт 2,784,000 зарцуулж, иргэдэд төрийн үйлчилгээний нэгдсэн системийн заавар, зөвлөгөө мэдээллээр хангах арга хэмжээг тус тус авч хэрэгжүүллээ. Баруун-Урт сумын Авто тээврийн төв дээр шинээр төрийн үйлчилгээний коиск машиныг Төрийн цахим үйлчилгээний хэлтсээс байршуулаад байна. | 70% |
| 17 | 39 | Засгийн газарт чиглэл өгөх тухай 2024-01-17 Дугаар 2024_11 | 1.1. төрөөс иргэн, хуулийн этгээдэд үзүүлж байгаа үйлчилгээний төлбөр, хураамжийн ногдуулалт, түүний зарцуулалтын талаар судалж, дүгнэлт, саналаа 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор Улсын Их Хуралд иргүүлэх; | орон нутагт хамааралгүй<br><br>Хяналтаас хасуулах санал : орон нутгийн чиг үүрэгт хамааралгүй тул хасах саналтай | Х.Б |
| | 40 | | 1.2. төрөөс үзүүлж байгаа үйлчилгээний төлбөр, хураамж болон тэдгээрийн зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэх, хууль тогтоомж зөрчсөн төлбөр, хураамжийг хүчингүй болгох арга хэмжээ авах. | Орон нутагт хамаарлгүй<br><br>Хяналтаас хасуулах санал : орон нутгийн чиг үүрэгт хамааралгүй тул хасах саналтай | Х.Б |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 18 | 41 | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай 2024-04-18 Дугаар 2024_27 | 2. 2.Хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагаа, арга хэмжээг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7, 6.8, 6.9 дэх хэсэгт заасны дагуу үндсэн чиглэл, хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Ёс зүйн хороо, Засгийн газрын, төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороо, бүх шатны томилох эрх бүхий албан тушаалтанд тус тус даалгасугай. | “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг төрийн байгууллагын дарга нарт танилцуулж, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүрэг болгоод байна. Мөн аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Төрийн албан хаагчийн ёс зүйн хариуцлагын тогтолцоог сайжруулан, соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулах чиглэлээр зорилт, үйл ажиллагаа төлөвлөөд байна. | 70% |
| | 42 | | 2.а. а/бүх шатны боловсролын сургалтын байгууллага, дотуур байрны гадаад болон дотоод орчны аюулгүй байдлын стандартыг хангуулах, боловсролын байгууллагын барилга, өргөтгөлийн ажилд төр, иргэний хамтарсан хөндлөнгийн хараат бус хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх; | Улсын төсвийн хөрөнгөөр Түвшинширээ сум, орон нутгийн хөрөнгөөр Сүхбаатар суманд дотуур байр ашиглалтад орсноор аймгийн хэмжээнд ажиллаж байгаа 14 дотуур байрны 12 буюу 85.7% нь стандартын шаардлага хангасан. Дотуур байрны нүхэн жорлонг ариун цэврийн байгууламжаар солих арга хэмжээг жил дараалан хэрэгжүүлж байгаа ба энэ онд 5 дотуур байрны ариун цэврийн байгууламжийг 12 дугаар сард ашиглалтад өгөхөөр барилга угсралтын ажил хийгдэж байна. Дээрх 5 дотуур байрны ариун цэврийн байгууламж ашиглалтад орвол сургуулийн дотуур байрууд 100 % орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болно. Баяндэлгэр сумын дотуур байрын камержуулалт 10.0 сая, эцэг эх, асран хамгаалагч нараас 4.8 сая төгрөг, Сүхбаатар сумын дотуур байранд орон нутгаас 10.0 сая төгрөг, Түвшинширээ сум ЗДТГ, багш ажилчид, эцэг эх, асран хамгаалагчдын хандиваар 17.0 сая төгрөг, Халзан суманд 6 настны өрөөг тохижуулахад 7.0 сая төгрөг, Дарьганга, Наран суманд ахмад багшийн гэр бүл хүүхэд хөгжлийн танхимд 10.5 сая төгрөгийн хандив, Мөнххаан суманд төгсөгчдийн хандиваар 10.0 сая төгрөгийн хандиваар хүүхэд хөгжлийн танхимыг | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 19 | 43 | Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2023 оны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2024-05-02 Дугаар 2024_37 | 2.б. б/хөгжлийн бэрхшээлтэй сурагчийн эрхийг хангах хүрээнд тэднийг дэмжих төв ажиллуулж, тохирох орчныг бүрдүүлэх, тусгай сургалтын хэрэглэгдэхүүн бий болгох, эцэг, эхийн оролцоог хангаж, багшийн туслахаар ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх, багш, багшийн туслах, ажилтанд нэмэгдэл хөлс олгох хуулиар тогтоосон арга хэрэгслийг үр дүнтэй хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын цогц арга хэмжээ авах; | Тусгай хэрэгцээт хүүхэдтэй ажиллах арга зүйн сургалт зохион байгуулах, сургалтын орчин, ганцаарчилсан сургалтын хөтөлбөрийг сайжруулах зорилготой Жайка старт 2, EQUAL төсөл Баруун-Урт сумын 1 дүгээр сургууль, Дарьганга, Түмэнцогт сумдын Ерөнхий боловсролын сургуулиудад хэрэгжиж багш, эцэг эх, ажилтнууд хамрагдаж сургалт, нөлөөллийн ажил хийгдсэн. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилладаг багш нарт 10 хувийн цалингийн нэмэгдэл олгож байна. Баруун-Урт сумын 8 дугаар цэцэрлэг алслагдсан хөдөөгийн малчин өрхийн хүүхдэд боловсрол олгох “Хаалга бүрт мэдлэг” төсөл хэрэгжүүлж 18 өрхийн 2-5 насны 34 хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол олгосон. Адина-тэгш боломж ТББ-аас зохион байгуулсан "Тэгш хамран сургах боловсролын сургагч багш бэлтгэх" сургалтад ерөнхий боловсролын сургуулийн 2 ажилтан хамрагдсан бөгөөд Боловсролын дэлхийн түншлэл олон улсын байгууллага БШУЯ-ны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих” төслөөр 2024-2025 оны хичээлийн жилд зорилтот 3 сургуулийн “Дэмжлэгийн баг”-ийн үйл ажиллагааг сайжруулах, нийт багш ажилтан, эцэг эхчүүдэд сургалт зохион байгуулж 10 | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 44 | | 3.в. в/аймаг, дүүрэг бүрд байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд зориулсан нөхөн сэргээх, нийгэмшүүлэх, боловсрол олгох, өдөр өнжүүлэх хөгжлийн төв болон байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн төрөлжсөн асрамж халамжийн төв байгуулах, холбогдох санхүүжилт, хүний нөөцийн асуудлыг цогцоор нь шийдвэрлэх. | Байнгын асаргаа шаардлагатай хүүхэд зориулсан өдөр өнжүүлэх, төрөлжсөн асрамжийн газар байхгүй ба аймгийн засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төв" байгуулж өгөх саналыг тусгуулсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс нь 2024 онд 22 удаа хуралдаж, 216 хүүхдийн асуудлыг хэлэлцэж, 24 хүүхдийг хөгжлийн бэрхшээлтэй болохийг тогтоож, 44 хүүхдийн байнгын асаргааг шинээр тогтоож, 143 хүүхдийн байнгын асаргааг сунгаж, 2 хүүхдийн асаргааг биеийн байдал сайжирч, эдгэрсэн үндэслэлээр цуцалж, 3 хүүхдийг онош баталгаажуулах шаардлагатай тул гэж үзэн буцаасан. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхийн төлөөлөлд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болон төрийн бус байгууллага байгуулах талаар зөвлөгөө, хамтран ажиллах боломж нөхцөлийг талаар мэдээлэл өгч, “Сэтгэлзүйч эцэг эх” хүүхэд хүмүүжлийн эерэг арга, нөхөрсөг уулзалт хэлцүүлэг зохион байгуулсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих чиглэлээр зүүн бүсийн майхант чуулганд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн төлөөллийг | 70% |
| 20 | 45 | Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2024-08-27 Дугаар 2024_21 | 2.3. 3/Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон жил бүрийн улсын төсөвт тусган хэрэгжүүлэх; | хугацаа болоогүй | Х.Б |
| | 46 | | 2.4. 4/Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнахдаа энэ тогтоолын 2 дугаар хавсралтад заасан шалгуур үзүүлэлтийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ | хугацаа болоогүй | Х.Б |
| УИХ-ын байнгын хорооны тогтоол | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 21 | 47 | Сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирусын халдварын тархалтыг бууруулах, хязгаарлах, урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай 2016-04-05 Дугаар 2016 №10 НББСШУБХ | 3.1/. Харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, ХДХВ/ДОХ-ын тархалтыг бууруулах, хязгаарлах тухай эрсдлийн удирдлагын хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, (2018-2020 оны сүрьеэ, бэлгийн замын халдварт өвчний статистик иргүүлэх) | Сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдвар (БЗДХ)-т өвчнийг тандах, илрүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэгт зорилтот бүлгийг хамруулах арга хэмжээг орон нутгийн хэмжээнд зохион байгуулан ажиллаж байна. БЗДХ хавьтал, эмчилгээ-100%, Сүрьеэгийн хавьтлын иргүүлэг үзлэг, шинжилгээ 85%-тай байна. -Глобаль сан, МСЭМХ, ЭМГ-ийн хамтарсан гэрээний дагуу хаалганаас хаалганд үзлэг, шинжилгээг 6 сумын зорилтот бүлгийн хүн амд зохион байгуулж байна. 12 сарын 05-ны байдлаар Асгат, Сүхбаатар, Эрдэнэцагаан сумын 486 иргэнийг үзлэгт хармуулснаас хавьтал 70%-ийг эзэлж байна. 59 иргэнээс цэрний сорьц авч, 150 иргэнд туберкулины сорил тавьж, сэжигтэй тохиолдол 2 илрүүлсэн. -АНЭ-ийн төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч нараас бүрдсэн баг Анхан шатны 10 сумын ЭМТ-д явуулын амбулаторийн тусламж үйлчилгээг үзүүлсэн. ХДХВ/ДОХ/БЗДХ-ын шинжилгээнд хамрагдвал зохих 14035 иргэнээс 5843 иргэн хамрагдаж үзлэг 41%-тай хийгдсэн байна. -АЗД-ын 2022 оны А/290 дүгээр захирамжийн дагуу ЭМД-гүй иргэдийн 5 төрлийн оношлуураар шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. 2024 оны 3 дугаар улирлын байдлаар 5 төрлийн | 70% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 22 | 48 | Бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирусын халдварын тархалтыг бууруулах, урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай 2016-12-14 Дугаар 2016 №04 НББСШУБХ | 2.1/. Хүн амын дунд БЗДХ-т өвчин нэмэгдэж байгаатай холбогдуулан аймаг, нийслэл, дүүргийн түвшинд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичигтээ ХДХВ ын халдвар, ДОХ болон БЗДХ-аас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгаж, хэрэгжилтийг хангах; | Сумдад жил бүр явуулын амбулаторийн үзлэг - Глобал сан, Монголын сумын эмч мэргэжилтнүүдийн холбооны үзлэг - Эрүүл Сүхбаатар төсөл - Эрт илрүүлэг үзлэг шинжилгээ зэрэг нийтийг хамарсан ажлыг зохион байгуулсан. Энэ онд Бэлгийн замаар дамжих халдвар (БЗДХ)-ын илрүүлэг шинжилгээнд 15-49 насны 14035/ 9105/64% иргэнийг хамруулсан.<br>Аймаг сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд сумдын төсөвт явуулын амбулаторийн үзлэгийн зардалыг тусгаж жил бүр илрүүлэг үзлэгийг зохион байгуулж байна. Аймгийн 9 сум/ 75 %-д нь явуулын амбулаторийн үзлэг шинжилгээ идэвхтэй хэлбэрээр хамруулсан. Үүнд зорилтот бүлгийн 15-49 насны 5380 хүн хамрагдаж тэмбүүгийн шинэ өвчлөл 10 илэрч эмчилгээнд хамрагдсан. БЗДХ-ын кабинетаар 5155 хүн үзлэгт хамрагдсанаас Урьдчилан сэргийлэх үзлэг 3904. Өвчний учир амбулаторын үзлэг-785. Идэвхтэй хяналт-195 байна. Нийт илрүүлсэн өвчлөл 153 буюу 10000 хүн амд харьцуулсан харьцаагаар 21,5 промиль байна. Тэмбүү-42 буюу 6,4 промиль, заг хүйтэн-73 буюу 11,2 промиль, трихомониаз-38 буюу 5,8 промиль байна. Тайлант онд бэлгийн замын халдвартай 26 жирэмсэн эмэгтэй бүртгэгдсэн. Үүнээс | 70% |
| | 49 | | 2.2/. Нутаг дэвсгэрийнхээ хүн амыг эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангахад шаардагдах зардлыг жил бүрийн төсөвтөө тусгаж батлуулах, зарцуулалтад хяналт тавих. | 2024 онд Баруун Урт суманд Өрхийн эмнэлгийн барилга 89,659,7 төгрөгийн өртөгөөр баригдан ашиглалтад орж, Уламжлалтын эмнэлэгт тоног төхөөрөмж 40,000.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлж, Онгон сумын ЭМТ-д 475,000 төгрөгийн засвар хийсэн.<br>Мөн аймгийн нэгдсэн эмнэлэг 17050 ш 32,517,038 төгрөгийн Дох, тэмбүүгийн түргэвчилсэн оношлуур худалдан авсан. 4500 хүн тун, 1,335,000 төгрөг RPR оношлуур, 4600 хүн тун, 4,916,000 ТРНА оношлуур худалдан авч зарцуулсан. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 23 | 50 | “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл”-ийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2018-01-31 Дугаар 2018 №02 ХЗБХ | 3.8.. Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, дээрх үйл ажиллагаанд шаардагдах төсөв, хөрөнгийг шийдвэрлэх, дээрх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг дэмжих, урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулахад анхаарах, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл хамтарсан багийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллах, хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах, хорооны цагдаагийн алба хаагч, нийгмийн ажилтны орон тоог нэмэгдүүлэх, мэргэжлийн нийгмийн | 2022 онд Японы сангийн буцалтгүй тусламжаар Хууль зүй дотоод хэргийн яам, Азийн хөгжлийн банкны хамтарсан төслийн хүрээнд 253.6 сая төгрөгийн санхүүжилтээр нийт 8 хүн хүлээн авах багтаамжтай, 177 м.кв талбай бүхий “Түр хамгаалах байр” байгуулагдаж, орон нутгийн төсөвт 150,0 сая төгрөгийг тусган зардлыг шийдвэрлэн ажиллаж байна.Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дэргэд Сэтгэл зүйн өрөө тохижуулж, 129 гэр бүлд сэтгэл зүйн зөвлөгөө үзүүлсэн ба гэр бүлийн боловсрол олгох нэвтрүүлэг, подкаст, шторк, рийл, постер зэрэг нийт 35 төрлийн мэдээллийг бэлтгэн цахим орчин, орон нутгийн телевизээр иргэдэд хүргэж, түр хамгаалах байрны алба хаагчдад үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж түүнийг даган гарсан дүрэм, журам болон холбогдох стандартын сургалт мэдээллийг сард 3 удаа зохион байгуулсан.ИТХ-ын 2022 оны 01 тоот тогтоолоор "Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх" дэд хөтөлбөр батлагдсан. Тус хөтөлбөрийн хүрээнд 38 үйл ажиллагаа төлөвлөсөн ба дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах чиглэлээр “Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээг сумдад зохион байгуулж, хүүхдийн төлөө зөвлөл, хамтарсан баг, байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөл | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 24 | 51 | Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай 2020-08-26 Дугаар 2020.08.26 №01 ИЦББХ | 3. Бүх шатны боловсролын байгууллагын мэдээллийн технологийн тоног төхөөрөмж, дэд бүтцийн нөхцөл байдалд үнэлгээ хийж, бэлэн байдлыг үе шаттай хангуулах | 2024 оны байдлаар Асгат, Онгон сумын цэцэрлэг боловсролын нэгдсэн сүлжээнд холбогдож, ерөнхий боловсролын 15 сургуульд LMS, SMS системийг нэвтрүүлэн сургуулийн захирал, сургалтын менежер, багш нарт зөвлөгөө өгч ажилласны үр дүнд манай газар бүх сургуулийн мэдээллээ нэгтгэж харах боломжтой болсон. Ингэснээр багшийн хичээл оролт, сурагчийн хичээлийн идэвх оролцоо, бие даан суралцах явц, хүүхэд хамгаалал болон сургуулийн мэдээллийг эцэг эх асран хамгаалагч нарт цаг тухай бүрд нь хүргэдэг болсон. Ирэх оны 1 дүгээр сараас эхлэн үлдсэн 1 сургууль LMS, SMS системд нэвтрүүлэх захиалга өгсөн. Интернэт, цахим шилжилтийн бэлэн байдалтай холбоотой судалгааг 3 янзаар авч дүгнэлт хийн сайжруулах талаар цахим зөвлөгөө болон боловсролын салбарын удирдах ажилтны зөвлөгөөн дээр танилцуулсан. Үүний үр дүнд Уулбаян, Түвшинширээ, Баруун-Урт сумын 2-р сургууль нэмэгдсэнээр ерөнхий боловсролын 16 сургууль боловсролын нэгдсэн интернэтэд холбогдсон. Мөн ерөнхий боловсролын сургуулийн дотоод сүлжээг сайжруулах, үүсэж болох сүлжээний доголдол асуудлын талаар мэдээллийн технологийн багш нараар дамжуулан цахим /meet/ болон БГ-н | 100% |
| 25 | 52 | Чиглэл өгөх тухай 2020-12-16 Дугаар 2020 | 1.1/. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2020 оны 07 дугаар тогтоолоор байгуулсан ажлын хэсгийн хяналт шалгалтын тайланг хэлэлцээд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /У.Хүрэлсүх/-т чиглэл болгосугай: 1/ Мах экспортлогч үндэсний аж ахуйн нэгжүүдийг бодлогоор дэмжиж, мах, махан бүтээгдэхүүнийг экспортолдог аж ахуйн нэгжүүдийн тоог нэмэгдүүлэх; | Баруун-Урт сумын “Дарьт шүтээн “ХХК-ний “Баян тал “ махны үйлдвэр Иран улсад 2024 онд хонь 1500 тн, адуу 1100 тн бүгд 2600 тн мах экспортолсон. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 53 | №10 БОХХААБХ | 1.5/. Экспортод гаргаж байгаа мах, махан бүтээгдэхүүний тодорхой хувь нь чанар, стандартын шаардлага хангахгүй байгаа тул мэргэжлийн хяналтын үйл ажиллагааг сайжруулж, оновчтой зохион байгуулалт хийх; | Мах бэлтгэн хэрэглэгчдэд нийлүүлдэг аж ахуй нэгжүүдэд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны салбарын хяналтын газрын салбарын ерөнхий байцаагчийн баталсан 08-00-02/29 дугаартай удирдамжийн дагуу мал төхөөрөх 2 объект, мах боловсруулах 1 объект, нийт 2 аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус шалгалт хийж 78 зөрчил илрүүлэн 56.0 хувийг газар дээр арилгуулан улсын ахлах байцаагийн 38 заалттай 2 албан шаардлага хүргүүлэн биелэлт 85 хувьтай байна.<br>Экспортод мах гаргадаг 1 компани үйл ажиллагаа явуулж байгаа ба зөрчил гаргаагүй. үйл ажиллагаа хэвийн явагдаж байна | 100% |
| | 54 | | 1.2/. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний байрыг стандарт, техникийн зохицуулалтад нийцүүлэн шинээр барих, засварлах, өргөтгөх болон стандартын шаардлага хангасан зориулалтын тоног төхөөрөмжөөр хангахад шаардагдах зардлыг шийдвэрлэх; | Энэ онд улс, орон нутаг, төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр 4 сургууль 168 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр хангагдсан байна. Мөн 13 цэцэрлэг 27 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр хангагдсан байна. Баруун-Урт сумын 960 хүүхдийн сургууль, Түвшинширээ сумын 100 хүүхдийн дотуур байр, Сүхбаатар сумын 100 хүүхдийн дотуур байрууд ашиглалтад орсон ба гал тогоо стандартын шаардлага хангасан шинэ тоног төхөөрөмжөөр хангагдсан. | 100% |
| | 55 | Ерөнхий | 1.9/. ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдалд мэргэжлийн хяналтийн байгууллагаар үнэлгээ хийлгэж, санал дүгнэлтийг улсын хэмжээнд нэгтгэн гаргаж, цаашид үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангах; | Хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй нийт 10 объект төлөвлөснөөс 9 буюу 90 хувийг хяналт шалгалтад хамруулсан. Шалгалтаар 1 объект үйл ажиллагаа явуулаагүй тул хяналт шалгалтад хамрагдаагүй. Хяналт шалгалтын хугацаанд нийт 116 зөрчил илрүүлж 31 хувийг газар дээр нь арилгуулж хугацаа шаардах зөрчилд 80 заалттай 10 албан шаардлага хүргүүлж ажиллалаа. Албан шаардлагын биелэлт 100 хувьтай байна. Шалгалтын явцад хялбаршуулсан журмаар 1 аж ахуй нэгжид 1 сая төгрөгийн торгууль тавьж бүрэн барагдуулсан. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 26 | 56 | Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай 2021-05-25 Дугаар 2021 №05 БСШУСБХ | 1.10/. орон нутгийн болон үндэсний үйлдвэрлэлийг дэмжсэн, аюулгүй хүнсний ханган нийлүүлэлтийн тогтолцоог бий болгох, сургуулийн хоол үйлдвэрлэлд ашиглах хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний худалдан авах ажиллагааг ерөнхий гэрээний дагуу зохион байгуулах ажлыг | Орон нутгийн үйлчилгээ худалдаа эрхлэгчдээс сүү сүүн бүтээгдэхүүн, мах, ногоо зэрэг бүтээгдэхүүнүүдийг худалдан авахаас гадна үндэсний үйлдвэрлэлийн бараа бүтээгдэхүүнүүдийг гэрээний дагуу худалдан авч ЕБС-ын хоол үйлдвэрлэлд нийлүүлж байна. | 70% |
| | 57 | | 1.11/. 2022 оноос эхлэн хуулийн хэрэгжилтэд шаардагдах урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг улсын төсөвт бүрэн тусгах, аж, ахуйн нэгж, байгууллагын хандив, олон улсын байгууллага, гадаад орнуудын буцалтгүй тусламжийн хүрээнд хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэх. | 2024 онд Баруун-Урт сумын 960 хүүдийн сургуулийн барилга, Дарьганга, Наран сумдын цэцэрлэг, Түвшинширээ, Сүхбаатар сумдад дотуур байрын шинэ барилгыг ашиглалтад оруулснаар стандартын шаардлагад нийцсэн хоол үйлдвэрлэл, үйлчилгээтэй байгууллагын тоо нэмэгдэж 2024, 2025 оны төсөвт зардлууд нь тусгагдсан. 2023 оны 05-р сарын 03 өдөр батлагдсан Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний үндэсний MNS 7005:2023 стандартыг Сүхбаатар аймгийн 16 сургууль 24 цэцэрлэг нь 2024 оны 01 сарын 01 өдрөөс эхлэн мөрдөж ажиллаж байна. Сүхбаатар аймаг нь Ерөнхий боловсролын 16 сургуулийн 23 гал тогоотой, 24 цэцэрлэгийн 24 гал тогоотой нийт 32 буюу үүний 68% стандартад нийцэхүйц гал тогоотой байна. Үр дүн: 2024онд Улсын төсвийн 9.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар баригдсан 960 хүүхдийн шинэ сургуулийг улсын комисс хүлээн авснаар 3-р сургуулийн үдийн хоол хөтөлбөрт хамрагддаг 870 сурагч стандартын шаардлага хангасан хоол үйлдвэрлэлийн гал тогоо, хооллох заалтай болсон. Түвшинширээ сумын 100 хүүхдийн дотуур байр, Сүхбаатар сумын сургуулийн 150 хүүхдийн дотуур байрын ашиглалтанд орсноор стандартын | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 58 | | 1.1/. Биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дараах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т чиглэл болгосугай: 1/ Биеийн тамир спортын тухай хууль, МУЗГ-ын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд биеийн тамир, спортын чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг МУЗГ, бүх шатны ИТХ, аймаг, нийслэлийн Засаг дарга, биеийн тамир, спортын Улсын хороо хангаж ажиллах; | Аймгийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ Жүдо бөх, Сагсан бөмбөг, Хөл бөмбөг, Дугуй, Волейбол, Шатар, Буудлага, Үндэсний бөх зэрэг спортын 8 төрлөөр жилийн хугацаанд Дэлхий, Олон улсын, Улсын аварга шалгаруулах, Бүсийн болон нэрэмжит 51 тэмцээн уралдаанд орж, нийт 279 багц медаль хүртээд байна. Засаг даргын нөөц сангаас сагсан бөмбөг, хөл бөмбөгийн шигшээ баг тамирчдад тэмцээн зохион байгуулах, оролцох зардалд 29 сая төгрөг зарцуулсан. -Мөн БТСУХ, Спортын Анагаах Ухааны Эрдэм Шинжилгээний Төв хамтран орон нутгийн өсвөрийн шигшээ багийн тамирчдын бие бялдарын ерөнхий хөгжил болон биеийн бүтэц, баланс, сэтгэл зүй, хоол шим тэжээлийн байдлыг сорил тест болон асуумжийн аргаар судлах, суурь судалгааны мэдээлэл цуглуулах сорилд 7 спортын төрлийн 83 тамирчин хамрагдсан. Энэ судалгааны дүгнэлтээр тамирчин тус бүрт зөвлөмж өгсөн байна. - "Найрсаг Баруун-Урт, театр" өдөрлөгийн үеэр Баруун-Урт сумын Засаг даргын тамгын газраас шигшээ багийн спортын төрлүүдэд 13 сая төгрөгийн өртөг бүхий спортын хэрэглэгдэхүүний дэмжлэг үзүүлсэн | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 27 | 59 | Биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай 2021-10-19 Дугаар 2021 №8 БСШУСБХ | 1.5/. бүх шатны боловсролын сургалтын байгууллагын биеийн тамирын хичээлийн хөтөлбөр агуулгыг боловсронгуй болгох, тоног төхөөрөмж, материаллаг баазыг бэхжүүлэх, суралцагчдыг спортын секц, дугуйланд хамран суралцуулах бололцоог бүрдүүлэх талаар холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх; | Аймгийн нийт 16 сургууль, МБСБ-ын сурагчдын бие бялдрыг хөгжүүлэх, биеийн тамирын хичээлийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, спортын амжилт гаргах нөхцөл бололцоогоор хангах арга хэмжээг үе шаттайгаар 2021-2024 оны хичээлийн жилд улсын төсөв, төсөл хөтөлбөр, төгсөгчдийн хандив зэрэг эх сурвалжуудаас санхүүжүүлэн бүрдүүлэн ажиллаж байна. 2024 оны эхний хагас жилд: Түмэнцогт сумын ЕБС төгсөгчдийн хандиваар 8.2 сая төгрөгийн үнэ бүхий Сагсны бөмбөг -5, волейболын бөмбөг-5, Бочи спорт хэрэглэгдэхүүн багц, Бөхийн дэвжээ Халзан сумын ЕБС хандиваар 1.6 сая төгрөгийн үнэ бүхий Сагсан бөмбөг 2ш,волейболын бөмбөг 3ш,волейболын тор,дартсны самбар1ш,сум 3ш Сүхбаатар сумын ЕБС Сумын БЭМХЭД сангаас 10 сая төгрөгийн үнэ бүхий Волейболын бэлтгэл хангах төхөөрөмж буюу бөмбөг-15ш, довтолгооны төхөөрөмж-1,холболтын төхөөрөмж-2ш, хаалтын самбар-1ш тус тус худалдан авч хэрэглэгдэхүүн тоног төхөөрөмжийн нөөцийг нэмэгдүүллээ. Мөн шинээр Баруун-Урт суманд 960 хүүхдийн хичээлийн шинэ байр ашиглалтад орсноор 3-р сургуулийн сурагчид стандартад зал танхимд биеийн тамирын хичээл орох нөхцөл боломж бүрдлээ. Үр дүнд Өсвөр үе, залуучуудыг спортын олон төрлөөр | 100% |
| | 60 | | 1.6/. Биеийн тамирын багш, дасгалжуулагч, арга зүйч, мэргэжилтэн бэлтгэх сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох, тэдгээрийг гадаад улсад бэлтгэх, мэргэшүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх; | БТСУХ, Монголын Модон барилдааны холбоо, аймгийн БТСГ хамтран зохион байгуулсан "МОДОН БАРИЛДААН"-ы сургалтад 16 сургуулийн 18 багш амжилттай хамрагдаж сертификаттай боллоо. Сургалтыг Монголын Модон барилдааны холбооны мэргэжлийн багш дасгалжуулагч нар зохион байгуулав. ISF WSC сагсан бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнтэй холбоотой HOD and COACHES онлайн сургалтад 3-р сургуулийн багш Д.Тасхүү амжилттай хамрагдлаа. Мөн 2023-2024 оны хичээлийн жилийн мэргэжил дээшлүүлэх эхний жилийн үндсэн сургалтад Онгон сумын багш Х.Золжаргал, 4-р сургуулийн багш Н.Сувд-Эрдэнэ нар, 2024-2025 оны хичээлийн жилд 1-р ангийн сурагчидтай ажиллах арга зүйн сургалтад 16 сургуулийн 21 багш танхим цахим хосолсон хэлбэрээр амжилттай хамрагдаж, сургалтаас олж авсан мэдлэг туршлагаа ажлын байрандаа хэрэгжүүлэн ажиллаж байна | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 61 | | 1.12/. Нутгийн өөрөө удирдах байгууллага, бүх шатны засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, иргэдийн идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлэх, спортын барилга байгууламж, заал, талбайн хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх, жил бүрийн улсын төсвийн төсөлд  биеийн тамир спортын салбарын зардлыг нэмэгдүүлэх талаар анхаарч ажиллах. | Иргэд хөдөлмөрчид, аж ахуй нэгж төрийн болон төрийн бус байгууллагуудын дунд идэвхтэй дасгал хөдөлгөөнийг дэмжих зорилгоор 10 дэх жилдээ бямба гариг бүрийн өглөө 07 цагт бүх нийтийн гүйлтийг зохион байгуулан давхартсан тоогоор 4568 иргэд хөдөлмөрчид хамрагдсан.<br>•Сүхбаатар аймгийн Баруун-Урт хотод Спортын шинэ цогцолбор ашиглалтанд орж, уг спорт цогцолборын барилга нь R=20.00-22.14 м-ийн хэмжээтэй хоёр давхар дугуй барилга юм. Зоорийн давхаргүй төвлөрсөн 3 орц гарц, шатны 4 хонгилтой нэг давхрыг нь спортын дасгал сургалт, үйлчилгээний байрны зориулалтай, уламжлалт гэр загварын 3-13м өндөр танхимын дундах R= 24 м талбайг төрөл бүрийн спорт тэмцээн зохиоход тойрч хүрээлсэн талбайд нь 1000 гаруй үзэгчид тухлан суух зориулалтай цогцолбор ашиглалтанд орсон. Спортын ил гадаа талбай аймгийн хэмжээнд 47 байгуулагдсан, сургуулийн болон спортын 22 заал үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Энэ онд нийт Нийтийн биеийн тамирын 98 арга хэмжээ, давхардсан тоогоор 46343 хүүхэд, залуучууд, ахмадууд хамрагдсан байна. 2025 оны улсын төсөвт Эрдэнэцагаан сумын царцаагдсан спорт заалны барилгыг ашиглалтад оруулах саналыг | 100% |
| | 62 | | 1.5/. Тариалангийн талбайн хөрсний үржил шимийг хамгаалах, таримлын зохистой сэлгээг сонгон нэвтрүүлж, малын тэжээл болон бусад ашигт таримлын тариалалтыг нэмэгдүүлэх, рапсын тариалалтыг нийт тариалсан талбайн 15 хувиас хэтрүүлэхгүй байх зохион байгуулалтын арга хэмжээг авч | Аймгийн хэмжээнд 5 ААН, 2 иргэн 2110 га талбайд малын тэжээл тариалалт хийж өнгөрсөн оноос 184 га талбайгаар тариалалт нэмэгдсэн. Малын тэжээл- 2110 га Үр тариа- 3658 га Рапс 3220 га нийт 8988 га талбайд тариалалт хийсэн. Үүний 35 хувийг рапсын тариалалт эзэлж байна. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 28 | 63 | Засгийн газарт чиглэл өгөх тухай 2022-01-17 Дугаар 2022 №01 БОХХААБХ | 1.9/. Хүнсний хангамж, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор усны эх үүсвэр бүхий газарт төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, малын тэжээл, ашигт таримал тариалах, мод үржүүлгийн газар байгуулахад шинээр газар олгох асуудлыг судалж шийдвэрлэх, нийслэл хот, говийн бүсийн болон хүн ам төвлөрсөн томоохон суурин газруудыг түшиглэн өвөл, зуны хүлэмжийн цогцолбор аж ахуй, хадгалалт борлуулалтын цогцолбор төв байгуулахад урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох, хүлэмжид хэрэглэсэн цахилгааны хөнгөлөлтийн цагийн хугацааг уртасгах арга хэмжээг авч хэрэгжүүлэх; | Түмэнцогт сумын Хар ямаатын байгалийн нөөц газарт 40 га талбайд 58.000 суулгац, Хэрлэн гол дагуу 92 га-д 70.000 монос, Дарьганга сум 9850 ш Асгат, 100ш чацаргана, Уулбаян сум 100ш үхрийн нүд, Түвшинширээ 550ш, Онгон 58ш хайлаас, шар хуайс зэрэг мод тариалж жимс, жимсгэний модны тариалалтыг нэмэгдүүлэн ажилласан. байна. Энэ онд Баруун-Урт сумын 1 иргэн өвлийн хүлэмж ашиглалтанд оруулж цахилгааны төлбөр хөнгөлөлт үзүүлэх саналыг ХХААХҮЯ-нд хүргүүлсэн. | 70% |
| | 64 | | 1.1/. Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт чиглэл болгосугай: 1/ төслийн 1, 2 дугаар ээлжийн барилга угсралтын ажлын зургийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу баталгаажуулж, ажлын гүйцэтгэлийг хянан, тодорхой арга хэмжээ авч, ажлыг эрчимжүүлэх; | Наран сумын сургууль, дотуур байр, Халзан сумын сургууль болон дотуур байр, Эрдэнэцагаан сумын 2 дотуур байрын барилгууд зэрэг 6 байгууламж 1,2-р ээлжинд хамрагдаж Сайрын харгана ХХК ажлыг 100% гүйцэтгэсэн. 3-р ээлжийн 13 байгууламжийн ажлыг РСТ ХХК болон Модерн хас ХХК-ууд гүйцэтгэсэн. Эрдэнэцагаан, Дарьганга сумддын 4 байгууламжийг РСТ ХХК гүйцэтгэж комисс хүлээн авсан. Мөнххаан, Уулбаян, Түвшинширээ, Баяндэлгэр, Онгон 5 сумын 9 байгууламжийн ажлыг Модернхас ХХК гүйцэтгэж байна. Ажлын явц 95%. 4-р ээлжийн 5 байгууламжийн ажлын гүйцэтгэчээр РСТ ХХК шалгарч ажил эхлээд явж байна. | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 65 | "Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан | 1.2/. төслийн 3, 4 дүгээр ээлжийн барилга угсралтын ажлыг төлөвлөгөөт хугацаанд чанартай гүйцэтгэн дуусгаж, ашиглалтад оруулах ажлыг удирдан зохион байгуулах; | Сүхбаатар аймгийн хэмжээнд 3 багц ажил үргэлжилж байна. Дарьганга дотуур байр, цэцэрлэг, Эрдэнэцагаан сумын 1, 2 дугаар цэцэрлэгийн ариун цэврийн байгууламжийн ажлыг “РСТ” ХХК барилга шугам сүлжээ угсралтын ажлыг гүйцэтгэж Улсын комисс ажиллаж байнгын ашиглалтад оруулсан. Нэгдүгээр багц “Тоонот гранд” ХХК зураг төслөөр Мөнххаан сум сургууль, дотуур байр, Уулбаян сум сургууль, цэцэрлэг, Түвшинширээ сум бага сургуулийн нүхэн жорлонг ариун цэврийн байгууламжийн ажлыг “Модернхас” ХХК гүйцэтгэж энэ онд багтаан ашиглалтад оруулахаар ажиллаж байна. 3 дугаар багц Баяндэлгэр сумын ерөнхий боловсролын сургуулийн ариун цэврийн өрөөний заслын ажил, гадна ариутгах татуургын шугам сүлжээ угсралтын ажил, Цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын дотор засал дотор цахилгаан, дулуун хангамж халаах хэрэгслийн ажил. Онгон сум Цэцэрлэгийн ариун цэврийн байгууламжийн өргөтгөлийн барилгын ханын өрөгт бүтээц, хучилтын хавтангийн ажил, дотуур байрны дотор засал шугам сүлжээ угсралтын ажлыг “Модерхас” ХХК гүйцэтгэж байна. Орон нутгийн зүгээс төлөвлөгөөт хугацаанд чанартай дуусгах тал дээр гүйцэтгэгч компаниудтай хамтран ажиллаж байна. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 29 | 66 | авах арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2020 оны 39 дүгээр тогтоолын 1 дэх заалтын 5 дахь дэд заалтын хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай 2022-01-17 Дугаар 2022 №01 БСШУСБХ | 1.3/. төсөлд нэг маягийн зураг, төсөв ашиглах бол холболтын зураг төсөл, тухайлсан байршилд шинээр зураг төсөв боловсруулан гүйцэтгэхэд ажлын даалгавар, геологи, геодезийн дүгнэлт, байгаль орчны ерөнхий үнэлгээ, техникийн нөхцөлүүдийг хууль тогтомжийн дагуу шуурхай олгох, мэргэжлийн байгууллагаар хянагдан магадлалын дүгнэлтээр баталгаажуулсан ажлын иж бүрэн зураг, төсвийг холбогдох байгууллагад 2022 оны 02 сарын 15-ны дотор хүргүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд болон аймгийн засаг дарга нарт үүрэг болгох; | Баруун-Урт сум 640 хүүхдийн сургууль, 200 хүүхдийн цэцэрлэгийн барилгын зураг, Баяндэлгэр 150 ортой хүүхдийн цэцэрлэгийн барилга, Уулбаян сум 150 ортой хүүхдийн цэцэрлэгийн барилга, Түвшинширээ сум 320 суудалтай сургуулийн барилга, Онгон сум 300 хүний суудалтай соёлын төвийн барилга зэрэгт нэг маягийн холболтийн зургийг ашиглаж төсөл арга хэмжээнүүдийн ажлын зураг төслийг боловсруулан баталгаажсан. дээрх зураг төсвийн хүрээнд гүйцэтгэгч байгууллагууд шалгарч 2024 оны төсвийн хуулинд туссан хөрөнгө оруулалтыг гүйцэтгэл баталгаажсан. | 100% |
| | 67 | | 1.5/. тухайн орон нутагт хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн бүтээн байгуулалтын явцад хяналт тавьж, хариуцсан чиглэлээр үүрэг, зөвлөмж өгч ажиллахыг аймаг, нийслэлийн засаг дарга нарт үүрэг болгох; | Улс болон орон нутаг хувийн хөрөнгө хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй нийт 30 төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж ажиллаж байна. Хяналтаар нийт 45 удаа тухайн барилга байгууламжууд дээр очиж үүрэг даалгавар, газрын даргын 35 албан тоот бичгийг аж ахуй нэгжүүдэд хүргүүлэн ажилласан. Аж ахуй нэгжүүдээс ирүүлсэг явцын санхүүжилт гүйцэтгэлийн материалыг хянаж 25,4 тэрбум төгрөгний баталгаажуулж санхүүжилтийг олгогдсон. | 100% |
| | 68 | | 1.6/. Төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэлд аудит хийлгэн, аудитын дүгнэлтэд үндэслэн шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлэх. | 2023 онд Улсын төсвөөс эрх шилжин хэрэгжсэн барилга байгууламж, бүтээн байгуулалтын ажлуудад аймгийн төрийн аудитын газрын батласан төлөвлөгөөний дагуу аудитыг бүх барилга байгууламж хийлгэн нэгдсэн дүгнэлтийг хүлээн авсан. Дүгнэлтийн дагуу илэрсэн зөрчил дутагдлуудыг засаж сайжруулах шаардлагатай арга хэмжээнүүдийн талаар гүйцэтгэгч байгууллагуудад мэдэгдэл хүргүүлэн, шаардлагатай арга хэмжээнүүдийг тухай бүр авч албан шаардлага, дүгнэлтийг хариуг хугацаанд нь барагдуулсан. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 30 | 69 | Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай 2022-04-13 Дугаар 2022 №04 БОХХААБХ | 1.4/. Мал, амьтны гоц халдварт өвчний гаралт, тархалтыг таслан зогсоох зорилгоор отор, нүүдэл, шилжилт хөдөлгөөнд тавигдах мал эмнэлгийн болон бусад мэргэжлийн байгууллагуудын хяналтыг сайжруулах талаар онцгой арга хэмжээ авах, зарим эрсдэлтэй бүс нутгийн мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах, мал эмнэлгийн хорио цээрийн байнгын болон түр хяналтын цэгийг нэмэгдүүлж, мал эмнэлгийн нэгдсэн бүртгэлийг сайжруулах; | Мал эмнэлгийн нэгдсэн системийн гэрчилгээ бичилтэд сумдын болон аймгийн байцаагч нар хяналтыг өдөр тутам тавьж ажиллаж байна. Гадагшаа отор нүүдэл үржлийн чиглэлээр баталгаажуулсан болон зөвшөөрсөн төлөвтэй нийт 1614 гэрчилгээгээр адуу 8822, тэмээ 2, үхэр 683, хонь 616, ямаа 767 нийт 10890 малд гэрчилгээ олгосон байна. Гаднаас отор нүүдлээр 64 гэрчилгээгээр адуу 283, тэмээ 2, үхэр 93, хонь 49, ямаа 143 нийт 570 мал ирсэнг хүлээн авч мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулаад байна. 2024 онд малын гоц халдварт өвчнөөс шалтгаалсан хохирол гараагүй | 100% |
| | 70 | | 1.5/. Мал амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх арга хэмжээний хүрээнд Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль болон Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт үүрэгжүүлж, хуульд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд огцруулах хүртэл хариуцлага тооцох; | 2024 оны жилийн эхэнд "Удирдах ажилтны зөвлөгөөн" зохион байгуулж, сумдын засаг нарт холбогдох хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар чиглэл зөвлөмж өгсөн. Мөн шаардлагатай тухай бүрт үүрэг чиглэл өгч ажилласан ба холбогдох хуульд заасан үүргээ биелүүлээгүй буюу тухайн чиглэлээр зөрчил гаргасан Засаг дарга байхгүй болно. | 100% |
| | 71 | | 1.6/. Малын тоо толгойн албан татварын 50-аас доошгүй хувийг малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхэд зарцуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх; | 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын хүндрэлээр 1,8 сая мал хорогдож малчид хүнд байдалд орсон тул малын тоо толгойн албан татварыг авах нөхцөл бүрдээгүй ба улс орон нутгийн төсвөөс тухайн арга хэмжээнд хөрөнгө зарцуулж, малын халдварт өвчин гарах эрсдлээс сэргийлсэн. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 72 | | 1.7/. Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, мал эмнэлгийн байгууллагын чадавхийг бэхжүүлэх ажлын хүрээнд вакцин болон халдваргүйтгэлийн бодис, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нөөцийг бүрэн бүрдүүлэхэд шаардагдах хөрөнгийг улсын төсөвт тусгах; | Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 08-ны А/165 тоот тушаал, аймгийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 15-ны А/291 тоот захирамж, Мал эмнэлгийн газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А/14 тоот тушаалын дагуу Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх хаврын дархлаажуулалтыг зохион байгуулж ажилласан. Дархлаажуулалтад 55 ажлын хэсэгт удирдах ажилтан 54, малын их эмч 60, санитарч 17, туслах ажилтан 36, жолооч 52 нийт 224 хүний бүрэлдэхүүнтэйгээр 05 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн 07 дугаар сарын 20-ны хооронд аймгийн хэмжээнд 8149 өрхийн 173841 үхэр, 174 гахай нийт 174015 мал, амьтанг хамруулахаар төлөвлөсөн ба нийт 4480 хот айлын 160882 толгой үхэр, 142 гахай бүгд 161024 мал, амьтан хамруулан 92,5 хувийн гүйцэтгэлтэй дуусгаад байна. Санхүүжилт 161.0 сая төгрөгийг гүйцэтгэлээр нь мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд олгосон. Намрын дархлаажуулалтын арга хэмжээг 11 дүгээр сарын 19-нөөс эхлэн явц 97.9 %-тай хамруулж холбогдох тайлан, мэдээг МЭЕГ-т хүргүүлээд байна. | 100% |
| 31 | 73 | Чиглэл өгөх тухай 2022-06-07 Дугаар 2022 №14 НББХ | 1.6/. Улсын хэмжээнд сум бүрийг “Ахмадын өргөө”-тэй болгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, Ахмадын өргөөний урсгал зардал, тоног төхөөрөмжийг шийдвэрлэх, ажиллаж буй ахмадын урамшууллыг тухайн орон нутгийн төсөвт тусгаж, санхүүжүүлэх; | Аймгийн хэмжээнд 12 сумын ахмадын хөгжлийн төв, аймгийн Ахмадын ордон үйл ажиллагаа идэвхтэй явуулж байна. Аймгийн Засаг даргын 2021 оны 154 дүгээр захирамжаар 2021-2024 онд ахмадын талаар хэрэгжүүлэх 90 бүтээлч ажлын чиглэл, төлөвлөгөөг батлан, сум, холбогдох байгууллагуудад хүргүүлэн арга хэмжээг зохион байгуулж ажиллалаа. Орон нутгийн төсвөөс сумдын ахмадын хорооны үйл ажиллагааны зардлалд 7000,0-30000,0 мянган төгрөгийн зардлыг 2023, 2024 оны төсөвт тус тус тусгасан ба сум бүр ахмадын хөгжлийн төв болон ахмад настнуудад дэмжлэг үзүүлж хамтран ажиллаж байна. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 32 | 74 | Чиглэл өгөх тухай 2022-06-15 Дугаар 2022 №07 ҮББХ | 1.5. Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор малын тэжээл тариалах газрын асуудлыг шийдвэрлэх, зуны улиралд сүүний илүүдэлтэй аймгуудад сүү цуглуулах цэг болон боловсруулах үйлдвэрийг кластерын зарчмаар хөгжүүлэх, импортын хуурай сүүг орлох, хадгалалтын хугацаа урттай сүүн бүтээгдэхүүний үйлдвэрийг байгуулах, тоног төхөөрөмжийг шинэчлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх | 2024 онд тус аймгийн Үйлдвэрлэл технологийн паркад 1,9 тэрбум төгрөгийн өртөгтэй сүүний үйлдвэрийн барилга баригдсан. Энэхүү үйлдвэрийг ашиглалтанд оруулахаар НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллагаас 20.0 мянган доллор буюу 68.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн зардлыг санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн. Үлдэгдэл санхүүжилт болох 200.0 сая төгрөгийг аймгийн 2025 оны төсөвт суулгахаар санал оруулсан. Мөн аймгийн төвд сүүний үнээний ферм эрхлэгч хоршоодыг нэгтгэн дундын хоршоо байгуулах замаар сүүний үйлдвэрийн түүхий эд / шингэн сүү/-ийг нийлүүлэх талаар төлөвлөн ажиллаж байна. | 70% |
| 33 | 75 | Мал, махны бэлтгэн нийлүүлэлт, нөөц, экспортыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-01-17 Дугаар 2023 №02 БОХХААБХ | 1.2/. Итпортлогч улсын хорио уээрийн байгууллагаас тавьж байгаа шаардлагын дагуу хяналт шалгалтыг дотооддоо зохион байгуулж, мах махан бүтээгдэхүүн экспортлох эрх бүхий үйлдвэр, бүтээгдэхүүний тоо хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэх; | Мах бэлтгэн хэрэглэгчдэд нийлүүлдэг аж ахуй нэгжүүдэд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны салбарын хяналтын газрын салбарын ерөнхий байцаагчийн баталсан 08-00-02/29 дугаартай удирдамжийн дагуу мал төхөөрөх 2 объект, мах боловсруулах 1 объект, нийт 2 аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус шалгалт хийж 78 зөрчил илрүүлэн 56.0 хувийг газар дээр арилгуулан улсын ахлах байцаагийн 38 заалттай 2 албан шаардлага хүргүүлэн биелэлт 85 хувьтай байна. 2.Баруун-Урт сумын “Дарьт шүтээн “ХХК-ний “Баян тал “ махны үйлдвэр Иран улсад 2024 онд хонь 1500 тн, адуу 1100 тн бүгд 2600 тн мах экспортолсон. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 34 | 76 | Тусгай хамгаалалттай газар нутгийн хилийн цэсийн баталгаажуулалтын ажлыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-01-17 Дугаар 2023 №03 БОХХААБХ | 1.4/. Тусгай хамгаалалттай газар нутагт Нийслэл, дүүрэг, сумын Засаг даргын захирамжаар газар эзэмших, ашиглах эрх олгосон болон Нийслэлийн нутаг дэвсгэрт Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалаар газар эзэмших эрх олгосон асуудлыг хуульд нийцүүлэн шийдвэрлэж, газрын эрхийг гэрчилгээ олгох, гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах; | Тусгай хамгаалалттай газар нутагт газар эзэмших, ашиглах хүсэлт ирээгүй ба газар олгогдоогүй | Х.Б |
| | 77 | | 1.1.4/. асрамж, халамжийн төв, түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвд ажиллах орон тооны сэтгэл зүйч, дохионы хэлний хэлмэрч, сэтгэл засалчийг ажиллуулах, онлайнаар тус үйлчилгээг авах нөхцөлөөр хангах; | Аймгийн түр хамгаалах байранд мэргэжлийн сэтгэл зүйч ажиллаж байна. 2024 онд Түр хамгаалах байранд ирсэн 56 иргэнд үйлчилгээ үзүүлснээс насанд хүрэгч эмэгтэй – 12, эрэгтэй-2,, Хүүхэд-42 эрэгтэй-12, эмэгтэй -30 үүнээс үл хайхрагдсан -18, бие мах бодийн хүчирхийлэл- 16, Сэтгэл санааны хүчирхийлэл-17, Бэлгийн хүчирхийлэл-5 хүүхэд байна. Тэдгээр иргэдэд сэтгэл зүйн анхан шатны зөвлөгөөг өгч сэтгэл зүйн дүгнэлт гарган хамтарсан багтай хамтран ажиллаж байна | 70% |
| | 78 | | 1.1.9/. хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүүхдийн эрх, эрх чөлөөг зөрчихгүй байх, хүүхдээс мэдүүлэг авахад зориулж тусгайлан бэлтгэсэн өрөө бий болгох, хүүхдийн эрхийг хамгаалсан бодлогыг хэрэгжүүлж ажиллах, бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч хүүхдээс мэдүүлэг авахдаа хохирогчтой ижил хүйсийн байцаагч ажиллуулах; | Хэргийг мөрдөн шалгах явцад хүүхдийн эрх, эрх чөлөөг зөрчихгүй байх үүднээс мэдүүлэг авахад зориулж Цагдаагийн газар, Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газар тус бүрт хүүхдээс мэдүүлэг авах өрөөг тохижуулан хүүхдээс мэдүүлэг авч хүүхдийн эрхийг хамгаалсан бодлогыг хэрэгжүүлэн ажилласан. Бэлгийн хүчирхийллийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч болсон 6 хүүхдийн хэрэг шалгагдсан бөгөөд 2 хэрэг шүүхэд шилжиж шийдвэрлэгдэж 4 нь хэрэг бүртгэлийн ажиллагаа хийгдэж байна. Хохирогч хүүхдээс мэдүүлэг авахдаа ижил хүйсийн мөрдөн байцаагчийг Цагдаагийн газраас томилуулан ажиллаж байна. | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| 79 | 1.1.12/. “Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсэгт заасан байгууллага бүр хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлэх заалтын хэрэгжилтийг хангуулах хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас хүүхэд хамгааллын бодлого, түүний боловсруулалтын талаар зөвлөмж гаргаж байгууллагуудад хүргүүлэх. | 2024 оны жилийн эцсийн байдлаар хүүхдийн өрөөтэй байгууллага 71, хүүхэд хамгааллын бодлоготой байгууллага 76, дэргэдээ эцэг эхийн зөвлөлтэй байгууллага 98 болоод байна. "Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээ"-гээр "Хүүхэд хамгааллын тухай" хуулийн шинэчилсэн найруулгыг сурталчилан таниулах ажлын хүрээнд 7 сумын 81 байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлд хүрч ажилласан. Байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлөөр дамжуулан “Сэтгэлзүйч эцэг эх байя” нөхөрсөг уулзалтыг 18 хоногийн турш 3 удаагийн давтамжтай зохион байгууллаа. “Хүүхдээсээ суралцъя” видео бичлэгийг хийж олон нийтэд хүргэсэн. Мөн төрийн болон хувийн хэвшлийн 11 байгууллага сургалт зөвлөгөөнд хамтран ажиллаж, нийт 357 эцэг эх асран хамгаалагчдад хамрагдсан. ОУ-ын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр байгууллагын ажилтан, алба хаагчдын хүүхдүүдийг хүлээн авч баярын бэлэг, хөгжөөнт тэмцээн уралдаан зохион байгуулахаас гадна 35 байгууллага нь байгууллагынхаа гадна орчинд эрсдлийн үнэлгээ хийснээр 4 байгууллага эрсдлээ тодорхойлж, аюулгүй орчныг бүрдүүлэн ажилласан. Мөн албан байгууллага, аж ахуй нэгжийн дэргэдэх “Эцэг эхийн зөвлөл”-ийн үйл ажиллагааг | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 35 | 80 | Чиглэл өгөх тухай 2023-03-28 Дугаар 2023№05 НББХ | 1.2.1/. хүүхэд хөгжлийн чиг үүргийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих, Хүүхдийн номын сан, Хүүхэлдэйн театр, Хүүхдийн урлан бүтээх төвийн барилга байгууламжийг шинэчлэх зардлыг улсын төсөвт шат дараатай тусгаж, шийдвэрлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх, үйлчилгээг бүсчилсэн хэлбэрээр ажиллуулах, хүүхдийн хөгжил төлөвшилд хүрч үйлчлэх нөхцөл бүрдүүлэх; | 2024 онд улсын төсвийн хөрөнгөөр Онгон сумын Соёлын төвийн шинэ барилгыг барих тендерт Улаанбаатар хотын “Эс Жи Си” ХХК шалгарч барилгын суурийн цутгалт хашаажуулалтын ажил хийгдэж байна. Төсөвт өртөг 4,184.0 сая үүнээс тайлант хугацаанд 1,225.2 сая төгрөгийг зарцуулсан байна. Мөн фургон авто машин 67.0 сая, 8 ханатай гэр болон тавилга 23.5 сая, салбарын 15 байгууллагад нийт 168.8 сая төгрөгийн морин хуур 6 , зөөврийн болон суурин компьютер нийт 32, зургийн аппарат 1, заалны сандал 240, даралтат хөгжим 3, хурдан сканер 9, принтер 8, утааны аппарат 1 ширхэг нийт 168.8 сая буюу нийт 1,484.5 сая төгрөг, аймаг орон нутгийн хөрөнгөөр Түмэнцогт сумын дээврийн засвар 45.2 сая, ХЖТеатр, Онгон, Баяндэлгэр, Түмэнцогт сумын Соёлын төвийн зураг төсвийн шинэчлэхэд 103.4 сая төг, ХЖТеатрт 76.5 сая төгрөгийн тоног төхөөрөмж, Халзан сумын соёлын төв лед дэлгэц 40,7 сая буюу нийт 265.8 сая төгрөгийн хөрөнгө оруулал , сумдын Засаг даргын нөөц хөрөнгө, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Сүхбаатар сум орон нутгийн судлах музейн засварт 332.0 сая, Уулбаян, Түмэнцогт, Баяндэлгэр, Эрдэнэцагаан сумын соёлын төвийн лед дэлгэц 103.3 | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| 81 | 1.2.2/. цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдийн нэр төр, алдар хүндэд халдах, гутаан доромжлох, залилах, хүчирхийлэлд уриалах, садар самуун явдлыг сурталчлах зэрэг гэмт хэрэг, зөрчлийн үйлдлүүдийг таслан зогсоох, хууль бус үйл ажиллагаатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг нэн яаралтай авах; | “Цахим хэрэглээг зөв болгоё" Урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээний хүрээнд Баруун-Урт сумын Ерөнхий боловсролын сургууль, МСҮТ, Боловсрол-Өргөө нэгдсэн дотуур байрны 300 гаруй хүүхдүүдэд сургалт зохион байгуулж, BBS телевиз, цахим болон пэйж хуудсаар дамжуулан 10 шторк, 25 постер зөвлөмж, сэрэмжлүүлгийг үүрэг хүлээгч олон нийтэд түгээж ажилласан. Гэнэтийн, болзошгүй аюул, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Сүхбаатар аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, Сүхбаатар аймгийн Онцгой байдлын газар зэрэг төрийн байгууллагуудтай хамтарч эргүүл шалгалт зохион байгуулах олон нийтийн мэдээллийн хэрэгсэл телевиз, фейсбүүк зэрэг олон нийтийн цахим сүлжээгээр урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, хамтарсан 7 удаа 54 цагийн эргүүл шалгалт, 7 удаа тус орон нутгийн BBS телевиз, SB телевиз, Сүхбаатар инфо сайт зэргээр мэдээ мэдээлэл түгээж 10500 хандалт авч, Сүхбаатар аймгийн цагдаагийн газар, Сүхбаатар аймгийн Хүүхэд, гэр бүл хөгжил хамгааллын газрын цахим хуудсуудаар тус аймгийн 75 фейсбүүк хаягаар мэдээ мэдээллийг тараан ажилласан. Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулж буй ажил, арга | 100% |
| 82 | 1.2.4/. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2016-2022 оны санхүүгийн тайланд аудит хийлгэх, жил бүр хөндлөнгийн хяналт оруулах; | Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу тухайн газрын санхүүгийн тайлангийн аудит жил бүр хийгддэг бөгөөд 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын зөвлөмж болон түүний мөрөөр хийж хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг ил тод байдлын самбарт байршуулан нийтэд ил тод байдлаар хүргэсэн. Мөн Үндэсний аудитын газраас 2019-2023 оны тайлант хугацааг хамруулан "Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн"-д гүйцэтгэлийн аудит хийгдсэн. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 83 | | 1.2.6/. Хүүхдийн эрхийн байцаагчийн чиг үүргийг боловсронгуй болгох, нийгэмд таниулах ажлыг эхлүүлэх. | Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн албан тушаалын тодорхойлолтийг батлуулан тодорхойлолтод заасан шаардлагын дагуу хүүхдийн эрхийн улсын байцаагчийг томилон ажиллуулж байна. “Соёл, спорт олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах журам”-ын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Соёлын газар, Биеийн тамир спортын газарт зөвлөмжийг хүргүүлж ажилласан ба нийт багш, дасгалжуулагчдад танилцуулга сургалтыг зохион байгуулсан. | 100% |
| 36 | 84 | Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай 2023-04-25 Дугаар 2023№05 ТБХ | 6в/. төсвийн үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор төсөв боловсруулах үе шатанд олон нийтийн оролцоог хангах аргуудыг туршилтын журмаар нэвтрүүлэх, Төсвийн ил тод байдлын олон улсын санаачилга /С1оЬа1 1пШайуе Тог Е\|вса1 Тгалзрагелсу/ байгууллагаас гаргасан төсвийн бодлого боловсруулахад олон нийтийн оролцоог хангах зарчмуудыг нэвтрүүлэх, мэдээлэл, харилцаа холбооны олон сувгаар дамжуулан төсвийн төслийн талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх, тэдний санал бодлоо илэрхийлэх боломжийг олгох; | Швейцарын хөгжлийн агентлаг болон Нийгмийн эгэх хариуцлагын дэлхийн түншлэлийн санхүүжилтээр Дэлхийн банкны хэрэгжүүлж буй “ Монгол Улсад ил тод байдал, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхэд нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх нь “ буюу МАСАМ-2 төслийн хүрээнд аймгийн “Иргэдийн төсөв-2023” эмхэтгэлийг 2023 оны 2 сард боловсруулан гаргаж, олон нийтийн хэвлэл мэдээллийн сайтуудад байршуулсан. 2024 оны төсвийн мэдээллийг шилэн данс, байгууллагын мэдээллийн самбар, аймгийн албан ёсны цахим сайтуудад тухай бүр байршуулан ажиллаж байна. 2025 оны төсөвтэй холбоотойгоор иргэдээс цахимаар асуулга, судалгаа авсан ба  сум баг бүрт иргэдийн санал авч төсөл арга хэмжээг эрэмбэлэх ажлуудыг хийсэн. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 85 | | 6г/. төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хяналтын бүх үе шатанд мэргэжлийн судлаачид, мэргэжлийн төрийн бус болон судалгааны байгууллагуудтай хамтран ажиллах. | Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд аймгийн 2023 оны төсвийн төслийг боловсруулан саналаа Төрийн аудитын газарт хүргүүлж, дүгнэлт зөвлөмжийг тусган аймгийн ИТХурлаар хэлэлцүүлэн батлуулсан. - Төсвийн ил тод байдлыг хангах, иргэдэд төсвийг нээлттэй мэдээлэх, ингэснээр төсөвт иргэдийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлэх чиглэлээр " Монгол Улсад ил тод байдал, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхэд нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх нь " буюу МАСАМ-2 төслийн хүрээнд Глоб Интернэшнл төв ТББайгууллагатай хамтран 2023 оны 2 сард "Иргэдийн төсөв-2023" эмхэтгэлийг боловсруулан гаргаж, мэдээллийг албаны цахим сайтуудад байршуулсан. | 100% |
| 37 | 86 | Засгийн газарт чиглэл өгөх тухай (ЁЗСХБХ) 2023-11-01 Дугаар 2023_10 | 1.4. Иргэн төрийн албанд анх ороход тавих ёс зүйн шаардлагыг өндөрсгөх, ёс зүйн зөрчил гаргаж байсан хүнийг төрийн жинхэнэ албанд томилохгүй, албан тушаал дэвшүүлэхгүй байх зарчмыг хатуу мөрдөх; | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн дагуу ёс зүйн зөрчилтэй албан хаагчийг томилохгүй байх талаар сургалт, зөвлөгөөг нийт төрийн байгууллагын удирдлага болон албан хаагчдад өгөн ажиллаж байна. тухайн заалтыг зөрчсөн тохиолдол гараагүй | 100% |
| Ерөнхийлөгчийн зарлиг | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 38 | 87 | Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх туай 2018-05-23 Дугаар 2018_46 | 3.. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай. | Аймгийн Засаг даргын орлогч, хэлний бодлогын салбар зөвлөлийн даргын 2024.02.16 02/174 дүгээр албан тоотоор сумдын Засаг дарга , албан байгууллагуудын дарга нарт 7 үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хэвшүүлж ажиллахаар чиглэл,Аймгийн Засаг даргын 04 тоот албан даалгавараар монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх стандартуудыг хэрэгжүүлэх талаарх албан даалгавар гарч холбогдох бүх байгууллагуудыг архив албан хэрэг хөтлөлтөө хос бичгээр хөтлөхийг үүрэгжүүлсэн. аймгийн Хэлний бодлогын зөвлөлөөс “Хос бичигтэн байгууллага” уралдааныг 2024.03-9 дүгээр сард, удирдах ажилтнуудын манлайлах чадварыг дээшлүүлэх хүрээнд “Уламжлалт бичиг удирдлагын манлайлал” сургалтын 2024 оны 3-5 дугаар сард, , албан байгууллагуудын дунд 7 дахь жилдээ “ХҮМҮҮН БИЧИГ-ХҮН БҮРИЙН БИЧИГ” тэмцээн, Сумдын хэлний бодлогын салбар зөвлөлийн анхдугаар зөвлөгөөн, Жаахан шаргын нутаг” "ЖААХАН ШАРГЫН НУТАГ" МОНГОЛ БИЧГИЙН Бүсийн УРАЛДААн, Монгол бичгийг дээдлэгч багш нарыг урамшуулах ажлуудыг тус тус зохион байгуулан 1500 төрийн албан хаагч, иргэдийг оролцуулан зохион байгуулан 13.5 сая төгрөгийн | 100% |
| 39 | 88 | Засгийн газарт чиглэл өгөх тухай 2019-05-30 Дугаар 2019_104 | 1.16.. Ерөнхий боловсролын сургууль, их дээд сургуулиудын ойр орчмын түргэн хоолны болон түргэн үйлчилгээний цэгт хяналт тавих | Сүхбаатар аймгийн эрүүл мэндийн газрын хяналт шалгалтын хэлтсийн даргын баталсан удирдамжийн дагуу Баруун-Урт сумын ерөнхий боловсролын сургуулийн орчинд үйл ажиллагаа явуулж буй хүнсний худалдаа, үйлчилгээний байгууллагуудад худалдаалагдаж буй хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус шалгалтыг хамран зохион байгууллаа. Шалгалтаар нийт худалдааны 8 газар, хоол үйлдвэрлэлийн 2 газар хамрагдаж мэргэжил арга зүйн зөвлөгөө зөвлөмж өгсөн. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 89 | | 1.2. Жил бүр Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хувиас доошгүй хөрөнгийг уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг үйл ажиллагаанд зарцуулах, улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын тодорхой хувийг байгальд ээлтэй, стандарт бүхий ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд зориулах эрх зүйн орчинг бүрдүүлж, холбогдох шийдвэр гаргах<br><br>Тайлбар: Тайланд хийсэн ХШҮ-ний дагуу энэхүү заалтыг иргүүлэхдээ дараах зүйлийг анхаарна уу: Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хувиас доошгүй хөрөнгийг уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг үйл | АДАПТ төсөл 70%, ОНТ 30%-ийн санхүүжилтээр Дарьганга суманд 30 га-д татмын ойжуулалтын ажилд 315.0 сая төгрөг, -Түмэнцогт суманд 20 га-д татмын ойжуулалтын ажилд 322.0 сая төгрөг Түмэнцогт суманд 92 га-д 1.0 тэрбум төгрөгний хөрөнгө оруулалт хийсэн ба ажлын даалгаврын дагуу ойжуулалт, хашаажуулалт, усалгааны ажил бүрэн хийгдсэн. | 70% |
| | 90 | | 1.6. Дүүрэг, сумдад ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулж, иргэдэд мод тарих соёлыг сурталчлан түгээж бүх нийтийн үйлс болгох | Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Урт гол дагуу байгуулагдаж байгаа Соёл амралтын хүрээлэнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 9га талбайд, 18000 ширхэг мод, Мөн Баруун урт суманд байгуулагдаж байгаа Талын Наран цэцэрлэгт хүрээлэнд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 11 төрлийн 6032 ширхэг мод суулгацыг тарьж тохижилтын ажил явагдаж байна. Жил бүрийн намар, хавар бүх нийтээр мод тарих өдрийг аймгийн хэмжээнд зохион байгуулж, байгууллага, иргэдэд хөнгөлөлттэй үнээр мод худалдаалж, тариалах ажлыг тогтмол зохион байгуулж хэвшсэн. Мөн иргэдэд жимсний мод тариалах сургалт сурталчилгаа хийж, суулгац нийлүүлэх ажил хийсэн. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 40 | 91 | Засгийн газарт чиглэл өгөх тухай /Тэрбум мод/ 2021-10-04 Дугаар 2021_58 | 1.7. Мод тарьж ургуулахад шаардагдах усны нөөцийг бүрдүүлэх, ялангуяа гадаргын усыг говийн бүс нутагруу шилжүүлэх, хөв цөөрөм байгуулах, усалгааны хэмнэлттэй дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх зэрэг арга хэмжээний төсөв, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг нэмэгдүүлж, зохион байгуулах арга хэмжээ авах | Аймаг нь тал хээрийн бүсэд оршдог газарзүйн онцлогтой учраас гадаргын ус багатай ба мод тарьж ургуулахад шаардагдах усыг худгийн усаар ихэвчлэн шийдвэрлэж байна. Дарьганга сумын Ганга нуурын татамд 30 га талбайд 24.000 мод тарьж татмын ойжуулалт хийсэн ба 5151 м хашаа хамгаалалт хийж хашаан дотор гүний гудаг, 50тн-ийн ёмкост, усалгааны системийг 30га талбайг бүрэн хамруулж шийдсэн. Тус ажлыг Гранд форест ХХК 315.0 сая төгрөгөөр гүйцэтгэсэн.Баруун-Урт ойжуулалт, жимс жимсгэнэ үржүүлгийн төвд Орон нутгийн төсвөөр усалгааны хэмнэлттэй дэвшилтэт технилоги бүхий дуслын усалгааны системийг нэвтрүүлж нийт 3 га талбайд услалтын асуудлыг шийдсэн. Энэ онд Баруун урт суманд Жимс жимсгэнэ үржүүлгийн төвийн 5 га, төмс хүнсний ногооны 2 га талбайд намираа услалтын системийг байршуулж усыг хэмнэлттэй зарцуулах технологийг ашиглаж байна. | 70% |
| | 92 | | 1.8. Байгалийн бүс, бүслүүрийн хөрс, цаг агаарын онцлогт тохируулан мод тарьж ургуулах арга, орчин үеийн техник технологийг нэвтрүүлж, нэгдсэн зөвлөмжийг боловсруулан хэрэгжүүлэх, хот, суурин газрын ногоон байгууламжийг хот байгуулалтын нэгдсэн төлөвлөлттэй уялдуулан бие даасан салбар болгон хөгжүүлэх | Тэрбум мод үндэсний хөдөлгөөний 1-р үе буюу бэлтгэл үе шат 2024 онд дуусаж энэ онд аймгийн хэмжээнд 397613 модыг тарьж 90 хувьтай ургуулж байна. Мөн мод үржүүлгийн газруудын борлуулалт сайжирч 5 аж ахуй нэгж байгууллагад 17-н төрлийн 111189 ширхэг тарьц суулгацыг өөрийн аймгийн хөрсөнд ургуулж ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд бэлэн болоод байна. Аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд ногоон байгууламж цэцэрлэг хүрээлэнгийн газрууд төлөвлөгдсөн | 70% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 93 | | 2. Энэ зарлигийг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай оролцож, эх байгалиа хайрлан хамгаалах, мод тарьж ургуулах үйлсэд бодит хувь нэмэр оруулахыг иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудад уриалсугай. | Сүхбаатар аймаг “ Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэж 2022-2030 онд 10 сая мод тарих гэрээ байгуулсан. 10 сая модыг тарих хуваарийг сум бүр, аж ахуйн нэгж, иргэдийн тарих модны хуваарийг сурталчлах ажлыг BBS телевизтэй гэрээ байгуулан ажилласан. 5,10-р сард 20 удаа шторкоор хүргэсэн.Мөн тарьц суулгацын үзэсгэлэн худалдааг “ УСАЛЪЯ, АРЧИЛЪЯ, ХАМГААЛЪЯ “ уриаΗы дор аймгийн хэмжээнд 2 удаа зохион байгуулж орон нутгийн 7 ААНБ, Дорнод, Дорноговь аймгийн сум дундын ойн ангиас ирж оролцсон.Үзэсгэлэн худалдаанд нийт 10 төрлийн 180000 мянга тарьц суулгац худалдаанд оролцсоноос 100000 мянга нь мод худалдаалагдаж 800 зуун сая төгрөгийн борлуулалт хийгдсэн. Бүх нийтээр мод тарих аяныг аймгийн хэмжээнд 2 удаа зохион байгуулахад 177 ААНБ-ын 8362 иргэн оролцож 10 төрлийн 397613 мянган мод тарьж, модны ургалт 85 хувьтай байна. Дээрх ажилд нийт ОНТ, БХНСАХЗ –аас 687,0 сая төгрөг, иргэн, ААНБ-аас 702,0 сая төгрөгийг тус тус зарцуулагдсан байна. Нийтийн эзэмшлийн талбайд мод тарих, арчлан хамгаалах ажилд ХХҮГ-аас аймгийн хэмжээнд 260 иргэнийг түр ажлын байраар / ногоон ажлын байраар / хангаж 73631 ш мод тарьсан байна. -БУ-т сумын 1-р багийн | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 41 | 94 | Засгийн газарт чиглэл өгөх тухай 2022-04-05 Дугаар 2022_43 | 1.8. Иргэд, хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх, биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлэхэд зохион байгуулалт, хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, байгууллагуудыг дэмжин хамтран ажиллах; | ил бүрийн 3-6 сар, 9-10 сарын бямба гаригийн өглөөний 07 цагаас төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, хүүхэд, залуучууд, иргэд хөдөлмөрчдийг идэвхтэй дасгал хөдөлгөөнийг дэмжих зорилгоор 10 дахь жилдээ зохион байгуулсан. Энэ онд “Илүүдэл жингүй-Эртэч Сүхбаатарчууд” уриан дор бүх нийтийн зохион байгуулж төрийн болон төрийн бус 68 байгууллагын давхардсан тоогоор 9568 иргэд хөдөлмөрчид хамрагдлаа. “Банк-100”, “Баруун-Урт марафон” бүх нийтийн кросс гүйлтэд нийт 251 иргэд оролцсон. Дугуй сонирхогчдыг дэмжих, хүүхэд залуучууд, иргэдийн дунд дугуй унах сонирхлыг төрүүлэх ба стресс ядаргаа тайлах, зүрх, уушигны ажиллагаа сайжрах, чихрийн шижин, цусны даралт нэмэгдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор "Дугуйн фөстивал-2024" арга хэмжээг Баруун-Урт сумын ЗДТГ, ИТХ, аймгийн БТСГ, “Уртын гэгээ” ОНӨҮГ, “Шилийн богд” дугуйн клуб, BBS телевиз хамтран зохион байгуулсан. Тус арга хэмжээнд: Байгууллага, аж ахуй нэгж, сонирхогчдын дугуйн парад Дугуйн худалдаа, солилцоо, засвар үйлчилгээ Дугуйн "Шилийн богд" клубын танилцуулга Нас бол тоо” зурагт үзэсгэлэн зэрэг зохион байгуулагдаж 150 хүн хамрагдсан. Мэргэшсэн туршлагатай багш | 100% |
| 42 | 95 | Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай | 2. Төрийн бүх байгууллага, Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газар, бүх шатны сургалтын байгууллагууд Эзэн Богд Чингис хааны эш хөргийг дээдлэн залсугай. | Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу төрийн байгууллагууд ЕБС, СӨБ-ын байгууллагууд болон хувийн хэвшлийн байгууллагууд Чингис хааны эш хөргийг дээдлэн залсан. | 100% |
| | 96 | | 3. Монгол хүн, айл өрх бүр Эзэн Богд Чингис хааны эш хөргийг эрхэмлэн залж, дээдлэн шүтэж байхыг уриалсугай. | Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу Ойл өрх бүр Эзэн Богд Чингис хааны эш хөргийг эрхэмлэн залж, дээдлэн шүтэж байхыг уриалсан нэвтрүүлэг, мэдээ мэдээлэлийг хэвлэл мэдээллийн бүх сувгийг ашиглан бэлтгэн хүргүүлж байна. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 97 | 2022-07-11 Дугаар 2022_159 | 4. Монгол хүн бүр Их Монгол Улсын гал голомтыг сахиж буйгаа гүнээ ухамсарлан, Эзэн Богд Чингис хааны суу алдар, үйл хэрэг, билиг сургаалыг эрхэмлэн дээдэлж, даган мөрдөж, төрт ёсны үнэт зүйл, өв соёлыг үр хойчдоо өвлүүлэн үлдээж, эв ээ сахин бататгаж, улс орноо мандуулахад хувь нэмрээ оруулахыг уриалсугай. | Монгол хүн бүр Их Монгол Улсын гал голомтыг сахиж буйгаа гүнээ ухамсарлан, Эзэн Богд Чингис хааны суу алдар, үйл хэрэг, билиг сургаалыг эрхэмлэн дээдэлж, даган мөрдөж, төрт ёсны үнэт зүйл, өв соёлыг үр хойчдоо өвлүүлэн үлдээж, эв ээ сахин бататгаж, улс орноо мандуулахад хувь нэмрээ оруулахыг иргэн бүрт хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад эх сурвалжаар уриалж ажилласан. | 100% |
| ҮАБЗ-ийн зөвлөмж | | | | | |
| 43 | 98 | Газар хөдлөлтийн гамшгаас сэргийлэх тухай 2010-03-18 Дугаар 2010_10/09 | 1. Хот, суурингуудад ашиглахыг хориглосон болон эрүүл ахуй, чанар, аюулгүй байдлын шаардлага хангаагүй барилга, байгууламжуудыг дахин төлөвлөж, олон улсын стандартын дагуу шинэчлэх, | Улсын байцаагчийн дүгнэлтээр эрүүл ахуй, чанар аюулгүй байдал хангахгүй дүгнэлт гарсан Түвшинширээ сумын дотуур байрны барилга, Халзан сумын эрүүл мэндийн төвийн хуучин барилгыг буулгах шийдвэрийг аймгийн иргэдийн хурлаар хэлэлцүүлэн өмч бүртгэлээс хасах тогтоол шийдвэрийг гаргуулаад байна. тус 2 барилгын буулгаж чөлөөлсөн газар дээр Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барилга байгууламж барих хөрөнгө батлагдаж гэрээ байгуулагдан шинэ барилга угсралтын ажлууд эхэлсэн | 100% |
| | 99 | | 3. Газар хөдлөлтийн аюул, гамшиггай тэмцэх мэдлэг чадвар, дадал эзэмшүүлэх иргэний хамгаалалтын сургалт, дадлагыг улсын хэмжээнд байнга, тоггмол давтамжтайгаар зохион байгуулах, үр дүнг нь тооодог байх, | 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 16:00 цагт Улс орон даяар “Зарлан мэдээлэл”-ийн дуут дохио дамжуулж ажилласан бөгөөд тус аймгийн гамшгаас хамгаалах алба, тусгай болон ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийн нийт 756 хүн, төрийн болон тусгайлсан чиг үүрэг бүхий 5 байгууллагын 184 хүн, 42 аж ахуйн нэгж, байгууллагын 2554 иргэд, олон нийтийг хамруулсан 956 иргэн тухайн сум, баг, хорооны аюулгүй талбайд тус тус гарч нэгдсэн арга хэмжээнд нийт 4492 иргэн 34 автомашин, техник хамрагдсан. Онцгой байдлын газраас 59 алба хаагч, дуут дохиот 3 автомашинтай иргэдэд мэдээлэл хүргэн ажилласан. Тус дадлага сургуулилтад боловсролын 41 байгууллагыг хамруулсан. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 44 | 100 | Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай 2018-02-05 Дугаар 2018_06/05 | 1.9. Хяналтгүйгээр худалдаалж байгаа ахуйн хэрэглээний хийг тусгай зөвшөөрөл бүхий хүнсний дэлгүүр, аж ахуйн нэгжээр дамжуулан худалдаалах болон ахуйн хэрэглээний хийг насанд хүрээгүй хүүхдэд худалдаалахыг хориглох шийдвэр гаргаж, хэрэгжүүлэх. | Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн 13, хувийн 3 эмнэлэг, Төрийн 12, хувийн 20 эмийн санд хяналт шалгалт хийж бүртгэл судалгаанд авч, хяналт шалгалт хийж, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хэрэглээнд хяналт тавин тайланг сар, улирал бүрээр авч ажилласнаар энэ төрлийн гэмт хэрэг, зөрчил бүртгэгдэн шалгагдаагүй. ЦЕГ-ын Хар тамхитай тэмцэх газар Боловсролын ерөнхий газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран #АНЗААР арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулсан. Арга хэмжээний хүрээнд 2024 оны 03 сарын 15-ны өдөр төрийн байгууллагын 67 албан хаагчид, ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 350 сурагчдад "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх урьдчилан сэргийлэх, хэрэг бүртгэх, мөрдөн шалгах ажиллагаанд анхаарах" сэдвээр сургалт, мэдээллийн ажлыг зохион байгуулсан ажил арга хэмжээ хийгдсэн. | 70% |
| 45 | 101 | Усны нөөцийг хамгаалах, хомсдлоос сэргийлэх, усны чанар, аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай 2019-12-31 Дугаар 2019_60/40 | 2.6. УБ хотын цэвэрлэх байгууламжийн шинэчлэлийн ажлыг эрчимжүүлж, гэр хороолол, аймаг сумын төвүүдэд дэвшилтэт технологи бүхий хэсэгчилсэн, зардал багатай ариун цэврийн байгууламжуудын шийдлийг туршин нэвтрүүлж, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг сайжруулах, холбогдох стандартыг мөрдүүлэх | Усны энгийн болон эрүүл ахуйн хамгаалалтын бүсэд байгаа Эко жорлонгийн тоо судалгаа гаргаж, тэдгээрт мэдээлэл хүргэж ажиллах талаар, эко жорлон үйлдвэрлэгч аж ахуйн нэгж байгууллагын мэдээлэл танилцуулга бэлтгэж 2024 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 101 дугаар албан бичгийг 13 суманд хүргүүлсэн. Аймгийн хэмжээнд нүхэн жорлонтой айл өрхийн тоог сумдаар нь гаргаж нийт 9000 орчим өрх, 120 ААНБ нүхэн жорлонтой, Усан сан бүхий газрын эргээс 200м, Ус хангамжийн эх үүсвэрийн 100м дотор нүхэн жорлонтой айл өрх 350, ААНБ-10 гэсэн судалгааг гаргаад байна. Тус онд Айл өрх, ААНБ-ын оролцоотой Сүхбаатар -7, Эрдэнэцагаан-9, Халзан-2, Түмэнцогт-1, Түвшинширээ-6, Дарьганга-38, Баруун-Урт-112, Асгат-2, Онгон 3 ш, Уулбаян -1, Мөнххаан-1ш 182 эко ариун цэврийн байгууламжийг нэмэгдүүлсэн бөгөөд 3 суманд улсын төсвийн 2 тэрбум төгрөгөөр сургууль цэцэрлэгийн ариун цэврийн байгууламжийг эко болгосон. Айл өрх ААНБ өөрсдийн хөрөнгөөр 113.9 сая төгрөгөөр эко ариун цэврийн байгууламжийг бий болгосон байна. | 70% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 102 | | 2.7. Усны хэмнэлттэй хэрэглээг төлөвлшүүлж, ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх зохистой менежментийг явуулах, үйлдвэрлэлийн хаягдал бохир усыг дэвшилтэт технологиор цэвэрлэж дахин ашиглахыг бодлогоор дэмжих | Цайрт минерал ХХК нь үйлдвэрийн усыг эргүүлэн 70-80 хувийг үйлдвэрлэл болон зам талбайн тоосжилт дарахад, ахуйн бохир усыг 2 шатлалаар биологийн аргаар цэвэрлэн, цэвэрлэгдсэн усыг био цөөрмөөс насосоор соруулан уурхайн ногоон байгууламжийн усалгаанд ашиглаж байна. | 70% |
| 46 | 103 | "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг зохион байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2021-09-30 Дугаар 2021_03 | 3.5. Байгаль орчноо хайрлан хамгаалах, зохицон амьдрах, монгол зан заншлыг дээдлэх, уур амьсгалын нөлөөллийг бууруулах, ой мод, усны нөөцийг хамгаалах, экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор экологийн боловсролыг бүх шатны боловсролын байгууллага болон хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан бүх нийтийг соён гэгээрүүлэх арга хэмжээ авах. | Аймгийн зүгээс МБС-ийг мэргэжлийн багшаар хангах зорилгоор сургалтын төлбөрийн 7.0 сая төгрийн дэмжлэг үзүүлж мэргэжлийн багштай болсон. МБС-д 2023-2024 оны хичээлийн жилд Ойжуулагч мэргэжлээр 24 төгсөгчийг бэлтгэн төгсгөж, 2024-2025 оны хичээлийн жилд тус мэргэжлээр 15 суралцагч элсэн суралцаж байна. 2023 онд үндэсний сургагч багшаар 13 сумын 35 иргэнийг бэлтгэж, тайлант онд сургагч багш нар зөвлөн туслах үйлчилгээгээ хүргэсэн. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Боловсролын яамтай хамтран зохион байгуулж буй "УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ БА МОНГОЛ" хамтарсан сургалт үйл ажиллагаа ахлах, дунд ангийн сурагчдад зохион байгуулсан. Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, ой усны нөөцийг нэмэгдүүлэх, экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн орон даяар өрнөж байгаатай холбогдуулан хүүхэд багачуудад сурталчлан таниулах, олон нийтийг мод тарих үйлсэд уриалах зорилгоор "Би мод тарьж байна" дууг ЕБС-ийн бага, дунд ангийн суралцагчид болон цэцэрлэгийн хүүхдүүдэд зааж сургалаа.<br>“Мод тарьж ургуулах арга, дэвшилтэт технологи”-ийн талаар ХААИС-д туршлага | 100% |
| | 104 | | 3.4.□Тариалангийн зориулалттай газар ашиглалтыг сайжруулах, талбайн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор шинээр 200.0 мянган га атар газар олгох ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах; | Сүхбаатар, Дарьганга сумдад тэжээлийн ургамал тариалах 2 хоршоонд 5 хүртлэх га атар газрыг олгосон. Аймгийн хэмжээнд 50 хувиас дээш ургамлын бүрхэвчтэй атаршсан газар 903,827 га талбай байна. | 70% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 47 | 105 | Хүнсний аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-05-02 Дугаар 2022_01 | 3.8.. Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг бүсчлэн, кластераар хөгжүүлэх, хот суурин, газар тариалангийн бүс нутагт эрчимжсэн мал аж ахуйг эрхлэх, түүхий эд бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоог бүрдүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх; | Эрчимжсэн аж ахуй эрхлэгч 3 аж ахуй нэгжид ЖДҮ-ийг дэмжих сангаас 567,5 сая төгрөгийн зээлийг олгож үйл ажиллагааг нь дэмжсэн байна. Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд 153 малчин хоршоологч эрчимжсэн аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар 2,5 тэрбум төгрөгийн зээл авсан байна. | 70% |
| | 106 | | 3.10.. Хоол, хүнсний зөв, зохистой, соёлтой хэрэглээний талаарх сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг улс орон даяар зохион байгуулах | Хоол үйлдвэрлэлийн салбарт эрүүл ахуйн зохистой дадал нэвтрүүлэх нь" сургалт , Орон нутгийн бренд хоол , идээ, ундааны үзэсгэлэн, "Аймгийн аварга тогооч шалгаруулах уралдаан", спортын бүсчилсэн арга хэмжээ зохион байгуулсан. Тус арга хэмжээнд 13 сумын сургууль, цэцэрлэг, эмнэлэг, цэргийн анги, МСҮТ-ийн оюутан тогооч, ресторан, зоогийн газар, талх нарийн боов үйлдвэрлэгч, ЕБС, СӨБ-ийн хоол зүйч, Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтнүүд оролцсон.<br>Хоол, хүнсний зөв зохистой хэрэглээ, хүнсний аюулгүй байдал, Эрүүл хооллолтын сургалт сурталчилгааг 30 гаруй ААНБ-дад зохион байгуулж 7800 иргэд, ажилчид хамрагдсан. Эхийн сүүгээр хооллох, нэмэгдэл хооллолтод цагт нь оруулах, жирэмсэн хөхүүл эхийн хооллолт, ОНБТБэлдмэл хэрэглэх ач холбогдол ганцаарчилсан зөвлөгөө мэдээллийг 2799 бага насны хүүхэдтэй эцэг эх, жирэмсэн, хөхүүл эхчүүдэд 3 удаагийн давтамжтай зохион байгуулж, Бага насны хүүхдийн цогц хөгжил сургалтын хүрээнд Нялх, балчир насны хүүхдийн хооллолт сургалтыг 1451 эцэг эх, асран хамгаалагчдад хүргэн ажилласан. Давхардсан тоогоор 538 Хоол хүнс үйлдвэрлэгчид, хүнсний худалдаа эрхлэгчид, тогооч нарт Хүнсний аюулгүй | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 48 | 107 | Ашигт малтмалын тусгаи зөвшөөрлиин өнөөгиин баидал цаашид хэрэгжүүлэх арга хэмжээнии тухаи 2022-11-25 Дугаар 2022_03 | 1.3 . Үндэснии аюулгүй байдлын ашиг сонирхол Монгол Улсын хөгжлийн бодлогод ниицүүлэн ашигт малтмалын хайгуулын тусгаи зөвшөөрлииг олгох ажлыг цахим хэлбэрээр сонгон шалгаруулалтын журмаар /нээлттэи болон хяэгаарлагдмал/ зохион баигуулах тусгаи зөвшөөрлиин талбаин хэмжээг тухайн сум дүүргийн нутаг дэвсгэриин 15 хувиас хэтрүүлэхгүй байх; | Энэ онд Засгийн газрын тогтоолоор батлагдсан талбайд Ашигт малтмал, газрын тосны газраас сонгон шалгаруулалт явуулахаар орон нутгийн захиргааны байгууллагаас санал авах хүсэлт ирээгүй байна. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг АМГТГ-ын кадастрын цахим бүртгэлийн системээр бүртгэн олгох ажлыг зохион байгуулж ажиллаж байна. | Х.Б |
| ЗГ-ын тогтоол | | | | | |
| 49 | 108 | “Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж”  төсөл, арга хэмжээг батлах тухай 2021-06-01 Дугаар 2021_161 | 3. “Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж” төсөл, арга хэмжээний хүрээнд сумдын Нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох, инженерийн дэд бүтцийн барилга, байгууламжийн ашиглалт, үйлчилгээг нэгдсэн байдлаар зохион байгуулж ажиллахыг холбогдох аймаг, сумын Засаг дарга нарт даалгасугай. | Аймгийн 4 сумыг нэгдсэн инженерийн дэд бүтцийн шугам сүлжээтэй болгохоор зураг төсвийг хийлгэх ажлыг зохион байгуулж байна. 1. Дарьганга сум /Зураг төслийг ажлыг Дөрвөн гүн ХХК гүйцэтгэж, барилга угсралтын ажлыг 2024-2026 оны Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгүүлэхээр болсон бөгөөд гүйцэтгэгчээр Одкон холдинг ХХК шалгаран, барилга угсралтын ажил 20% тай байна. / 2. Баяндэлгэр сум /Барилга, хот байгуулалтын сайдын багцын хөрөнгөөр зураг төслийн ажлыг 100% гүйцэтгэсэн. Барилга угсралтын зардлыг 2025 оны Улсын төсөвт суулгахаар санал хүргүүлээд байна./ 3. Мөнххаан сум /2023 оны ОНТ-т 170 сая төгрөг батлагдан, 154,0 сая төгрөгийн үнийн санал ирүүлсэн "Гидродизайн инноваци" ХХК шалгарч зураг төсөл боловсруулах шатандаа байгаа бөгөөд ажлын явц 90% тай байна. 4.Онгон сум /Инженерийн шугам сүлжээний зураг төслийг 2024 оны ЭЗХЯ-ны сайдын багцаар шийдвэрлүүлэхээр ажиллаж байна. 5.Түвшинширээ, Уулбаян сумдын инженерийн дэд бүтцийн барилга, байгууламжийг барьж байгуулах, ашиглалт, үйлчилгээг нэгдсэн байдлаар зохион байгуулах ажлыг төр хувийн түншлэлээр хэрэгжүүлэхээр төслийг сонирхогч этгээдтэй харилцаж зөвшилцөн | 70% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 50 | 109 | Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-01-05 Дугаар 2022_7 | 5. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай:<br><br>5.1. эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томьёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх;<br><br>5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх;<br><br>5.3. төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ | Аймгийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр албан тоотоор төрийн байгууллагын архив албан хэрэг хөтлөлтийг хос бичгээр бичих ажлыг эрчимжүүлэх, бэлтгэл ажлыг хангах ажлыг төрийн байгууллагуудад үүрэг чиглэл болгож эрчимжүүлж “Хос бичигтэн байгууллага”, уралдааныг 6 сарын турш, “Уламжлалт бичиг-Удирдлагын манлайлал” сургалтыг 2 сар, "Хүмүүн бичиг- Хүн бүрийн бичиг" мэдлэгээ баталгаажуулах уралдаан, "Жаахан шарга" уралдаан зэргийг зохион байгуулан, "Сумдын хэлний бодлогын зөвлөгөөн", Хүмүүн бичиг сонинг 11 албан байгууллага захиалж төрийн албан хаагчдыг зөв унших арга зүйд сургах ажлыг удирдлага , зохион байгуулалтаар ханган ажиллаа. тус арга хэмжээний хүрээнд Сүхбаатар аймаг төрийн байгууллагын гадна дотор хаягжилт 100%, гадна гэрлэн хаяг 70%, аж ахуйн нэгжийн хаягжилт 60% тай болж, Баруун-Урт, Түмэнцогт, Мөнххаан сумд орон нутгийн хөрөнгөөр нийтийн эзэмшлийн гудамж, талбай, гэр хорооллын эгнээг хос бичгээр бичсэн хаягжилттай болгосон. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 51 | 110 | Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-09-14 Дугаар 2022_340 | 1. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төр-хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, бизнесийн үйл ажиллагаанд төрийн оролцоог багасгах зорилгоор төрийн зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг сонгон шалгаруулалтын үндсэн дээр зохих хууль журмын дагуу хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх арга хэмжээ авч ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус үүрэг болгосугай. | Талын түрлэг ТББ, “Үндэстэн баг” ХХК-ий сургалтын төвтэй хамтран төрийн албан хаагч, удирдах ажилтнуудад сургалт зохион байгуулсан.<br>Уулбаян, Түвшинширээ суманд төвлөрсөн дулаан, цэвэр усны шугам сүлжээ барих ажлыг мэргэжлийн компаниар гүйцэтгүүлж 20 жил ашиглалтын үйл ажиллагааг компани хэрэгжүүлэн төрд шилжүүлэх буюу барих-ашиглах-шилжүүлэх концессын төрлөөр гэрээ хийж ажлыг эхлүүлээд байна. Ингэснээр 2 сумын төв төвлөрсөн дулаан, цэвэр усны системд холбогдох боломж бүрдсэн.<br>Боловсролын үйлчилгээг чанартай хүртээмжтэй хүргэх хүрээнд байгалийн ухааны 3 зөвлөх багштай аймгийн Засаг дарга гэрээ байгуулан ажиллаж 10-12-р ангийн хүүхдүүдэд хими, физик, математикийн хичээлээр нэмэлт сургалтуудыг зохион байгуулан 400 хүүхдийг хамруулсан. Хүүхэд хамгааллын үйлчилгээг гэрээлэн гүйцэтгүүлэхээр "Хамтдаа" ТББ, "Анна хоме" ХАХТөв, "Хүүхдийн эрхийн сургалт судалгааны хүрээлэн", "Бор тагшны бодол", "Хайрын шүхэр" ТББ,, "Монголын хүүхдийн эрхийн үндэсний төв", Манаа ХАХТөв зэрэг төрийн бус байгууллагатай хамтран Бэлгийн цогц боловсрол олгох, Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны гишүүдийг | 100% |
| | 111 | | 1.3. цэцэрлэгийн барилга төлөвлөөгүй орон сууцны хороолол, цогцолбор барилгын зураг төслийг баталж магадлан хийсэн, барилгын ажлын зөвшөөрөл олгосон, хүлээн авч ашиглалтад оруулсан албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцуулах талаар зохих арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | Одоогоор цэцэрлэгийн барилга төлөвлөгөөгүй орон сууцны хороолол, цогцолбор барилгын зураг төслийг баталж магадлал хийсэн, барилгын ажлын зөвшөөрөл олгосон, хүлээн авч ашиглалтад оруулсан зөрчил дутагдал илрээгүй байна. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 52 | 112 | Орон сууцны хороолол, цогцолбор барилгад хүүхдийн цэцэрлэг байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-11-09 Дугаар 2022_402 | 1.4. орон сууцны хороолол, цогцолбор барилгын 1, 2 дугаар давхарт цэцэрлэг байгуулах зорилгоор түрээслэх, худалдан авах, салбар бүлэг ажиллуулахад норм нормативыг мөрдүүлэх чиглэлээр мэргэжлийн хяналтын байгууллагын санал, дүгнэлтийг авч, хэрэгжилтийг хангаж, хамтран ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай. | Түмэнцогт суманд 24 айлын орон сууцны 1 давхарт байрлах 119 мкв бүхий 2 өрөө байранд цэцэрлэгийн салбар бүлэг ажиллаж байна. Салбар бүлэг нь багш ажилчдын ариун цэврийн өрөө, хүүхдийн ариун цэврийн өрөө / угаалтуур 3, суултуур-3/, унтлагийн өрөө, хүүхэд хөгжүүлэх өрөө, хүүхэд хүлээн авах өрөөтэй. Сум хөгжлийн сангийн төсвөөр худалдан авсан, сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгөд данс бүртгэлтэй. 28-35 хүүхэд хүлээн авч СӨБ-ыг олгож байна. Энэ хичээлийн жилд 2 настай 25 хүүхэд суралцаж, бүлгийн багш, туслах багш ажиллаж байна. Салбар бүлгийн норм нормантивийг хангах чиглэлээр нийтийн орон сууцнаас тусдаа орох хаалга хийж дулаалсан. Мөн хашаажуулсан. Дотор талд бага насны хүүхдийн стандартад нийцсэн 00, угаалтуур суурилуулсан. | 100% |
| | 113 | | 2. Цаашид шинээр баригдах орон сууцны хороолол, цогцолбор барилга байгууламжийн зураг төсөлд цэцэрлэг төлөвлөх, ашиглалтад оруулах талаар дараахь арга хэмжээ авч хэрэгжилтийг хангаж ажиллахыг дор дурдсан холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус даалгасугай:<br>2.1. барилга байгууламжийн газар олголт, барилгажилтын төсөл, архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар зураг төсөлд холбогдох норм, дүрмийн дагуу цэцэрлэгийн барилгыг заавал тусган баталгаажуулж байхад хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;<br>2.2. орон сууцны | Баруун-Урт сумын 1-р баг 964 айлын орон сууцны хотхоны барилга байгууламжийн газар олголт, барилгажилтын төсөл, архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар зураг төсөлд холбогдох норм, дүрмийн дагуу цэцэрлэгийн барилгыг заавал тусгуулан мэргэжлийн байгууллагуудаар зураг төслийг баталгаажуулан хүлээн авсан болно. Баруун-Урт сумын 8-р багт 640 хүүхдийн цогцолбор сургуулийн барилга угсралтын ажил эхлэж Стандарт холдинг ХХК, Баяндэлгэр сум 200 хүүхдийн цэцэрлэгийн барилга угсралтын ажлыг Стандарт холдинг ХХК, Уулбаян сум 150 хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажил угсралтын ажлыг "Хөх хайрхан трейд" ХХК, Түвшинширээ сум 320 хүүхдийн сургуулийн барилгыг Хөх хайрхан трейд ХХК шалгарч 2024 оны төлөвлөгөөн тусгагдсан ажлыг гүйцэтгэн технологийн зогсолт хийгдээд байна. Сүхбаатар аймагт цэцэрлэгийн хүрэлцээ хангамж сайн. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 114 | | 3. Хот, тосгоны хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд хот байгуулалтын норм, дүрмийн шаардлагыг хангасан цэцэрлэгийн барилгыг тусгасан эсэхэд хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. | 2021 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Халзан, Мөнхаан сумдын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг инженер геодези ХХК-аар хийж гүйцэтгүүлэн аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулахад бэлэн болсон байна. 2024 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 480,0 сая төгрөгийг төсөвт тусган Дарьганга, Асгат, Наран, Түвшинширээ сумдын ХЕТ-г 2 багц тендер болгон зарлан Арт констракш ХХК, Эй ди жи си ХХК-тай гэрээ байгуулан хийж гүйцэтгүүлж байна. Онгон, Уулбаян, Сүхбаатар сумд өөрсдийн төсөв хөрөнгөөр ХЕТ-г шинэчлэх ажлыг хийж гүйцэтгэж байна. Энэхүү ажилтай холбогдуулан шинээр баригдах цэцэрлэгийн барилгын хүрэлцээ хангамжийг тодорхойлж дунд шатны бодлогын баримт бичигт хот байгуулалтын норм, дүрмийн шаардлагыг хангуулах зорилгоор ЕТ боловсруулах зургийн даалгаварт цэцэрлэгийн барилгыг тусган хяналт тавьж ажиллаж байна. | 100% |
| | 115 | | 4. Цэцэрлэгийн зориулалтаар баригдсан барилга байгууламжийг улсын төсвийн хөрөнгөөр түрээслэх, худалдан авах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх, шаардагдах зардлыг жил бүрийн улс, нийслэл, орон нутгийн төсвийн төсөлд тусгахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. | 2023-2024 оны хичээлийн жилд барилга байшин түрээслэх үйл ажиллагаа хийгдээгүй бөгөөд 2024-2025 хичээлийн жилийн бэлтгэл ажлыг хангаж хичээл сургалтын үйл ажиллагааг эхлүүлсэн. цэцэрлэгийн зориулалтаар баригдсан барилга байгууламжид өөр зориулалтаар үйл ажиллагаа явуулж байгаа тохиолдол байхгүй байна. Түвшинширээ суманд 2019 онд ашиглалтад орсон 200 хүүхдийн цэцэрлэгийн барилга нуралт үүссэн тул хүүхдүүдийг 2023-2024, 2024-2025 оны хичээлийн жилд нэмэлтээр 8 гэр цэцэрлэг барьж сургуулийн өмнөх боловсролыг олгож байна. Ачаалал ихтэй Уулбаян, Баяндэлгэр , Эрдэнэцагаан, Дарьганга , Онгон сумдад нэмэлтээр 19 гэр цэцэрлэг үйл ажиллагаагаа явуулж байна. Гэр цэцэрлэгийг зуухгүй болгох ажлын хүрээнд гэрийн дулаалга, халаалт агаар сэлгэлтийн ЧИП багцтай төслийг хэрэгжүүлж 19 гэр цэцэрлэгт зуух түлэхгүйгээр үйл ажиллагаа эрхэлж байна. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 53 | 116 | Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга | 3. Энэ тогтоолын 2-т заасан чиглэлийн хүрээнд орон нутгийн хэмжээнд Ажлын хэсэг байгуулж, тодорхой арга хэмжээ авч, шаардагдах эх үүсвэрийг батлагдсан төсөвтөө багтаан санхүүжүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.<br><br>/2. Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьших иргэдийн ажиллаж, амьдрах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, орон нутагт үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжих чиглэлээр холбогдох хууль тогтоомжийг шинэчлэн боловсронгуй болгох арга хэмжээний цогц хөтөлбөр боловсруулж, батлуулахыг Монгол Улсын Шадар сайд | Аймгийн ИТХ-ын 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 06 дугаар тогтоолоор “Нээлттэй аймаг Сүхбаатар” хөтөлбөр батлагдсан. Уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлагдан хэрэгжилтийг хանган ажиллаж байна. Хөтөлбөрийн хүрээнд аймгийн онцлог, түүх, соёл, өөрсдөд буй боломжоо ард иргэдэд таниулах, иргэдэд ажиллаж амьдрах таатай орчин бүрдүүлэх, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний чанарыг сайжруулах, үйлдвэр байгуулах аж ахуйн нэгж байгууллагыг дэмжих, мэргэжлийн ажиллах хүчний хомсдолыг багасгах зорилгыг дэвшүүлэн төлөвлөсөн. Эдгээр зорилгын хүрээнд нийт 37 арга хэмжээг төлөвлөн 2023-2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөгөө гарган хэрэгжүүлж байна. Энэ төлөвлөгөөний дагуу 2 эвэнтийг зохион байгуулсан. Хөрөнгө оруулалтын чуулганыг Баруун-Урт хотод , Сүхбаатарын оюутнууд арга хэмжээг УБ хотод зохион байгуулсан. Сургуулиа төгсөөд нутагтаа ажиллаж амьдрахад ямар боломж давуу тал байгааг мэдээлэх, шаардлагатай байгаа ажлын байрны мэдээллийг хүргэхэд УБ хотод сурч байгаа Сүхбаатар аймгийн 400 гаруй оюутнууд оролцсон эвэнт арга арга хэмжээг зохион байгуулсан. Хөрөнгө оруулалтын чуулганаар: - НҮБ-ын Хүүхдийн сан - | 70% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 117 | авах зарим арга хэмжээний тухай 2022-11-23 Дугаар 2022_419 | 4. Улаанбаатар хотын хэт төвлөрлийг бууруулах, хот, хөдөөгийн хөгжлийн зохистой тэнцвэрийг хангах зорилгоор Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Орхон, Өмнөговь, Сэлэнгэ аймаг, нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүрэг хүн амынхаа тоог 20 хувиар, бусад аймаг 10 хувиар тус тус нэмэгдүүлэх бодлогын чиглэлийг баримталж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн болон нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. | Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьшсан анх удаа орон сууц худалдан авсан иргэдийн хүсэлтийг хүлээн авч судлан шийдвэрлэснээр 3 иргэнд 207 сая төгрөгийг олгосон. Аймаг орон нутагт эрэлттэй мэргэжлийн жагсаалт гаргаж, эрэлттэй мэргэжлээр ажиллаж байгаа 5 багшид тус бүр 20,000,000 төгрөг, шилжин ирж ажиллаж байгаа 2 багшид тус бүр 20,000,000 төгрөг, орон нутагтаа зөвлөх багшийн үйлчилгээг үзүүлж байгаа 3 багшид 60,000,000 төгрөг, нийт 200,000,000 төгрөгийг Хүний нөөцийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд дэмжлэг үзүүлж шийдвэрлэлээ. Улаанбаатар хотоос гэр бүлээрээ Асгат суманд шилжин ирсэн багшийн ажлын байранд 18,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэн технологийн кабинеттай болгосон. Мөн "Хотоос хөдөө", “Хөдөөд тавтай морил” контент, кейсүүдийг бэлтгэн нэвтрүүлснээс гадна аймгийн Засаг дарга М.Идэрбат Орон нутагт шилжиж амьдрахаар зорьж буй иргэдэд аймаг орон нутгаас үзүүлэх дэмжлэг, боломжийн талаар үндэсний томоохон 10 гаруй телевизэд ярилцлага өгч аймаг орон нутгаа сурталчлах ажлыг зохион байгуулсан. | 70% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 54 | 118 | Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-12-07 Дугаар 2022_448 | 1.12. . 1.12 гүйцэтгэсэн ажлын бүтээмжийг нь харгалзан аймаг, сумын засаг захиргааны байгууллагад ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдын үндсэн цалинг хоёр дахин хүртэл нэмэгдүүлсэн хэмжээгээр тооцож, орон нутгийн нэмэгдлийг батлагдсан төсөвтөө багтаан олгох арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;<br><br>1.13.орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалтын арга хэмжээг төлөвлөх, батлах, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх, бүртгэх, тайлагнах, хяналт тавихад холбогдох хууль тогтоомжийг баримталж ажиллахыг аймаг, нийслэлийн | 2023 оны төсвийн жил дууссан тул хасах саналтай<br><br>Хяналтаас хасуулах санал : төсвийн жил дууссан тул хасах саналтай | Х.Б |
| 55 | 119 | 2023-2024 оныг Авлигатай тэмцэх жил болгон зарлах тухай 2023-02-08 Дугаар 2023_49 | Х-1.2. Шүгэл үлээх үйл ажиллагааг бүх талаар дэмжих хөдөлгөөн зохион байгуулж, авлигыг үл тэвчих, үл эвлэрэх хандлагыг төлөвшүүлэх, олон нийтийн дэмжлэг авах; | 2023 онд зохион байгуулагдсан Авлигын эсрэг "Нэгдье" аяныг орон нутагтаа өрнүүлж, гудамж талбайд хэвлэл байршуулах, цахим хуудас, нийгмийн сүлжээнд зурагт хуудас байршуулах зэрэг арга хэмжээг авсан. Үүнд: бүх төрийн байгууллагуудын нийгмийн сүлжээн дэх цахим хуудас, аймаг, сумдын хандалт өндөртэй зарын цахим хуудас, группүүдэд "Нэгьде" аяны зурагт хуудас, авлигыг мэдээллэх сувгуудын талаарх мэдээллийг түгээж, иргэд, олон нийтийг авлигын эсрэг нэгдэхийг уриалж ажиллалсан. Мөн аймгийн хэмжээнд 13 сум, 24 агентлаг үйл ажиллагаа явуулдгаас 21 нь Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээллэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбарыг тусгайлан хийлгэж, бусад сум, байгуулллагууд мэдээллийн самбарт "Шударга ёс, хөгжилд дэвшил 110" мэдээллийн буланг ажиллуулж, мэдээ мэдээллийг тогтмол шинэчлэн байршуулж ажиллаж байна. Уг самбарт авлигыг мэдээллэх арга, сувгуудын талаарх мэдээллийг байршуулсан. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 120 | | X-1.3. Төрийн үйлчилгээний хүнд суртал, чирэгдлийг багасгах, иргэд, хувийн хэвшлийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, хамтран ажиллах. | Төрийн захиргааны удирдлагын хэлтэс нь Иргэдийн санал хүсэлт, гомдол, мэдээ, мэдээллийг хүлээн авах нээлттэй утас болох 70510111 утасанд 49 дуудлага хүлээн авсан бөгөөд цаг үеийн нөхцөл байдалтай холбоотой болон лавлагаа, тодруулга, мэдээлэл авах хүсэлтэй дуудлага байлаа. Дуудлага бүрийг тухайн цаг хугацаанд шийдвэрлэж хариуг мэдэгдсэн. Мөн хэвлэл мэдээллийн тасаг нь иргэдэд мэдээллийг ил тод нээлттэй түргэн шуурхай хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон Аймгийн засаг даргын тамгын газрын пэйж хуудсаар дамжуулан иргэдэд хүргэж байна. | 100% |
| 56 | 121 | Хүнсний хангамж, хөдөө аж ахуйн салбарын технологит ажлын талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-02-08 Дугаар 2023_63 | 3. Мал, малын гаралтай бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхойлох зорилгоор нийт үхэр сүргийг ялган тэмдэглэж, Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай. | 2023-2024 оны өвөлжилт, хаваржилт хүндэрч аймгийн хэмжээнд 1.8 сая толгой мал зүй бусаар хорогдож 1,7 сая толгой мал өвөлжиж хаваржих урьдчилсан дүн гарсан. ХХААХҮ-ийн сайдын 2024 оны А/136 дугаар тушаал, Засаг даргын 2024 оны А/560 тоот захирамжийн дагуу Үржлийн малд үзлэг ангилалт хийж, малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох ажлын хүрээнд 2276 толгой үхэр сүргийг ээмэгжүүлэн бүртгэлжүүлсэн. Үүнээс улсын төсвөөр Түмэнцогт сумын 2000 үхрийг ээмэгжүүлсэн. | 100% |
| 57 | 122 | Хот, хөдөөгийн сэргэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-02-08 Дугаар 2023_68 | 7. Шилжин суурьших иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, хөрөнгө оруулагчдад мэдээлэл өгөх цахим платформыг үүсгэн, төрийн үйлчилгээг цахимжуулан “Цахим аймаг” болгох арга хэмжээ авч ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны яам (Н.Учрал), аймгийн Засаг дарга нарт даалгасугай. | 024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн ээлжит хуралдаанд "Цахим Сүхбаатар" дэд хөтөлбөрийг танилцуулан батлуулсан . Уг хөтөлбөрийн хэрэгжилтийг 2024-2026 онд хэрэгжүүлэхээр тусгасан ба тус хөтөлбөрийн зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар агентлаг албадын дарга, холбогдох мэргэжилтнүүдэд танилцуулах үйл ажиллагааг 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулж 126 албан хаагчийг хамруулж ажиллалаа. “Цахим Сүхбаатар” дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 2024 оны 09 сарын 06-ны 04/1023 тоот албан бичгээр хөтөлбөр, шалгуур үзүүлэлтийн хамтаар сумд,агентлаг, албадын дарга, эрхлэгч нарт хэрэгжилтийг хангал ажиллах чиглэл хүргүүлж ажилласан. | 70% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 58 | 123 | Мөнгөн төлбөрийн хэмжээг тогтоох тухай 2023-04-05 Дугаар 2023_119 | 2. Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн хэлбэрээр хаах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, мөнгөн төлбөрийг төвлөрүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. | Монгол улсын Засгийн газраас тогтоосон сүлжээний дагуу цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах 12 дугаар сарын байдлаар 12 иргэн төлж 18.072.402 төгрөгийг Төрийн сангийн тусгай дансанд төвлөрүүлсэн | 100% |
| 59 | 124 | Шинжлэх ухаан, технологийн салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2023-04-05 Дугаар 2023_120 | 2.3. “Хот хөдөөгийн сэргэлт”-ийн хүрээнд нийгэм, эдийн засгийн бүсчлэл тогтоох схем, арга зүй, шалгуур үзүүлэлтийг боловсронгуй болгох, эдийн засгийн өсөлтийн төв боомтуудын тусгайлсан орон зайн хөгжлийн төлөвлөлтийг боловсруулж, дэмжлэг үзүүлж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Шинжлэх ухаан, технологийн салбар зөвлөлийн дарга нарт; | инжлэх ухаан , технологийн шинэ шийдлийг орон нутагт түгээн дэлгэрүүлэх зорилгоор 2024 оны аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд 530,0 сая төгрөгийг батлуулан Баруун-Урт сумын хуучин лагийг бордоо болгох технологийг ашиглах төслийг хэрэгжүүлэхээр худалдан авах үйл ажиллагааг зарласан. Агаарын бохирдол, хог хаягдлыг бууруулах зорилгоор эх хүүхдийн эрүүл мэндийг дэмжих хүрээнд Гэр хороололд амьдарч байгаа иргэдийн амьдрах дотоод орчны чанарыг дээшлүүлэх "Монгол гэрийн халаалт, дулаалга, агаар сэлгэлтийн чип багц" төслийг хэрэгжүүлэхээр орон нутгийн төсөвт 1,3 тэрбум төгрөгийг батлуулан 867 өрхийг технологийн шинэ шийдэл болох халаалт, дулаалгыг шийдсэн багцыг түгээн дэлгэрүүлэхээр төлөвлөн хэрэгжүүлж байна. | 70% |
| | 125 | | 3. Энэ тогтоолд заасан арга хэмжээг 2024 оноос эхлэн хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг жил бүрийн улсын төсвийн төсөлд тусгах арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, холбогдох Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт тус тус даалгасугай. | Шинжлэх ухаан , технологийн шинэ шийдлийг орон нутагт түгээн дэлгэрүүлэх зорилгоор 2024 оны аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд 530,0 сая төгрөгийг батлуулан Баруун-Урт сумын хуучин лагийг бордоо болгох технологийг ашиглах төслийг хэрэгжүүлэхээр худалдан авах үйл ажиллагааг зарласан. | 70% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 60 | 126 | Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай 2023-06-21 Дугаар 2023_241 | 2. Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. | Хүчингүй болсон тул хасах саналтай<br><br>Хяналтаас хасуулах санал : хүчингүй болсон тул хасах саналтай | Х.Б |
| 61 | 127 | Боловсролын салбарын хөрөнгө оруулалтын ажлыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-07-05 Дугаар 2023_266 | 3. Стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын ашиглалттай холбогдон гарах зардлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу жил бүрийн орон нутгийн төсөвт тусган, засвар үйлчилгээг хариуцаж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай | 2024 онд 7 сумын 6 цэцрлэг, 4 сургууль, 5 дотуур байранд орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болох барилга угсралтын ажил хийгдэж, Эрдэнэцагаан, Дарьганга сумын боловсролын 4 байгууллагын барилга угсралтын ажил дуусч ашиглалтад орсон. Дотуур байрны нүхэн жорлонг ариун цэврийн байгууламжаар солих арга хэмжээг жил дараалан хэрэгжүүлж байгаа ба энэ онд 5 дотуур байрны ариун цэврийн байгууламжийг 12 дугаар сард ашиглалтад өгөхөөр барилга угсралтын ажил хийгдэж байна. Дээрх 5 дотуур байрны ариун цэврийн байгууламж ашиглалтад орвол сургуулийн дотуур байрууд 100 % орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болно. Шинээр ашиглалтад орсон 5 байгууламж орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болсон.2024 онд 16 сургууль, 24 цэцэрлэг, БӨНДБайр 41 байгууллагын байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 4,850,159.8 мян.төг, урсгал засвар 376,872.2 мян.төг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулсан. | 100% |
| 62 | 128 | Журам шинэчлэн батлах тухай 2023-07-19 Дугаар 2023_278 | 2. Энэ журмыг хэрэгжүүлж ажиллахыг бүх шатны төсвийн захирагч нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхланд тус тус үүрэг болгосугай.(1."Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам) | Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам) Бүхий л түвшинд хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын ажилд 278-р журмыг хэрэгжүүлэх талаар сумд, байгууллагуудад зөлөмж чиглэл хүргүлэн ажилласан. Аймагт хийгдэж буй Олон улсын зээл тусламж, Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын ажлуудад дээрхи журмыг баримтлан ажиллаж байна. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 63 | 129 | Хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай 2023-07-19 Дугаар 2023_279 | 2.. 2.5.Энэ тогтоолын хавсралтаар батлагдсан аймаг, нийслэл, сум, дүүргийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөц, аймгийн төвийн хүн амын хаврын улирлын махны нөөцийг бүрдүүлэх арга хэмжээ авах, отор нүүдлийг тогтоосон чиглэлийн дагуу явуулах, мал эмнэлгийн хорио цээрийн хяналт шалгалтыг эрчимжүүлж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам) Бүхий л түвшинд хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын ажилд 278-р журмыг хэрэгжүүлэх талаар сумд, байгууллагуудад зөлөмж чиглэл хүргүлэн ажилласан. Аймагт хийгдэж буй Олон улсын зээл тусламж, Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын ажлуудад дээрхи журмыг баримтлан ажиллаж байна.<br><br>Хяналтаас хасуулах санал : 2023-2024 оны өвөлжилт хаваржилт цаг үеийн хувьд өнгөрсөн тул хасах саналтай | 100% |
| 64 | 130 | Нийслэл Улаанбаатар хотод гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, гамшгийн хор уршгийг арилгах, нийслэлийн хот төлөвлөлт, газар зохион байгуулалттай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2023-08-16 Дугаар 2023_294 | 3. 3.Аймаг, сум, чөлөөт бүсийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдаагүй, тусгагдсанаас өөр зориулалтаар газар эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргахгүй байхыг аймаг, сумын Засаг дарга, чөлөөт бүсийн захирагч нарт үүрэг болгосугай. | Аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө, сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу тухайн жилд эзэмшүүлэх, ашиглуулах, өмчлүүлэх газруудын төслийг аймаг, сумдын ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулж, Засгийн газрын хуралдаанд оруулж шийдвэр гаргуулахаар хүргүүлэн батлуулсан. Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 03 өдрийн 136, 137 дугаар тогтоолын дагуу газар олголтыг хийж гүйцэтгэж байна. Тус тогтоолыг зөрчсөн захирамж шийдвэр гаргаагүй болно. | 100% |
| 65 | 131 | Цэргийн дүйцүүлэх алба хаах иргэдийн тооны дээд хязгаарыг тогтоох тухай 2023-08-23 Дугаар 2023_304 | 2. Цэргийн дүйцүүлэх алба хаах арга хэмжээг холбогдох журмын дагуу зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. | Цэргийн албаны тухай хуулийн 30 дугаар зүйл, Засгийн газрын 2023 оны 304 дүгээр тогтоолын дагуу Цэргийн албыг биеэр дүйцүүлэх хаах 30 иргэнийг Аймгийн засаг даргын А/739 захирамжаар элсүүлэн гэрээ байгуулсан. Аймгийн Засаг даргын 2024 оны А/323 дугаар захирамжийн дагуу цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах 40 иргэний сургалтыг Сүхбаатар сумын нутагт хээрийн байрлалд 14 хоногийн хугацаатай зохион байгуулсан. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 66 | 132 | Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2023-08-30 Дугаар 2023_312 | 4. Аймгийн Засаг даргын тамгын газрын орон тоог нэмэгдүүлсэнтэй холбогдон гарах зардлыг 2023 оны батлагдсан төсөвтөө багтаан зохицуулж, цаашид жил бүрийн төсвийн төсөлдөө тусгаж ажиллахыг аймгийн Засаг дарга нарт тус тус даалгасугай | Тогтвортой амьжиргаа-3" төслийн хэрэгжих хугацаа дууссантай холбогдуулан аймгийн Засаг даргын тамгын газарт "Орон нутгийн хөгжлийн сан" хариуцсан ажилтан ажиллуулахаар батлагдсаны дагуу аймгийн Засаг даргын тамгын газрын орон тоонд ТЗ-7 шатлал бүхий 1 орон тоог нэмж, холбогдох зардлыг 2024 оны төсөвт тусган батлуулж, албан хаагчийг сонгон шалгаруулж авсан. | 100% |
| | 133 | | 5. Худалдан авах ажиллагааны газар байгуулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохих журмын дагуу зохион байгуулж, албан хаагчдыг орон тоо, цалингийн сан, эд хөрөнгийн хамт Орон нутгийн өмчийн газраас шилжүүлэн ажиллуулах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхийг аймгийн Засаг дарга нарт тус тус даалгасугай. | “Худалдан авах ажиллагааны газар шинээр байгуулах тухай” аймгийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн А/664 дугаар захирамжийн дагуу шинээр байгуулагдаж, 2024 оны 01 дүгээр сарын 09-ний өдрөөс эхлэн үйл ажиллагааг хэвийн явуулж байна. Байгууллагын үйл ажиллагаанд хамаарах шаардлагатай эд хөрөнгийг шилжүүлэх асуудлыг Тус газраас 2024 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 15 тоот албан бичгээр хүсэлтийг ирүүлж, Орон нутгийн өмчийн газрын даргатай зөвшилцсөн бөгөөд холбогдох эд хөрөнгийг шилжүүлэх асуудлыг аймгийн ИТХ-ын ажлын албанд 44,368,161 төгрөгийн эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийг шилжүүлэх санал хүргүүлж аймгийн ИТХ-ын 2024 оны 06 дугаар сарын 03-ны 02 тоот тогтоолоор шилжүүлэх шийдвэрийг бүрэн хэрэгжүүлсэн. Мөн уг тогтоолын дагуу Орон нутгийн өмчийн газрын даргын 2024 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/26 дугаар тушаалаар 20 нэр төрлийн 1669500 төгрөгийн үнэ бүхий эргэлтийн хөрөнгийг шилжүүлсэн.<br><br>Хяналтаас хасуулах санал : Шийдвэр хэрэгжсэн тул хасах саналтай | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 67 | 134 | Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн зарим арга хэмжээний тухай 2023-08-30 Дугаар 2023_321 | 2. Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг харьяалах салбар, нутаг дэвсгэртээ зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, шаардагдах зардлыг төсвийн ерөнхийлөн захирагч нарын саналыг харгалзан улсын нэгдсэн төсвийн төсөлд тусган, хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхланд даалгасугай. | МУЗГ-н 2023 оны ”Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх тухай” 321 дүгээр тогтоолын хүрээнд 4 сайдын хамтарсан 2024оны А/75, А/09, А/73, А/34 дүгээр тушаалын дагуу Аймгийн Засаг даргын 2024 оны 351 дүгээр захирамжаар "Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх" арга хэмжээг зохион байгуулах зөвлөл байгуулагдсан. Тус зөвлөл 1 удаа хуралдаж, аймгийн хэмжээнд "Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх" арга хэмжээг зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргаж, холбогдох сум, агентлагт үүрэг чиглэл өгсөн. Батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган сар бүрийн 20-ны дотор байгууллагуудаас тайланг авч, нэгтгэж байна. 4 дүгээр улирлын байдлаар 10 байгууллага тайлангаа ирүүлсэн байна. Мөн уг төлөвлөгөөнд орсон Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, Хүн амын эрүүл мэндийн боловсрол, мэдлэг хандлага, ур чадварыг үнэлэх сэдэвт 2 төрлийн судалгаа хийгдсэн байна. -Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр ЭМГ, Аймгийн нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн цахим хуудсанд халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 621 | 100% |
| 68 | 135 | “Эрүүл шүд” арга хэмжээг хэрэгжүүлэх тухай 2023-08-30 Дугаар 2023_322 | 2. Сургуулийн өмнөх боловсролын байгууллага болон ерөнхий боловсролын сургуульд өдөр бүр “Шүд угаах цаг”-ийг бий болгон хэвшүүлж, эрүүл ахуйн шаардлага хангасан шүдээ угаах хэсэг бий болгох ажлыг үе шаттайгаар улс, орон нутгийн төсвийн болон гадаадын зээл тусламжийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр тусгаж, холбогдох арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай. | Сургуулийн өмнөх боловсролын байгууллага болон ерөнхий боловсролын сургуульд өдөр бүр шүд угаах цагийг бий болгож шүдээ угаах нөхцөлийг бүрдүүлсэн 24 цэцэрлэгт 4670 хүүхэд 13 дотуур байранд 1202 хүүхэд нийт 5872 сурагчдад шүд угаах эрүүл ахуйн дадал хэвшилд суралцах аяныг хэрэгжүүлж байна. Улсын төсвөөр Мөнххаан ЕБС, дотуур байр, Эрдэнэцагааны 1.2-р цэцэрлэг, Уулбаян ЕБС, Түвшинширээ дотуур байр зэрэг байгууллагуудад ариун цэврийн байгууламж ашиглалтад орсноор шүд угаах эрүүл ахуйн орчин нөхцөл бүрдэж байна. | 70% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 69 | 136 | Журам батлах тухай 2023-09-13 Дугаар 2023_344 | 2.. 2. Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн орон нутгийн төсвийн төсөлд тусган шийдвэрлүүлж байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. | Хүнс хөдөө аж ахуйн газраас 2024 оны хүн амын махны нөөц бүрдүүлэхээр 3 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан 40.0 тн мах нөөцөлж, 03-06 хүртэл ААН-үүд өөрийн нэрийн дэлгүүр буюу агуулахаас иргэдэд болон төсвийн байгууллагуудад нийлүүлсэн . Хөдөө орон нутаг тул орон нутгийн буюу улсын төсвийн хөрөнгөөр нөөц бүрдүүлэхэд хөрөнгө зарцуулдаггүй онцлогтой | 100% |
| 70 | 137 | Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг батлах, эрх олгох тухай 2023-09-20 Дугаар 2023_351 | 2. Энэ тогтоолоор баталсан солбицол бүхий талбайд авто зам, инженерийн шугам сүлжээний барилгын ажил гүйцэтгэх хуулийн этгээдэд түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах эрх олгохыг Сүхбаатар аймгийн Засаг дарга М.Идэрбатад даалгасугай. | асгийн газрын тогтоолоор батлагдсан солбицол, талбайд авто зам, барилгын ажилд шаардагдах ТТАМ хайх, ашиглах зөвшөөрлийг аймгийн Засаг даргын 2023 оны А/680 дугаар захирамжаар Эрээн толгой ХХК-д олгон, холбогдох мэргэжлийн байгууллага, сумдад хүргүүлсэн, хэрэгжилтийг хангуулан хяналт тавьж ажиллаж байна. Зам барилгын ажлын явц, гүйцэтгэл 30%-тай байна. | 100% |
| | 138 | | 3. Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах болон зам, замын байгууламж барих ажлын явцад соёлын биет өв илрэх тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагад нэн даруй мэдээлэх, ажил дууссаны дараа түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласан талбайг холбогдох стандарт, нормын дагуу нөхөн сэргээж, орон нутгийн эрх бүхий байгууллагад зохих ёсоор хүлээлгэн өгөхийг ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Соёлын сайд Ч.Номин, Сүхбаатар аймгийн Засаг дарга М.Идэрбат нарт үүрэг | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 351 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/680 дугаар захирамжаар Эрээнтолгой нүүрсний уурхайгаас Бичигтийн боомт хүртэлх 110.3 км тусгай зориулалтын авто зам, Бичигт авто зам, гадна инженерийн шугам сүлжээний барилга угсралтын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах болон зам, замын байгууламж барих ажлын явцад соёлын биет өв илрэх тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагад нэн даруй мэдээллэх, ажил дууссаны дараа түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласан талбайг холбогдох стандарт, нормын дагуу нөхөн сэргээж, орон нутгийн эрх бүхий байгууллагад зохих ёсоор хүлээлгэн өгөхийг ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээд, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтэс, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Эрдэнэцагаан сумын Засаг дарга нарт тус тус даалгасан.Сүхбаатар сумын нутаг дэвсгэрээр төмөр зам тавихтай холбогдуулж аймгийн Байгаль орчны газраас тухайн чиглэл, ойр орчимд байгаа соёлын өвийн талаархи мэдээлэл судалгааг авсан. Энэ ажилд Сүхбаатар сумын байгаль орчны байцаагч | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 71 | 139 | Улсын нөөцөөс бараа материал гаргаж, нөхөн бүрдүүлэх тухай 2023-12-13 Дугаар 2023_449 | 3.. 3.Улсын нөөцөөс олгох тэжээлийг оновчтой хуваарилах, зориулалтын бусаар зарцуулах, худалдаалахаас урьдчилан сэргийлж, хяналт тавих, гүйцэтгэлийн тайланг холбогдох баримтын хамт 2024 оны I улиралд багтаан Онцгой байдлын ерөнхий газарт хүргүүлэхийг аймаг, нийслэлийн Засагдарга нарт даалгасугай. | Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны А/04 тоот “Малын өвс хүлээн авах комисс томилох тухай” тушаалын дагуу Аймгийн аюулгүйн нөөцөд малын өвс хүлээн авах комисст ургамал хамгаалал хорио цээрийн байцаагч хяналт тавьж ажилласан.Хяналтаар зөрчил илрээгүй болно.<br><br>Хяналтаас хасуулах санал : хугацаанд хийгдээж өнгөрсөн 1 удаагийн шинжтэй арга хэмжээ тул хасах саналтай | 100% |
| | 140 | | 1.1.. 1.Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай:<br>1.1..Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2023 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн гүйцэтгэлийн явЦ байдалтай уялдуулан, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцын дүнд багтаан хөрөнгийн зохицуулалт хийж, санхүүжүүлэх; | төсвийн зохицуулалт хийсэн төсөл арга хэмжээ байхгүй<br><br>Хяналтаас хасуулах санал : төсвийн жил дууссан тул хасах саналтай | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 72 | 141 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-12-13 Дугаар 2023_456 | 1.2.. 1.2.Улсын төсвийн хөрөнгөөр 2023 онд санхүүжүүлэхээр гэрээ нь хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, санхүүжилт бүрэн авах боломжгүй нөхцөл байдал үүссэн зарим төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн олгогдоогүй санхүүжилтийн үлдэгдлийг төсвийн ерөнхийлөн захирагчийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулах; | 2023 оны төсвийн жилд дуусч ашиглалтанд орох байсан 7 төсөл арга хэмжээний 4973,8 сая төгрөгийн санхүүжилтийг захиалагчийн барьцаа хөрөнгө оруулалтанд дансанд байршуулсан.<br><br>Хяналтаас хасуулах санал : төсвийн жил дууссан тул хасах саналтай | 100% |
| | 142 | | 1.3.. 1.3.Төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн гүйцэтгэлд хяналт тавьж, баталгаажуулсны үндсэн дээр 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор энэ тогтоолын 1.2-т заасны дагуу барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан олгогдоогүй санхүүжилтийн үлдэгдлээс бодит гүйцэтгэлээр санхүүжүүлэх. | Барьцаа санхүүжилтэнд 7 төсөл арга хэмжээний 4973,8 сая төгрөг байршуулсан. Спорт цогцолборын барилга угсралтын ажил, Түвшинширээ сумын 100 ортой дотуур байрны барилга, 960 хүүхдийн сургуулийн барилгын ажлууд дуусч улсын комисс ажиллаж ашиглалтанд орсон тул Спорт цогцолборын барилгын 620,0 сая төгрөг, 960 хүүхдийн сургуулийн 697,7 сая төгрөг, Түвшинширээ сумын 100 ортой дотуур байрны үлдэгдэл 633,2 сая төгрөгийн санхүүжилтүүд чөлөөлөгдсөн. 3 автозамын ажил, Соёл амралтын хүрээлэнгийн 1-р ээлжийн автозамын ажлууд үргэлжлэн явагдаж байна. Орон нутагт ажиллах хүч олдохгүй хүндрэл бэрхшээл тулгамдсан асуудал болж байна4-р тойргийн 9,1 км автозамын ажил дууссан комисс ажиллуулах хүсэлтээ өгсөн. ЗГ-ын 456 дугаар тогтоолын хугацааг 12/30 хүртэл сунгасан. | 70% |
| 73 | 143 | Аргачлал шинэчлэн батлах тухай (Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлгийг тооцох аргачлал) 2023-12-20 Дугаар 2023_457 | 2. Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 2024 оны төсвийн жилээс эхлэн энэ тогтоолын 1-д заасан аргачлалын дагуу тооцон хуваарилж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхлан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай | 2024 оны ОНХС-ийн шилжүүлгийг тус тогтоолоор батлагдсан аргачлалын дагуу хуваарилж баталсан. Итгэлцүүрээр хуваарилагдаж буй эх үүсвэрийн 60 хувиас доошгүй нь сумдад хуваарилагдаж байна. Аймгийн ОНХС-ийн орлогын шилжүүлэг 18215,7 сая төгрөг хуваарилагдаж ирсэн үүнээс сумдад 12044,8 сая төгрөг буюу 307,0-2481,1 сая төгрөг хуваарилагдаж байна. Сумдын батлагдсан ОНХС-ийн шилжүүлгийг аймгийн Засаг даргын 2024 оны А/02 дугаар захирамжаар батлагдсан сарын хуваарийн дагуу олгож ажилласан. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 74 | 144 | Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-12-20 Дугаар 2023_458 | 2. Төлөвлөгөөнд тусгагдсан, өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.(Өвлийн аялал жуулчлалын 2024 оны төлөвлөгөө) Төлөвлөгөө батлагдсанаас хойш хэрэгжилтийг тайлагнах | Өвлийн аялал жуулчлалын 2024 оны төлөвлөгөө батлагдаагүй | Х.Б |
| 75 | 145 | Мах бэлтгэхэд зориулан олгох зээлийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-12-20 Дугаар 2023_461 | 4. Мах бэлтгэн нийлүүлэлт, борлуулалт болон чанар, аюулгүй байдалд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны салбарын хяналтын газрын салбарын ерөнхий байцаагчийн баталсан 08-00-02/29 дугаартай удирдамжийн дагуу мал төхөөрөх 2 объект, мах боловсруулах 1 объект, нийт 2 аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус шалгалт хийж 78 зөрчил илрүүлэн 56.0 хувийг газар дээр арилгуулан улсын ахлах байцаагийн 38 заалттай 2 албан шаардлага хүргүүлэн биелэлт 85 хувьтай байна. | 100% |
| 76 | 146 | 2024 оныг “Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил” болгон зарлах тухай 2023-12-27 Дугаар 2023_481 | 4. Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын төслийг боловсруулах, холбогдох тооцоо, судалгаа хийх, санал өгөх чиглэлээр хамтран ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн удирдлагад даалгаж, нутгийн өөрөө удирдах байгууллага, улс төрийн нам, эвсэл, мэргэжлийн холбоо, иргэний нийгмийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад уриалсугай. | Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын төслийг боловсруулахад шаардлагатай судалгаа тооцоо мэдээлэл, саналыг хүргүүлж ажилласан.<br><br>Хяналтаас хасуулах санал : санал илгээгдэж бүсчилсэн үзэл баримтлалын төсөл батлагдсан тул хасах саналтай | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 77 | 147 | Иргэдийг орон сууцжуулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-12-27 Дугаар 2023_483 | 2.8.. Иргэд орон нутагт шилжин, тогтвортой суурьших орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор орон сууцны төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх бүс нутгийг тодорхойлж, шаардлагатай газрыг чөлөөлж, олгох арга хэмжээ авч ажиллахыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар (А.Энхманлай), аймгийн Засаг дарга нарт; | Баруун-Урт сумын 3-р багийн нутаг дэвсгэрт “Шинэ тэмүүлэл” хотхон түрээсийн орон сууцны хорооллыг орон нутгаас 2023 онд орон нутгийн 807 сая/төг хөрөнгө оруулалтаар инженерийн шугам сүлжээг шийдвэрлэж өгсөн. Тус хотхон нь нийт 4 блок 224 айлын орон сууцны төсөл бөгөөд Сүхбаатар аймагт борлуулалтандаа анхны хувь лизингийн үйлчилгээг нэвтрүүлж хямд үнэ чанарыг эрхэмлэн нас насны хүүхдийн тоглоомын талбай ногоон байгууламжийг төлөвлөн барьж эхлээд байгаа иж бүрэн хотхоны төсөл юм. Уг төслийг санаачлагч “Голден Би Ти Эс констракшн” ХХК нь захиалагч иргэдэд ипотекийн зээл авахад хүндрэлтэй малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч, шинэ залуу гэр бүлийг дэмжсэн зээлийн хүүгүй хувь лизинг нэвтрүүлж шинэ байртай болох боломжийг бүрдүүлж байна. Уг төсөл арга хэмжээний эхний А блокийн 56 айлын орон сууцыг ашиглалтанд оруулсан. Жилийн эцсийн байдлаар Б блокын угсралтын ажил бүрэн дуусаж, дотрын засын ажил 80 хувьтай 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ашиглалтанд бүрэн орно. | 70% |
| | 148 | | 2.9.. Нийслэл Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, орон нутгийн иргэдийн амьдрах тав тухтай орчныг бий болгох зорилгоор цаашид хот суурин болж хөгжих боломжтой сумдад орон сууц барих талаар шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн болон аймгийн Засаг дарга нарт, шаардагдах санхүүжилтийг тухайн жилийн батлагдсан төсөвт багтаан судлан шийдвэрлэхийг Сангийн сайд Б.Жавхланд; | Сүхбаатар аймгийн хэмжээнд орон нутгийн иргэдийн амьдрах тав тухтай орчныг бий болгох зорилгоор Түмэнцогт, Сүхбаатар, Эрдэнэцагаан сумдаас орон сууц барих боломжтой газрын мэдээллийг авч ажиллаж холбогдох байгууллагад хүргүүлсэн. Мөнххаан суманд 24 айлын орон сууцны барилга хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар баригдаж байна. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Наран суманд төрийн албан хаагчдын орон сууц барих ажлын зураг төсөл боловсруулагдан батлагдахаар ажиллаж байна. | 70% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 149 | | 2.10.. Орон нутаг дахь төрийн үйлчилгээг сайжруулах, төрийн албан хаагчдыг орон нутагт тогтвор суурьшилтай ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор төрийн албан хаагчдад зориулсан орон сууцны төсөл, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн болон аймгийн Засаг дарга нарт, шаардагдах санхүүжилтийг тухайн жилийн батлагдсан төсөвт багтаан судлан шийдвэрлэхийг Сангийн сайд Б.Жавхланд; | Төрийн албан хаагчдын ажлын нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилгоор орон нутгийн төсөвт 600,0 сая төгрөгийг тусган Наран сумандаа шинээр 6 айлын орон сууц барих ажлын зураг төсвийг хийж гүйцэтгүүлж байна.<br>Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын яамны сайд болон 20 гаруй хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Сүхбаатар аймагт 09 дүгээр сарын 27-28-ны өдрүүдэд "Иргэдийн орон сууцжуулах хэлэлцүүлэлгийг хувь болон төрийн хэвшилийн албан хаагчдад зохион байгуулсан. Уг хэлэлцүүлгээр 250 гаруй иргэд болон албан хаагчид хамрагдаж 960 айлын орон сууцны хөтөлбөр, Амгалан гэр хорооллын дахин төлөвлөлт, 3-р багийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөгний хэрэгжилтийг яамны зүгээс дэмжин ажиллахаар шийдвэрлэсэн. | 70% |
| 78 | 150 | Фестиваль зохион байгуулах тухай 2024-01-25 Дугаар 2024_41 | 3. Фестивалийг зохион байгуулахад зохих дэмжлэг туслалцаа үзүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.(1.“Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивалийг жил бүр зохион байгуулж байхаар тогтсугай.) | “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестиваль нь Улаанбаатар хот, Налайх дүүргийн Тайж хайрханы бэлд 2024 оны 08-р сарын 16-18-ны өдрүүдэд зохион байгуулагдлаа. Сүхбаатар аймгаас Удирдамжийн дагуу Дарьганга, Үзэмчин угсаатан ястаны язгуур урлаг, Боловсролын хөтөлбөр, гар урлал үзэсгэлэн, Дарьганга угсаатны соёл, зүүн 3-н аймгийн хамтарсан Сэцэн ханы хурд зүүн бүсийн хурдан морины соёл, уяа сойлго зэргийг таниулан сурталчилах зориулалттай 5-8 ханатай 3-н гэр, бэлтгэн оролцлоо. Ардын урлаг, боловсролын хөтөлбөр, соёлын өвийн арга хэмжээнд 6 ай савын хүрээнд ардын авьяастан, соёлын биет бус өвлөн уламжлагч 13, Жаахан шарга театрын уран бүтээлч 20, гар урлал үзэсгэлэн 4, зохион байгуулалт, аж ахуйн албаны 8 нийт 45 хүний бүрэлдэхүүнтэй оролцлоо. “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивальд оролцоход Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын яам 10 сая, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газар 10 сая, Сүхбаатар аймгийн Засаг даргын тамгийн газраас 20 сая төгрөгний дэмжлэг тус тус үзүүлсэн | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 79 | 151 | Морин хуурын улсын чуулгыг өргөтгөх, морин хуурыг эрхэмлэн дээдэлж, түгээн дэлгэрүүлэх талаар авах арга хэмжээний тухай 2024-02-14 Дугаар 2024_59 | 6.. Энэ тогтоолын хэрэгжилтийг шуурхай зохион байгуулахыг Засгийн газрын холбогдох гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, арга хэмжээний хэрэгжилтийн явц, үр дүнг жил тутам Засгийн газрын хуралдаанд танилцуулж ажиллахыг Соёлын сайд Ч.Номинд тус тус даалгасугай.<br><br>(5.“Морин хуурыг эрхэмлэн дээдэлж, түгээн дэлгэрүүлэх талаар авах арга хэмжээ”-г хавсралт ёсоор баталсугай.) | Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор Төрийн ордонд зохион байгуулсан "Морин хуур үндэсний чуулганд Жаахан шарга театр, 12 сумын Соёлын төвийн дарга нар оролцсон. Баруун Урт сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуультай хамтран бэлэглэлийн морин хуур хийхээр туршилт хийж Билгүүн хээр хэмээх морин хуур 2-ыг урлан, Улаанбаатар хотод болсон гэр үзэсгэлэн, “Нүүдэлчин” фестивальд үзмэр болгон иргэдэд хүргэсэн. Мөн аймгийн удирдах ажилтнуудын зөвлөгөөнд танилцуулсан. Жаахан шарга театр, Асгат, Дарьганга, Баяндэлгэр, Мөнххаан, Уулбаян, Түвшинширээ, Эрдэнэцагаан, Онгон, Түмэнцогт, Халзан сумдын соёлын төвд 64 хүүхэд, 2 насанд хүрэгч морин хуурын дугуйланд хичээллэсэн. ССАЖЗЯ-ны хөрөнгө оруулалтаар Асгат болон Эрдэнэцагаан сумын соёлын төвд тус бүр 2ш морин хуур олгогдсон. Уулбаян, Сүхбаатар, Эрдэнэцагаан, Онгон, Баяндэлгэр, Түмэнцогт, Дарьганга сумдад судалгаагаар 1925 айл өрх морин хуурыг гэртээ залсан байна. | 100% |
| | 152 | | 2. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.4-т заасан арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг гамшгаас хамгаалах алба, бүх шатны Засаг дарга, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагад үүрэг болгосугай.<br>(1.Өвөлжилт хүндэрсэнтэй холбогдуулан зудын эрсдэлийг бууруулах, хаваржилтын хүндрэлийг хохирол багатай даван туулах зорилгоор улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллагыг 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс 05 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд гамшгаас | Гамшгаас хамгаалах тухай хуулийн 271 дүгээр зүйлийн 271.1.1, 271.1.4, 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалт, Улсын Онцгой комиссын даргын 2023 оны 08 дугаар тушаалыг үндэслэн Аймгийн засаг даргын А/692 захирамжаар ослын үеийн удирдлагын 9 бүлгийн 45 хүний бүрэлдэхүүнийг томилгоожуулан шуурхай штабыг аймаг, 13 суманд байгуулан, аймгийн хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэн өвөлжилтийн бэлтгэл бэлэн байдлыг хангуулан үйл ажиллагааг зохион байгуулан удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллаа. Уг ажлын хүрээнд Өвөлжилтийг даван туулах, цаг агаарын аюулт болон гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, хор уршгийг арилгах, салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах зорилгоор аймгийн Шуурхай штабыг байгуулж хуваарь гарган 24 цагаар үүрэг гүйцэтгүүлэн ажиллуусан бөгөөд шуурхай штабт үүрэг гүйцэтгэсэн албан хаагчид УОК-ыг мэдээ мэдээлэлээр ханган ажилласан. Аймгийн засаг даргын А/04, А/198 дугаар захирамжаар зудын гамшигтай тэмцэх хариу арга хэмжээг хэрэгжүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 80 | 153 | Өвөлжилт, хаваржилтын байдал хүндэрсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2024-02-14 Дугаар 2024_62 | 3.1. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг холбогдох Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай: 3.1.Мал аж ахуйн салбарт үүсээд буй нөхцөл байдал, хаваржилтын хүндрэлийг хохирол багатай даван туулах зорилгоор “Малчдадаа тусалъя аян”-ыг үндэсний хэмжээнд зохион байгуулахыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн | Сүхбаатар аймгийн Улаанбаатар хот дах нутгийн зөвлөлөөс сум бүрт 15 тн буюу 600 шуудай хивгийг үнэгүй олгосон. Баруун-Урт сумын нутгийн зөвлөлөөс 100 тн буюу 4000 шуудай хивгийг Баруун-Урт, Эрдэнэцагаан, Халзан, Баяндэлгэр сумдад олгосон. Дэлхийн зөн ОУБ-аас Баруун-Урт сумын 160 малчин өрх, Сүхбаатар сумын 60 малчин өрх, Баяндэлгэр сумын 100 малчин өрх нийт 300 өрхөд өрх тус бүрт 660.0 мянган төгрөг, 200 кг хивэг олгох ажил хийгдэж байна. Баруун-Урт сумдад олгогдсон. Монголын Гандан дэгчлэн хийдээс Баруун-Урт суманд 12 тн хорголжин тэжээл 400 боодол өвс олгосон Японы хүүхдийг ивээх сангаас Халзан, Уулбаян, Түвшинширээ сумдын 150 өрхөд өрх тус бүрт 500.0 мянган төгрөг олгосон Улаан загалмайн хорооноос 8 сумын 200 өрхөд өрх тус бүрт 550.0 мянган төгрөг олгосон. ОУБ Дезерит 200 өрхөд хүнс эрүүл мэнд ахуйн хэрэглээ өрх тус бүрт 450.0 мянган төгрөг олгоно. Аймгийн Засаг даргын тамгын газраас санаачлан "Хамтдаа даван туулья" "Малчдад туслах" аяныг зохион байгуулж хандивын аянд төрийн албан хаагчид 1 өдрийн цалингаа хандивлаж, төрийн бус байгууллагууд болон иргэдээс нийт 57 сая төгрөг цугласанаас туулах чадвар сайтай ЗИЛ-131 маркийн автомашиныг 38 сая | 100% |
| | 154 | | 3.3.. Цасанд боогдсон зам, даваа чөлөөлөх, шар усны үерт өртөж болзошгүй малчин өрхийг нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Онцгой байдлын ерөнхий газар (Г.Ариунбуян), аймгийн Засаг дарга нарт, шаардлагатай хүн, хүч, техник хэрэгслийн дэмжлэг үзүүлж ажиллахыг Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр нарт; | Зэвсэгт хүчний жанжин штабын даргын тушаалаар зудын эрсдэлтэй байгаа аймгуудын малчдад туслах сэргээн босголтын бүлэг Сүхбаатар аймгийн Мөнххаан, Түмэнцогт, Сүхбаатар, Түвшинширээ, Дарьганга, Халзан, Онгон сумдад нийт 127 албан хаагч 14 хоног үүрэг гүйцэтгэсэн. 14 хоногийн хугацаанд 10880 км зам туулж, 37 гэр хашааг нүүлгэж, цасанд дарагдсан гэр хашаа 183 гаргаж, хандив тусламжийн өвс тэжээл хүнсний бүтээгдэхүүн хүргэлт 48 байршилд хүргэн ажилласан байна.<br><br>Хяналтаас хасуулах санал : 2023-2024 оны өвөлжилт хаваржилтийн нөхцөл байдал өнгөрсөн тул хасах саналтай | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 155 | | 3.8.. Орон нутгийн төсвийн давсан орлогыг малчдад туслах арга хэмжээнд зарцуулах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг шуурхай зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг дарга нарт. | Аймгийн нийт нутгаар зуд болж гамшгийн үеийн өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан төсвийн талаар авч хэрэгжүүлэх зохицуулалт, шаардлагын талаар сумдад зөвлөмж чиглэл хүргүүлсэн. Мөн давсан орлогыг малчдад туслах арга хэмжээнд зарцуулах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг шуурхай зохион байгуулахад хийгдэх төсвийн зохицуулалтын хүсэлтийг хүлээн авч, тухай бүр шийдвэрлэн төсвийн хуваарьт өөрчлөлт оруулан аймгийн нэгдсэн төсвийн баазыг эхний 6-н сарын байдлаар нийт 10-н удаа Сангийн яаманд татуулж ажилласан.<br><br>Хяналтаас хасуулах санал : 2023-2024 онд зохион байгуулж өнгөрсөн тул хасах саналтай | 100% |
| 81 | 156 | Өвөлжилт, хаваржилтын хүндрэлийгдаван туулахтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2024-02-28 Дугаар 2024_76 | 2 . Тариалан эрхлэгч аж ахуйн нэгжүүдээс худалдан авах тэжээлийн буудай болон малын тэжээлийн үнэ, татан авах зардлын тооцоо, аймгуудад олгох хуваарийг гаргаж, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, аймгийн Засаг дарга нарт тус тус даалгасугай. | Улс, аймаг сум орон нутгийн Онцгой комисс болон төр, хувийн хэвшил, олон улсын төсөл хөтөлбөр, аймаг сумдын нутгийн зөвлөлөөс 1700 тн үйлдвэрийн тэжээлийг хөнгөлөлттэй болон үнэ төлбөргүй малчдад олгосон. Мөн ХХААХҮСайдын тушаалаар баталсан тэжээлийн улаан буудайнаас эхний ээлжинд 800 тн-ыг Төв аймгийн Угтаал цайдам (Хөдөө аж ауйн корпораци ТӨХХК)-аас татаж Улаанбаатар хотод 45,0 сая төгрөгөөр няцлуулан савлуулсан. 800 тн няцалж, савласан улаан буудайг Төв аймгийн Угтаал цайдамаас Улаанбаатар хот, Улаанбаатар хотоос Баруун-Урт сум хүртэл тээвэрлэн авчрахад 259,2 сая төгрөг зарцуулсан. Тээвэрлэн ирсэн тэжээлийг 5,6 сая төгрөгөөр буулгаж хураасан. Тус 800 тн улаан буудайг сумдад үнэ төлбөргүй олгох ажлыг зохион байгуулсан. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 82 | 157 | Журам батлах тухай 2024-02-28 Дугаар 2024_77 | 3. Энэ журмыг үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын удирдлагуудад тус тус зөвлөсүгэй. (Суурь болон төрөлжсөн мэдээллийн санг цахим хэлбэрээр шинээр үүсгэх, бүтцийн өөрчлөлт оруулах, ашиглалтаас гаргах нөхцөл, бүртгүүлэх журам”) | "Суурь болон төрөлжсөн мэдээллийн санг цахим хэлбэрээр шинээр үүсгэх, бүтцийн өөрчлөлт оруулах, ашиглалтаас гаргах нөхцөл, бүртгүүлэх журам"-ын талаар ЦХХХЯамнаас зохион байгуулсан сургалтад 2024 оны 06 дугаар сарын 07-нд хамрагдаж холбогдох мэдээллийг авч ажилласан. | Х.Б |
| 83 | 158 | Тоггоолын хавсралт өөрчлөн батлах тухай 2024-02-28 Дугаар 2024_82 | 2.. Төрийн албан хаагчдад орон нутагт ажилласны нэмэгдлийг олгоход шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэхийг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. /2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш тайлагнах/ (1.“Журам батлах тухай” Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам”-ыг хавсралт ёсоор өөрчлөн баталсугай.) | Засгийн газрын 2024 оны 02 сарын 28-ны өдрийн 82 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны , үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журам"-ыг сумдын санхүү албаны дарга нар, төсвийн байгууллагуудын нягтлан бодогч нарт хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллах талаар чиглэл , зөвлөмж хүргүүлсэн. Аймгийн хувьд аймаг, сумын орон нутгийн төсвийн байгууллагуудын төрийн албан хаагчид орон нутгийн нийт нэмэгдлийг / улс+ орон нутаг / тухайн албан хаагчийн үндсэн цалингийн 50 хувиар , аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн төрийн захиргаа, төрийн үйлчилгээнийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдлийг 10 хувиар тооцон 2024 оны төсөвт тусган батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн 2025 онд ОНН-ийг өмнөх оны түвшингээс бууруулахгүй байх зарчмыг баримтлан төсвийн тооцоог хийж, аймгийн ИТХурлаар хэлэлцүүлэхээр ажиллаж байна. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 84 | 159 | Журам батлах, журмын хавсралтад өөрчлөлт оруулах тухай 2024-02-28 Дугаар 2024_83 | 3.. Мөнгөн урамшуулал олгоход 2024 онд шаардагдах хөрөнгийг тухайн төрийн захиргааны байгууллагын төсвийн захирагчийн батлагдсан төсөвт багтаан, цаашид жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлж байхыг төсвийн захирагч нар, Сангийн сайд Б.Жавхланд тус тус үүрэг болгосугай. (1.“Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ыг хавсралт | Хөдөө , орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдад олгох урамшууллын судалгааг сум бүрээр тооцон гаргаж, 2024 оны сумын төсөвт тооцон хянасан бөгөөд сумд тухайн урамшууллыг 2024 оны төсөвтөө батлуулж, холбогдох журмын дагуу шаардлага хангасан албан хаагчдад олгон хэрэгжилтийг хангасан. . Мөн аймгийн шууд байгууллагуудын төрийн захиргааны албан хаагчдад олгох урамшууллын тооцоо судалгааг авч, 2024 оны 6-н сард багтаан олгосон. Нийт 6-н байгууллагын 50-н албан хаагчдад 400.8 сая төгрөгийн урамшууллыг олгосон. | 100% |
| 85 | 160 | Тусгай зориулалтаар 2024 онд агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээг тогтоох тухай 2024-03-06 Дугаар 2024_89 | 2. Тусгай зориулалтын ангийн дуудлага худалдааг тухайн жилд агнах, барих амьтны тоо хэмжээний дээд хязгаарт багтаан, холбогдох хуульд нийцүүлэн зохион байгуулахыг аймгийн Засаг дарга нарт [illegible] | СБ аймагт 2024 онд тусгай зориулалтаар агнах ан амьтны тоо батлагдаагүй | Х.Б |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 86 | 161 | Улсын хэмжээнд 2024 онд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт батлах тухай 2024-04-03 Дугаар 2024_136 | 2.. Энэ тогтоолоор баталсан жагсаалтад тусгагдсан байршилд газар эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргахдаа газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системээр дамжуулан хэрэгжүүлэх арга хэмжээ авч, жагсаалтад тусгагдаагүй байршилд газар эзэмшүүлэх, ашиглуулах аливаа шийдвэр гаргахгүй байхыг Засгийн газрын холбогдох гишүүд, аймаг, сум, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. (“Улсын хэмжээнд 2024 онд иргэнд гэр бүлийн хамтын хэрэгцээний зориулалтаар болон төрийн байгууллагад эзэмшүүлэх газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт”-ыг 1 дүгээр хавсралт, “Аж ахуйн зориулалтаар | Засгийн газрын 2024 оны 136 дугаар тогтоол Сүхбаатар аймгийн хэмжээнд 589 нэгж талбарын 2187.53 газрыг иргэн, аж ахуйн нэгж байгууллагад эзэмшүүлж, ашиглуулахаар газрын хэмжээ байршил, зориулалтыг баталсан. Газрын кадастрын системээр дамжуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Аймгийн хэмжээнд 2024 оны 12 дугаар сарын 16-ны байдлаар 219 нэгж талбарын 496.70 га газрыг иргэн, аж ахуйн нэгж байгууллагад олгоод байна. Мөнххаан, Сүхбаатар, Асгат сумдад дуудлага худалдаа зарлагдаад байна. Мөн Эрдэнэцагаан суманд өвөлжөө хаваржааны зориулалтаар олгогдох газарт 236 иргэний хүсэлтийг хүлээн авч ГКМС-д бүртгэгдсэн байна. | 100% |
| 87 | 162 | Газрын тосны бүтээгдэхүүн шилжүүлэн ачих байгууламы, агуулах барих зориулалтаар улсын хилийн зурваст газар | 4.. Газрын тосны бүтээгдэхүүн шилжүүлэн ачих байгууламж, агуулахын төсөл хэрэгжүүлэхтэй холбоотойгоор улсын зурваст нэвтрэх, газар ашиглах болон холбогдох бусад зөвшөөрлийг зохих хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Гаалийн ерөнхий газар (Р.Отгонжаргал), Хил хамгаалах ерөнхий газар (Х.Лхагвасүрэн), Сүхбаатар, Дорноговь аймгийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. | Монгол Улсын аж үйлдвэр эрдэс баялагийн яамнаас ирүүлсэн хамтран ажиллах тухай албан бичгийн хүрээнд улсын зурваст нэвтрэх, газар ашиглах болон холбогдох бусад зөвшөөрлийг зохих хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх хүсэлтийн дагуу аймгийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт сумын тухай жилийн газар зохион байгуулах төлөвлөгөөнд тусган газар олгох арга хэмжээ авах албан бичгийг хүргүүлсэн. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 163 | зурваст газар ашиглуулах 2024-04-10 Дугаар 2024_150 | 5.. Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутаг дэвсгэрт улсын хилийн зурвас газрын хил заагт хамаарахгүй 7.2 га газрыг Газрын тухай хуулийн дагуу шийдвэрлэхийг Сүхбаатар аймгийн Засаг дарга М.Идэрбатад, тогтоолын хавсралтад заасан газрыг Газрын кадастриын мэдээллийн санд бүртгэхийг Газар зохион байгуулалтын, геодези, зураг зүйн ерөнхий газар (А.Энхманлай)-т тус тус даалгасугай | Газар зохион байгуулалтын ерөнхий газраас тухайн газрыг судлан сум орон нутгийн удирдлагуудад танилцуулж 2025 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгахаар төлөвлөж байна. | 70% |
| 88 | 164 | Жагсаалт батлах тухай 2024-04-17 Дугаар 2024_162 | 3□Ерөнхий гэрээний аргаар зохион байгуулах тендер шалгаруулалтад шаардагдах техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, холбогдох бусад материалыг Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч | Улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаар батлагдсан төсөл хөтөлбөрийг техникийн тодорхойлолт боловсруулан, ажлын даалгавар батлуулан, барилгын хөгжлийн төвийн магадлалаар батлагдсан зураг төсвийн дагуу Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэн тендер зарлуулж зөвлөмжийн дагуу гэрээ байгуулан ажиллаж байна. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 89 | 165 | “Шинэ хоршоо хөдөлгөөн” өрнүүлэх тухай 2024-04-24 Дугаар 2024_166 | 3.. “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий ач холбогдол, үр нөлөөг харьяа нутаг дэвсгэртээ сурталчлан таниулах, “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолтой уялдуулан зохион байгуулж, идэвхжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг аймаг, сум, багийн Засаг дарга нарт даалгаж, аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, багийн иргэдийн Нийтийн Хурлын дарга нарт зөвлөсүгэй. | “Шинэ хоршоо” хөдөлгөөний нээлтийн арга хэмжээнд Сүхбаатар аймгаас төрийн байгууллага, арилжааны банкны төлөөлөл, малчид, хоршоологчид нийт 150 төлөөлөгч оролцсон. Мөн “Шинэ хоршоо” хөдөлгөөний багийн гишүүн бэлтгэх сургалтанд аймаг, сумын мэргэжилтнүүд хамрагдсан. Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд улс, бүс, аймгийн 5 арга хэмжээнд аймаг сумдын 600 хоршоодын төлөөлөл, малчид төрийн албан хаагчид оролцсон. Сумдад дэд ажлын хэсэг байгуулагдсан ба ажлын хэсгийн ажиллах төлөвлөгөө батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна багш нар сум багийн уулзалт өдөрлөг арга хэмжээнүүдэд Шинэ хоршоо хөдөлгөөний талаарх төрийн бодлого, хоршоо байгуулах зөвлөмж, аргачлалыг тогтмол өгч ажилласан. Мөн орон нутагт ажиллаж байгаа багийн гишүүдтэй хамтран ажиллаж, малчин өрхүүдээр явах, замчлах, яриа таниулга хийх ажлуудыг хийж байна. 5319 өрхийн 13822 гишүүнд мэдээлэл өгөөд байна. Сүхбаатар аймагт Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд 200 шинэ хоршоо байгуулагдаж, 1800 малчин хоршооны гишүүнээр элссэн байна. ШИНЭ ХОРШОО хөдөлгөөний хүрээнд нийт 190 хоршооны 492 гишүүн малчинд 18 тэрбум төгрөгийн зээлийг ХААН, Төрийн банкаар зээл олгосон. Сүхбаатар, Дарьганга | 100% |
| 90 | 166 | Журам шинэчлэн батлах тухай 2024-04-24 Дугаар 2024_168 | 1.. Энэ журмыг хэрэгжүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхланд тус тус үүрэг болгосугай | Үнэт цаас гаргах хэрэгцээ шаардлага үүсээгүй. | Х.Б |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 167 | Зүй бусаар хорогдсон малын сэг зэм устгах, мал, амьтны халдварт | 1.. Хүн, мал, амьтны халдварт өвчин дэгдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор зүй бусаар хорогдсон малын сэг зэмийг зохих журмын дагуу устгах, орчны цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйтгэл хийх арга хэмжээг 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор зохион байгуулахыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нар болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ нарт тус тус даалгасугай | Аймгийн хэмжээнд Сайдын 02 албан даалгав, Аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/173 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд өвөлжилт, хаваржилтын хүндрэлээр зүй бусаар хорогдсон малын сэг, зэмийг цуглуулах, устгах, бэлчээр, бууц, хашаа хороо, уст цэг, усны эх булгийг цэвэрлэх, халдваргүйтгэх ажил хийгдээд байна. 2024 онд Аймгийн хэмжээнд 1818876 мал хорогдсон бөгөөд, хорогдсон малын 1673091 толгойг буюу 92,0 хувийг цуглуулж, булшлан 1,6сая м.кв талбайг халдваргүйтгээд байна. Энэ арга хэмжээнд нийт: - Малын эмч 31 - Сумын ЗДТГ-аас 249 хүн Орон нутгаас 906 хүн, Зэвсэгт хүчний 40 алба хаагч нийт 1226 хүн хүч. Техник: - Суудлын 98 - Ковш 24 - Экскователр 14 Ачааны 261, бүгд 397 автомашин ажиллаж шатах тослох материалд 472,3 сая төгрөгийг зарцуулаад байна.томилолт болон бусад зардалд 882.7 сая төгрөг нийт 1.3 тэрбум төгрөг зарцуулсан.<br><br>Хяналтаас хасуулах санал : 2023-2024 оны хаваржилт цаг хугацааны хувьд өнгөрсөн тул хасах саналтай | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 91 | 168 | өвчнөөс урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээний тухай 2024-04-24 Дугаар 2024_173 | 2.. Малын сэг зэмийг устгах, ариутгал, халдваргүйтгэл хийх арга хэмжээний зардлыг орон нутгийн төсөвтөө зохицуулалт хийх замаар шийдвэрлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, иргэд, малчидтай орон нутгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсээр дамжуулан байгуулах гэрээт ажлын хөлсийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зохих журмын дагуу гаргахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяад тус тус даалгасугай | Монгол Улсын Засгийн Газрын 2024 оны 02 сарын 28-ний өдрийн 8 дугаар тогтоол, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2024 оны 03 дугаар сарын 01 -ны 02 дугаар албан даалгавар, аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/173 дугаар захирамжын хэрэгжилтийг хангах хүрээнд өвөлжилт, хаваржилтын хүндрэлээр зүй бусаар хорогдсон малын сэг, зэмийг цуглуулах, устгах, бэлчээр, бууц, хашаа хороо, уст цэг, усны эх булгийг цэвэрлэх, халдваргүйтгэх ажил хийгдээд байна. 2024 онд Аймгийн хэмжээнд 1.818.876 мал хорогдсон бөгөөд, хорогдсон малын 1.673.091 толгойг буюу 92,0 хувийг цуглуулж, булшлан 1,6сая м.кв талбайг халдваргүйтгээд байна. Энэ арга хэмжээнд нийт: - Малын эмч 31 - Сумын ЗДТГ-аас 249 хүн Орон нутгаас 906 хүн, Зэвсэгт хүчний 40 алба хаагч нийт 1226 хүн хүч. Техник: - Суудлын 98 - Ковш 24 - Эксковатор 14 Ачааны 261, бүгд 397 автомашин ажиллаж шатах тослох материалд 472,3 сая төгрөгийг зарцуулаад байна.томилолт болон бусад зардалд 882.7 сая төгрөг нийт 1.3 тэрбум төгрөг зарцуулаад байна. Аймгийн ОК-ын 6-р хуралдаанаас 50,0 сая төгрөг, Дэлхийн зөн ОУ-ын байгууллагаас 99,5 сая төгрөгийн бензиний талон зэргийг сумдад | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 92 | 169 | Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай 2024-05-01 Дугаар 2024_187 | 4.б.. Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан 2024 онд мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх зориулалтаар малчдын хоршоонд эзэмшүүлэх газрыг тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж, газар эзэмшүүлэх асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэхийг аймаг, нийслэл, сумын Засаг дарга нарт, тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөлд тухай бүр нь дүгнэлт гаргаж ажиллахыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар (А.Энхманлай)-т тус тус | 2024 оны ГЗБТ-нд тодотголоор Сүхбаатар сум Мал аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалтаар 7 нэгж талбарын 30.2га, Тэжээллийн ургамал тариалах зориулалтаар 10 нэгж талбарын 49.9га, Мөнххаан суманд Мал аж ахуйн үйлдвэрлэл, тэжээлийн ургамал тариалах зориулалтаар 57 нэгж талбарын 264.6га, Дарьганга сум Тэжээллийн ургамал тариалах зориулалтаар 4 нэгж талбарын 5.18га, Халзан сум Мал аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалтаар 2 нэгж талбарын 9.9га, Тэжээлийн ургамал тариалах зориулалтаар 8 нэгж талбарын 1.96га, Түвшинширээ суманд Мал аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалтаар 1 нэгж талбарын 0.3га газрыг тус тус төлөвлөн батлуулсан. Сүхбаатар, Мөнххаан, Халзан, Дарьганга сумд төсөл сонгон шалгаруулалтыг сумын Засаг даргын захирамжаар зохион байгуулж Сүхбаатар суманд 8 хоршоонд 35.2га, Дарьганга суманд 3 хоршоонд 7.59га газрыг олгоод байна. Мөнххаан сум төсөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулж 17 хоршоо шалгарч, газар эзэмшүүлэх Засаг даргын захирамж гаргуулахаар хүлээгдэж байна. | 70% |
| 93 | 170 | Ариун цэврийн байгуулам бүхий түр буудаллах цаг, үйлчилгэний цогцолбор барьж байгуулах тухай 2024-05-01 Дугаар 2024_189 | 2.. Энэ тогтоолын хавсралтад заасан байршилд эзэмшүүлэх газрыг аймаг, сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж, холбогдох хууль тогтоомжийн дагуу эзэмшүүлэх ажлыг 2024 оны 2 дугаар улиралд багтаан зохион байгуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар (А.Энхманлай), аймаг, сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай | Сүхбаатар аймгийн Мөнххаан, Эрдэнэцагаан суманд Ариун цэврийн байгууламж бүхий түр буудаллах цэг, үйлчилгээний цогцолбор барьж байгуулах байршил тогтоогдож, тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан байна.<br><br>Хэрэгжилт удааширсан шалтгаан: Зохион байгуулалтаас | 30% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 171 | – | 4.. Олон улс, улсын чанартай авто зам дагуу ариун цэврийн байгууламж бүхий түр буудаллах цэгийн цэвэрлэгээ, арчлалт, хог хаягдлын асуудлыг зохион байгуулж ажиллахыг холбогдох аймаг, сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай | Сүхбаатар аймагт олон улс, улсын чанартай авто зам дагуу ариун цэврийн байгууламж бүхий түр буудаллах цэг байгуулагдаагүй<br><br>Хэрэгжилт удааширсан шалтгаан: Санхүүжилтээс | 0% |
| 94 | 172 | Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим системийн талаар авах арга хэмжээний тухай 2024-05-08 Дугаар 2024_196 | 3.. “Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим систем”-ийг ашиглан эрхлэх асуудлынхаа хүрээндээ төрийн албан хаагчийн мэдээллийн бүрдүүлэлт, үнэн зөв байдалд хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай | Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн бодлого хариуцсан ахлах мэргэжилтэнд уг эрх нээгдээд байна. Бусад албан хаагчдад одоогоор эрх олгогдоогүй байна. Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 сургалтын үеэр тус системийн танилцуулга, сургалт хийгдсэн ба тус сургалтад албан хаагчид хамрагдсан.<br><br>Хэрэгжилт удааширсан шалтгаан: Урт хугацааны туршид хэрэгжих | 30% |
| 95 | 173 | Цахим шилжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай 2024-05-15 Дугаар 2024_215 | 4.. Төрийн байгууллага хоорондоо төрийн болон албаны нууцад хамаарахаас бусад албан бичгийг илгээх, хүлээн авахдаа албан бичиг солилцооны дундын систем (Docx)-ийг ашиглаж байхыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, шүүх, прокурор, Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог төрийн байгууллагын удирдлагуудад тус тус зөвлөсүгэй. | Аймгийн хэмжээнд 13 сум, агентлаг, төсөвт байгууллагуудад албан бичиг солилцооны дундын системийн талаар 400 гаруй албан хаагчдад сургалт зохион байгуулсан. Аймгийн хэмжээнд нийт 79 байгууллага албан бичиг солилцооны дундын системд холбогдож бусад төрлийн системүүдээс цахимаар албан бичиг хүлээн авах боломжтой болсон. | 70% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 96 | 174 | Түүхэн аялал жуулчлалын бүсийг хөгжүүлэх төлөвлөгөө батлах тухай 2024-05-29 Дугаар 2024_239 | 2. Энэ тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай() | Аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдыг аймаг орон нутагтаа татах үүднээс Уртын голын дагуу Сүхбаатар соёл амралтын хүрээлэнг 2022 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 9 тэрбум төгрөгийн зам, барилгын ажил эхлэж энэ оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 3 тэрбум төгрөгийн ажлыг "Монгол зам" ХХК гүйцэтгээд байна. Сүхбаатар соёл амралтын хүрээлэнд нийтдээ 40 га талбайд эрэг болон зүүн авто замын хооронд 2,5 км урт тохижилт хийгдэнэ. Төлөвлөлт хийх 40 га талбайн 4,1 га-д амрах талбай /задгай театр, мини парк, спорт талбай, тоглоомын талбай, ахмад настан бялдаржуулах, 0,6га-д явган зам, 1,7га-д 2,5 км урт 5 м өргөнтэй дугуйн болон гүйлтийн зам, 20,7га-д ногоон байгууламж, 0,4га-д хиймэл нуур, 0,4га-д үйлчилгээний цэг, 1,0га-д 315 автомашины зогсоол болон дугуйн зогсоол байхаар төлөвлөж гүйцэтгэж байна.Монгол улсад 2024 онд зохион байгуулах олон улсын арга хэмжээний цаглабарт тусгагдсан “Агтана хүрээт” монгол туургатны адуун соёлын их наадам найм дахь жилдээ уламжлал ёсоор 11-р сарын 16, 17 ний өдрүүдэд Шилийн богд уулын ар бэлд “Соёлтой наадая залуучуудын манлайлал” уриан дор амжилттай зохион байгуулагдсан. Соёл урлаг, аялал | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 97 | 175 | Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2025 оны төсвийн хязгаарыг батлах тухай 2024-07-24 Дугаар 2024_10 | 2.. Энэ тогтоолоор баталсан төсвийн хязгаарт нийцүүлэн 2025 оны төсвийн төслийг боловсруулахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. | Аймгийн 2025 оны төсвийн төсөл, 2026-2027 оны төсвийн төсөөллийг дээрх тогтоолоор баталсан төсвийн хязгаарт багтааж , мөн аймгийн хөгжлийн жилийн төлөвлөлттэй уялдуулан боловсруулж, хуулийн хугацаанд Сангийн яаманд тушаалаа. Үүнд: 1. Сумд, байгууллагуудаас ирүүлсэн 2025 оны төсвийн зарлагын саналыг хянаж, төсвийн төлөвлөлтийн Fiscal программд байгууллага, хөтөлбөр, зориулалт, эдийн засгийн ангилал нэг бүрээр оруулж, аймгийн нэгтгэсэн дүнг гарган баазыг Сангийн яаманд татуулсан. 2. Сангийн яамны хариуцсан мэргэжилтэнгүүдтэй уулзаж, холбогдох нэмэлт судалгаа тооцооллыг гаргаж өгсөн. / Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан ТЖАХаагчийн 5-н жилийн тэтгэмжийн судалгаа, Тэтгэвэрт гарах ажиллагсадын судалгаа, орон нутгийн суурь орлого зарлагын судалгаа, шинээр ашиглалтанд орох барилга байгууламжийн судалгаа гэх мэт / 3. Аймгийн орон нутгийн төсвийн байгууллагуудын орон тоо, цалингийн сангийн дэлгэрэнгүй судалгааг нэмэлтээр гаргаж, холбогдох мэргэжилтэнд хянуулсан. Мөн журмын өөрчлөлтөөр ОНН-ийг орон нутаг дах улсын төсвийн байгууллагуудын төрийн захиргааны албан хаагчдад олгох болсонтой | 100% |
| | 176 | | 3.1.. “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоол, “Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аяныг зарлах тухай" Засгийн газрын 2019 оны 476 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд атар газрыг тариаланд шилжүүлэх ажлыг орон нутгийн түвшинд зохион байгуулах; | Хоршоонд олгох 5 га газрыг олгох ажлын хүрээнд иргэдээс болон орон нутгийн удирдлагаас ирүүлсэн саналын дагуу "Номин богд" ХХК-ийн орчимд 10 байршилд буюу нийт 50 га газрыг тэжээлийн ургамал тариалах зориулалтаар олгохоор газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулахаар ГЗБГЗЗЕГ руу дүгнэлт гаргуулахаар хүргүүлсэн боловч тус байршил нь ХХААХҮЯ-ны мэдээллийн санд атар газрын ангилалд байгаа тул олгох боломжгүй гэсэн дүгнэлт гарсан. Тиймээс энэ жилийн хувьд атар газар тариаланд шилжээгүй. | Х.Б |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 98 | 177 | Хөдөө аж ахуйн салбарын 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай 2024-08-07 | 3.2.. Энэ тогтоолын хавсралтаар батлагдсан аймаг, нийслэл, сум, дүүргийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэх, отор нүүдлийг тогтоосон чиглэлийн дагуу явуулах, мал эмнэлгийн хорио цээрийн хяналт шалгалтыг эрчимжүүлж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах; | Аймгийн Засаг даргын 2024 оны “Хөдөө аж ахуйн салбарын болон төв суурин газрын 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтийн бэлтгэл хангах тухай” 06 дугаар албан даалгаврыг сумдад хүргүүлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар аймгийн аюулгүйн нөөцөд 150 тн өвс, 60 тн тэжээл бэлтгэхээс 342 тн өвс, 89.4 тн тэжээл бэлтгэсэн. Сумдын аюулгүйн нөөцөд 780 тн өвс 390 тн тэжээл бэлтгэхээс 784 тн өвс 384 тн тэжээл бэлтгэсэн. Малчдын түвшинд 26509 тн өвс, 117 тн ногоон тэжээл, 427 тн үйлдвэрийн тэжээл, 366 тн гар тэжээл, 476 тн давс хужир шүү бэлтгэсэн. 2024-2025 онд 8538 малчин өрхийн 1754657 толгой мал /бод 398.0, бог 1356.0/ өвөлжиж хаваржих дүн гараад байна.Өөрийн аймгийн бусад сумдын нутагт 978 өрхийн 98.5 мянган толгой мал, хилийн зурвaст 352 өрхийн 223.2 толгой мал, улсын тусгай хамгааллаттай бүс нутагт 264 өрхийн 72.0 мянган толгой мал, өөр аймгийн нутагт 15 өрхийн 6.2 мянган толгой мал өвөлжих урьдчилсан дүн гараад байна. | 100% |
| | 178 | | 3.3.. Улсын тусгай хамгаалалттай болон хилийн зурвас газарт отроор өвөлжиж, хаваржих малчин өрх, малын тооны судалгааг урьдчилан гаргаж, холбогдох төрийн байгууллагын зөвшөөрөл, гэрээний дагуу босоо чиглэлд отроор өвөлжүүлж, хаваржуулах ажлыг зохион байгуулах; | Аймгийн Засаг даргын 2024 оны “Хөдөө аж ахуйн салбарын болон төв суурин газрын 2024-2024 оны өвөлжилт, хаваржилтийн бэлтгэл хангах тухай” 06 дугаар албан даалгаврыг сумдад хүргүүлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Эрдэнэцагаан, Дарьганга, Наран, Онгон, Баяндэлгэр сумдын хилийн зурвас газарт хилийн хамгаалалтад туслах хүчний гэрээтэй тэр хавидаа нутагладаг 300 гаруй өрхийн 200 мянга гаруй мал өвөлжих урьдчилсан тооцоололтой. Өөрийн аймгийн бусад сумдын нутагт 978 өрхийн 98.5 мянган толгой мал, хилийн зурвaст 352 өрхийн 223.2 толгой мал, улсын тусгай хамгаалалттай бүс нутагт 264 өрхийн 72.0 мянган толгой мал, өөр аймгийн нутагт 15 өрхийн 6.2 мянган толгой мал өвөлжих урьдчилсан дүн гараад байна. Өвөлжилтийн нөхцөл байдал хэвийн, хүндрэл гараагүй байна | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 179 | 2024-08-07 Дугаар 2024_28 | 3.4.. "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ий хүрээнд хэрэгжүүлэх төслийг орон нутгийн хөгжлийн болон бэлчээр ашиглалт, газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдуулан мал аж ахуйн салбарын үндсэн хөрөнгө, бүтээн байгуулалтын чиглэлд хандуулах; | 2024 оны 4 дүгээр улирлын байдлаар Дарьганга, Сүхбаатар сумдад 9 хоршоонд нийт 48 га газрыг олгосон байна.Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төслийн хүрээнд мал эмнэлгийн зориулалтаар 1. бог малын эхо аппарат-13 ширхэг, 2. малын эм, био бэлдмэл хадагалах зориулалттай хөргөгч-13 ширхэгийг тус тус нийлүүлэгч"Атар-ирээдүй" ХХК-аас 161,2 сая төгрөгөөр худалдан авч аймгийн Засаг даргын "Хөрөнгө бүртгэж, эзэмшүүлэх тухай" А/474 захирамжаар сумдын Мал эмнэлгийн тасгуудад хүлээлгэн өгсөн. Мөн улсын төсвийн 237,9 сая төгрөгийг хөрөнгөөр мал эмнэлгийн хяналт, ариутгалын пунктын лабораторид 41 нэр төрлийн тоног төхөөрөмж худалдан авч, Мал эмнэлгийн газарт эзэмшүүлсэн. | 70% |
| 180 | | 3.7.. Арилжааны зориулалтаар байгалийн хадлан бэлтгэх гэрээ байгуулсан иргэн, аж ахуй нэгжийн гэрээний гүйцэтгэлд хяналт тавих, гэрээг дүгнэх, хадлангийн талбайг цэвэрлүүлэх арга хэмжээ авахыг Сүхбаатар аймгийн Засаг дарга М.Идэрбат, Дорнод аймгийн Засаг даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Ёл нарт. | Аймгийн Засаг даргын 2024 оны "Байгалийн хадлан тэжээл бэлтгэх ажлын хэсэг байгуулах тухай" А/486 дугаар захирамжийн хэрэгжилтийг ханган, хяналт тавин ажиллаж байна. Эрдэнэцагаан суманд 138 малчин 33630 га газарт, Асгат суманд 3 иргэн 600 га газарт, Дарьганга суманд 2125 га-д 14 салаа хадланд гарсан бөгөөд үүний 2 салаа нь Онгон, Уулбаян сумаас гарч, тус тус хадлан хадах гэрээг сумын Засаг даргатай байгуулсан. Аймгийн хэмжээнд Асгат, Дарьганга, Эрдэнэцагаан сумдад нийт 36355 га талбайд 155 хадлангийн салаа өвс хадасан. Эдгээр сумд газрын нэгдмэл сангийн ангилалд бүртгэгдсэн хадлангийн талбайд 5 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн хадлан дуустал мал бэлчээрлэхийг хориглосон шийдвэрийг малчдад хүргэж ажиллсан. Мөн арилжааны зориулалтаар байгалийн хадлан бэлтгэх гэрээ байгуулсан иргэн, аж ахуй нэгжийн гэрээний гүйцэтгэлд хяналт тавихаар сумдууд ажлын хэсэг томилон хадлангийн талбайг цэвэрлүүлсэн. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 181 | | 4.. Энэхүү тогтоолд заасан арга хэмжээг батлагдсан төсөвтөө багтаан зохион байгуулж, хэрэгжилтийг ханган ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын холбогдох агентлагийн дарга нарт үүрэг болгосугай. | Аймгийн Засаг даргын 2024 оны “Хөдөө аж ахуйн салбарын болон төв суурин газрын 2024-2024 оны өвөлжилт, хаваржилтийн бэлтгэл хангах тухай” 06 дугаар албан даалгаврыг сумдад болон холбогдох байгууллага, аж ахуй нэгжид хүргүүлсэн. Албан даалгаварын хэрэгжилтийг хангуулахаар, хяналт тавьж, мэргэжлийн байгууллагыг үүрэгжүүлэн ажиллуулж байна. хүндрэлтэй нөхцөл байдал үүсээгүй байна. | 100% |
| 99 | 182 | Цэргийн дүйцүүлэх алба хаах иргэдийн тооны дээд хязгаарыг тогтоох тухай 2024-08-28 Дугаар 2024_52_1 | 2.. Цэргийн дүйцүүлэх албыг зохих журмын дагуу зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. | Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 52 дугаар тогтоолын дагуу 20 иргэнийг цэргийн дүйцүүлэх албанд элсүүлсэн. | 100% |
| 100 | 183 | Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг батлах, эрх олгох тухай 2024-09-04 Дугаар 2024_65_1 | 2. Энэ тогтоолоор баталсан солбицол бүхий талбайд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах эрх олгох арга хэмжээ авахыг Сүхбаатар аймгийн Засаг дарга М.Идэрбатад | Засгийн газраас батлагдсан солбилцолоор Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах зөвшөөрлийг аймгийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн А/525 дугаар захирамжаар "Монгол зам групп" ХХК-д олгосон, мэргэжлийн байгууллагууд болон холбогдох сумд захирамжийн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Авто замын ажлуудын явц, гүйцэтгэл дундаж хувь 65%-тай, ирэх онд ашиглалтад оруулахаар ажил гүйцэтгэх | 100% |
| | 184 | | 1.1.. Тухайн нутаг дэвсгэрийнхээ нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайд суурилуулсан болон аж ахуйн нэгж, байгууллагын гадна орчны теле камерыг нэгдсэн сүлжээнд холбох, хяналт тавих чиг үүрэг бүхий “Теле камерын хяналтын дэд төв”-ийг холбогдох хууль тогтоомжийн дагуу аймаг, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дэргэд байгуулах ажлыг удирдан зохион байгуулж ажиллахыг аймаг, дүүргийн Засаг дарга нарт; | "Теле хяналтын камерын дэд төв"-ийг Засгийн газрын 86 дугаар тогтоолын дагуу аймгийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/668 дугаар захирамжаар Баруун-Урт сумын Засаг даргын Тамгын газрын дэргэд байгуулж, аймгийн Цагдаагийн газарт байрлаж байсан дэд төвийг Баруун-Урт сумын 7-р багийн нутаг дэвсгэрт байрлах "Дөрвөлж" ОНӨААТҮГ-ын эзэмшлийн байрны 1 дүгээр давхарт нүүлгэн шилжүүлсэн. Теле камерийн ашиглалт, нууцлалыг цагдаагийн газарт хариуцуулахаар үохион байгуулалтын арга хэмжээ авсан. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 101 | 185 | Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээний тухай 2024-09-18 Дугаар 2024_86-1 | 1.3. Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайд суурилуулсан болон аж ахуйн нэгж, байгууллагын гадна орчны теле камерыг Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа теле камерын стандартад нийцүүлэх, мэдээлэл холбоо, сүлжээний үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын дэд бүтцийг ашиглан “Теле камерын хяналтын дэд төв”-д холбох боломжийг судалж, шийдвэрлэхийг аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт; | Аймгийн Засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн А/420 дугаар захирамжаар гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, байгууллагын гадна орчны аюулгүй байдлыг хангах зорилгоор МУ-ын стандарт теле хяналтын системийн ерөнхий шаардлага MNS6423:2019 хангасан камер суурилуулах ажлыг зохион байгуулж, аймгийн хэмжээнд нийт 368 ширхэг хяналтын камер, аймгийн төв, сумдад ашиглагдаж байгаа 1070 ширхэг камерыг бүртгэлийн нэгдсэн системд бүртгэх ажил хийгдсэн. Цагдаагийн газарт байсан “Теле камерын хяналтын дэд төв”-ийг Баруун-Урт сумын ЗДТГ-ын дэргэд байгуулах тухай аймгийн Засаг даргын 2024 оны А/668 дугаар захирамж гарч, шийдвэрлэгдсэн. | 100% |
| | 186 | | 2.. Теле камерын хяналтын төвүүдийн үйл ажиллагаа болон энэ тогтоолын 1.3-т заасан ажлыг зохион байгуулахад шаардагдах зардлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу орон нутгийн төсвөөс санхүүжүүлж байхыг аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга | Аймгийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/668 дугаар захирамжаар “Теле камерын хяналтын дэд төв”-ийг Баруун-Урт сумын ЗДТГ-ын дэргэд байгуулж, техник хэрэгслийн хадгалалт хамгаалалт, ашиглалтын үйл ажиллагааг тус газар хариуцахаар шийдвэрлэсэн. “Камерын хяналтын дэд төв”-ийн техник, тоног төхөөрөмж, засвар үйлчилгээ, холболт хийх ажлын зардалд 20.000.000 төгрөгийг Баруун-Урт сумын ЗДТГ шийдвэрлэсэн. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 187 | | 4.Теле камераар цуглуулсан мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мэдээллийг хуульд зааснаас бусад тохиолдолд ашиглахгүй байх нөхцөлийг бүрдүүлж, эрсдэлээс хамгаалах шаардлагатай арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгож, шүүх, прокурор, Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог төрийн байгууллагын удирдлагуудад тус тус зөвлөсүгэй. | Сүхбаатар аймгийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/668 дугаар захирамжаар "Теле камерын хяналтын дэд төв"-ийг Баруун-Урт сумын ЗДТГ-ын дэргэд байгуулсантай холбоотойгоор холбогдох төрийн байгууллагуудад мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мэдээллийг хуульд зааснаас бусад тохиолдолд ашиглахгүй байх талаарх зөвлөмжийг хүргүүлж ажилласан. | 100% |
| 102 | 188 | Ёс зүйн хэм хэмжээ батлах тухай 2024-10-02 Дугаар 2024_109_1 | 2. Байгууллагын дотоод журмыг энэ тогтоолын хавсралтаар баталсан ёс зүйн хэм хэмжээнд нийцүүлэн батлан хэрэгжүүлэх, Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллахыг төсвийн шууд захирагч нарт үүрэг болгосугай | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ"-г батлах тухай 109 дүгээр тогтоолыг төрийн байгууллагын дарга, удирдлах албан тушаалтнуудад танилцуулан, Байгууллагын дотоод журмыг энэ тогтоолын хавсралтаар баталсан ёс зүйн хэм хэмжээнд нийцүүлэн батлан хэрэгжүүлэх, Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллахыг | 70% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 103 | 189 | Журам батлах тухай “Төрийн нууцад хамаарах худалдан авах ажиллагааг зохицуулах журам” 2024-10-09 Дугаар 2024_120_1 | 2.. Энэ тогтоолын хавсралтаар баталсан журмыг (Төрийн нууцад хамаарах худалдан авах ажиллагааг зохицуулах журам) үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг холбогдох төсвийн байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч, төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлагад тус тус үүрэг болгосугай.<br><br>(3.Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр, Тагнуулын ерөнхий | Журмын хэрэгжилтийг ханган ажиллах талаар төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлагуудад чиглэл өгсөн ба хэрэгжилтийг хянаж байна. | 70% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 104 | 190 | Улсын хэмжээнд 2024 онд эзэмшүүлэх, ашиглуулах зарим газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт батлах тухай 2024-10-23 Дугаар 2024_131_1 | 2. 2.Энэ тогтоолоор баталсан жагсаалтад тусгагдсан байршилд газар эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргахдаа холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг баримталж, Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системээр дамжуулан хэрэгжүүлэх арга хэмжээ авч, Засгийн газрын 2024 оны 136 дугаар, 74 дүгээр тогтоолууд болон энэ тогтоолоор баталсан жагсаалтад тусгагдаагүй байршилд газар эзэмшүүлэх, ашиглуулах аливаа шийдвэр гаргахгүй байхыг Засгийн газрын холбогдох гишүүд, аймаг, сум, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. | 2024 онд тогтоолоор баталсан жагсаалтад тусгагдаагүй байршилд газар эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гараагүй | 100% |
| 105 | 191 | ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦАХИМ ШИЛЖИЛТИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2024-11-13 Дугаар 2024_163 | 2. 2.Төрийн захиргааны байгууллагын албан хэрэгцээнд ашиглах баримт бичиг боловсруулах программ хангамжийн лицензийг Ерөнхий гэрээгээр худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу нэгдсэн журмаар зохион байгуулахыг Монгол Улсын Шадар сайд Т.Доржхандад, холбогдох зардлыг төсвийн багцдаа тусган санхүүжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус үүрэг болгосугай. | төсөвт тусгах талаар төлөвлөж байна | Х.Б |
| ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 106 | 192 | 2021 оны 6 дугаар сарын 8-ны өдөр 34 дүгээр тэмдэглэл 2021-06-08 Дугаар 2021_34 | YIII.5.2 . Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд оролцох тэгш эрхийг хамгаалж, холбогдох хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг эрхэлсэн салбар, харьяалах нутаг дэвсгэртээ хангуулах, хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолын дагуу 2023 онд “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комисс”-н бүрэлдэхүүнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөллийн оролцоог хангаж нийт 10 байгууллагад үнэлгээ хийж, хүлээн авсан. Чойбалсан хотын 86 жилийн ой, ""Алдар гавьяаны өдөр""-ийг тохиолдуулан найрамдал хотуудын хөгжлийн “НӨХӨРЛӨЛ-2024” хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн олон улсын Параспортын 9 төрөлт тэмцээнд аймгаас нийт 10 тамирчин оролцож, 1 алт, 4 мөнгө, 4 хүрэл медаль хүртсэн. Улаанбаатар хотод болсон хараагүй иргэдийн параспортын их наадамд аймгаас нийт 10 хүн оролцож, 1 алт, 4 мөнгө, 7 хүрэл медаль хүртсэн. Аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбооны үйл ажиллагааг дэмжиж жил бүр Засаг даргын үйл ажиллагаанд 10 сая төгрөг тусгаж, байрны урсгал зардлыг орон нутгийн төсвөөс гарган санхүүжүүлж байна. Мөн 2024 оны орон нутгийн сонгуулиар шинээр сонгогдсон аймгийн иргэдийн төлөөлөгчийн хурлын төлөөлөгч, аймаг орон нутаг, агентлаг, төсөвт байгууллагын удирдлагуудад сургалт нөлөөллийн ажил хийж, ХБИ-ийн уулзалт хийж санал хүсэлтийг авч дараагийн боллого төлөвлөлтөд тусгахаар төлөвлөн | 70% |
| 107 | 193 | 2021 оны 12 дугаар сарын 8-ны өдөр 63 дугаар тэмдэглэл 2021-12-08 Дугаар 2021_63 | XY.3.1.3. Орон нутгийн түвшинд өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн өсөлтийн шалтгааныг судалж, холбогдох зохицуулалт, арга хэмжээ авахад санаачилга гарган ажиллахыг бүх аймгийн засаг дарга нарт; | Сүхбаатар аймгийн түвшинд өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн өсөлтийн шалтгааныг судалж Монополын эсрэг газарт сар бүрийн 10,25-ний өдөр мэдээлэн ажиллагаа. Цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалсан аймгийн засаг даргын эрх зүйн хэм хэмжээний актуудыг тухай бүр гаргуулж ажилласан. Өвс тэжээлийн хөнгөлөлтийн захирамж, мах, махан бүтээгдэхүүний, сурагч хүүхдийн дүрэмт хувцасны үнийн судалгаа, өвс тэжээлийн зах залийн үнийн мэдээллийг цаг алдалгүй тухай бүр цуглуулж Монополын эсрэг газар мэдээлсэн. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 108 | 194 | 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 28 дугаар тэмдэглэл 2022-05-11 Дугаар 2022_28 | XX.7. . Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br><br>Үүнтэй холбогдуулан 2022 оны 9 дүгээр сард багтаан бүх иргэдийг тоон гарын үсэгтэй болгох, тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгаланд, тоон гарын үсгийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, бүх | 2024 оны 11 дүгээр сарын байдлаар e-mongolia.mn системээр дамжуулан 998, Хаан банкаар дамжуулан 2200, Улсын бүртгэлийн хэлтсээр дамжуулан 20,000 гаруй нийт 23,198 иргэнд тоон гарын үсэг олгосон нь аймгийн 16 ба түүнээс дээш насны нийт иргэдийн 52.1%-ийг эзэлж байна. | 70% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 109 | 195 | 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдөр 33 дугаар | XIII.1. .<br>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, өнөөгийн нөхцөл байдлын талаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:<br><br>1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалахтай холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт даалгав:<br><br>1.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд болон салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, хяналт тавих. Хөгжлийн | Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөл үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд 10,0 сая төгрөг засаг даргын нөөц хөрөнгөнөөс 10,0 сая төгрөг төсөвлөж, компьютер, принтер зэргийг авч өгсөн. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс 2024 онд нийт 22 удаа хуралдаж, 216 хүүхэд орсноос 24 хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэйг тогтоож, 44 хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэйг шинээр тогтоож, 143 хүүхдийн байнгын асаргааг сунгаж, 2 хүүхдийн асаргаа биеийн байдал эдгэрсэн тул цуцлагдаж, 3 хүүхдийн оношийг баталгаажуулсан. ЭХЭМҮТ, УНТЭ, УХТЭ, ХБХСЗТ-тай хамтран хөгжлийн бэрхшээлтэй 27 хүүхдийг эрүүл мэндийн цогц үзлэг шинжилгээнд хамруулсан. Эрүүл мэндийн 16 байгууллагаар сэргээн засах эмчилгээнд давхардсан тоогоор хөгжлийн бэрхшээлтэй 420 хүүхдэд эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 405 эцэг эх, асран хамгаалагчдад сургалт зохион байгуулсан. Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн ажлын хүрээнд Жайка старт 2 төслийн мэргэжилтнүүд болон аймгийн БШУГ-н дарга мэргэжилтнүүдийн хурал,ХБХБЭМНХСК-н гишүүд, Баруун-Урт сумын 4-р сургууль, 11 цэцэрлэгийн | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 169 | 196 | дугаар тэмдэглэл 2022-06-15 Дугаар 2022_33 | XIII.1.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх нийгмийн халамж, хөгжлийн үйлчилгээг сайжруулахтай холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт даалгав:<br><br>4.1. байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч, ажил хөдөлмөр эрхлээгүй байгаа эцэг, эсхүл эх, хууль ёсны асран хамгаалагчийн эрүүл мэндийн даатгалын болон тэтгэврийн даатгалын шимтгэлийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцож улсын төсвөөс төлөх боломжийг судлан санал... | Байнгын асаргаа шаардлагатай ХБХ асарч буй хүүхдийг асарч буй хөдөлмөрийн насны, ажилгүй 245 иргэний нийгмийн даатгалын шимтгэлийг төрөөс төлсөн. Нийгмийн халамжийн тэтгэвэр, байнгын асаргаа шаардлагатай ХБХ-дэд олгох тэтгэмжийг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлсэн. Засгийн газрын 122 дугаар тогтоолын дагуу 2024 оны 04 дүгээр сараас эхлэн нийгмийн халамжийн тэтгэвэр, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд олгох тэтгэмжийг сар бүр 375000 төгрөгөөр тогтоосныг мөрдөж байна. ХБХ-ээ асарч буй 40 хүнд 2 удаа сэтгэл зүйч эцэг, эх сэдэвт сургалт зохион байгуулсан. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний сэргээн засах үйлчилгээнд 8 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, бүлгийн төсөлд 2 хүүхдээ асарч буй эх эцэг хамрагдсан. Хөгжлийн бэрхшээлтэй 15 хүүхдэд протез, ортопед, тусгай хэрэгслийг захиалан олгосон. Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдал” /DET/ сургалтыг аймгийн Засаг даргын дэргэдэх хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах орон тооны бус салбар зөвлөлийн гишүүд, Аймгийн болон Баруун-Урт сумын ИТХурлын төлөөлөгчид, төр захиргааны болон төрийн үйлчилгээ үзүүлэгч албан байгууллагуудын удирдлага, ажилтан... | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 110 | 197 | 2022 оны 8 дугаар сарын 24-ний өдөр 42 дугаар тэмдэглэл 2022-08-24 Дугаар 2022_42 | ХҮ.3. . Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааны явцын талаар Эрүүл мэндийн сайд С.Энхболд Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br><br>Үүнтэй холбогдуулан хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг эрчимжүүлэхийг Эрүүл мэндийн сайд С.Энхболдод, уг үйл ажиллагаанд салбарын болон төрийн бүх шатны байгууллагуудын ажилтан, албан хаагчдыг хамруулах, энэ | Халдварт бус өвчний Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 42258/26502/62.7%, Чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 28479/18687/65.6% байна. Хөхний өмөнгийн эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 13109/9547/73 хувь, умайн хүзүүний эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 4609/2497/54.1 хувь хамрагдсан. Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн дунд 9 дүгээр сард Халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэг оношилгоог сайжруулах 1 сарын аян зарласан. Аяны үр дүнд халдварт бус өвчний АГ-н эрт илрүүлэг үзлэг 12%, ЧШ өвчний эрт илрүүлэг үзлэг 11.4%, Умайн хүзүүний эрт илрүүлэг үзлэг 17.2%, Хөхний эрт илрүүлэг үзлэг 13.6%-иар нэмэгдсэн байна. Үзлэгт хамрагдсан 11960 иргэнд артерийн даралтыг зөв хэмжих, даралтны эм тогтмол уух, эрт илрүүлэг үзлэгийн ач холбогдлын талаарх сургалт сурталчилгааг зохион байгуулж, аяны хүрээнд 15 эрүүл мэндийн байгууллага цахим хуудсандаа 15 төрлийн мэдээ мэдээллийг байршуулан, ард иргэдэд түгээсэн. "Цусны даралт ихсэлтийн эсрэг аян 2024" Аяны хүрээнд 3523 хүнд Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж, 1001 хүнийг төрөлжсөн нарийн мэргэжлийн эмчийн | 70% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 111 | 198 | 2022 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр 54 дүгээр тэмдэглэл 2022-11-09 Дугаар 2022_54 | X.12.2. “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн 10 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлж төрийн өмчийн бүх шатны боловсролын сургалтын байгууллагын болон шинжлэх ухааны байгууллагын газар эзэмших, ашиглах эрхийг батлагдсан аргачлалын дагуу үнэлүүлэх талаар шаардлагатай арга хэмжээг авч, дүнг танилцуулахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав. | Харьяа боловсролын нийт 40 байгууллагын газар эзэмших, ашиглах эрхийг батлагдсан аргачлалын дагуу үнэлүүлсэн. Шинээр ашиглалтад орсон 3-р сургуулийн газар БШУГ-ын нэр дээр байсныг шилжүүлэх хүсэлт аймгийн ГХБХБГ-т өгсөн. | 100% |
| 112 | 199 | 2022 оны 12 дугаар сарын 7-ны өдөр 58 дугаар тэмдэглэл 2022-12-07 Дугаар 2022_58 | XXI.6.1. Төрийн байгууллагын баримт бичгийг цахим хэлбэрээр солилцох нөхцөлийг бүрдүүлсэн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:<br><br>1. Албан бичиг солилцооны дундын системийг ашиглах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, албан баримт бичгийг цахим хэлбэрээр солилцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, бүх шатны төрийн байгууллагын удирдлагад үүрэг | 2024 онд Аймгийн засаг даргатай сумдын засаг дарга, агентлаг, төсөв байгууллагын дарга нартай төрийн ажил үйлчилгээг төлөөлөн гүйцэтгэх гэрээ, "Цахим Сүхбаатар" дэд хөтөлбөрт тусгагдсаны дагуу дотоод үйл ажиллагааны удирдлагын системд бүртгэлтэй байгууллагуудыг албан бичиг солилцооны дундын системийн сургалтыг 13 сум, агентлаг, албадад зохион байгуулж нийт 400 гаруй албан хаагчдийг хамруулллаа. Сургалтаар албан бичгийн хэвлэмэл хуудасыг цахим хэлбэрт шилжүүлэх, албан бичиг боловсруулалт төлөвлөлт, docx системд токен үүсгэх, цаг бүртгэлийн тохируулга, хүний нөөцийн модулийн талаар дэлгэрэнгүй мэдээллийгн өгч ажиллалаа. 2024 оны 11 дүгээр сарын байдлаар аймгийн хэмжээнд docx.gov.mn системд нийт 79 байгууллага бүртгүүлж токен үүсгэн төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системд холболтоо хийн албан бичиг хүлээн авах, илгээх боломжтой болсон. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 113 | 200 | 2023 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр 4 дүгээр тэмдэглэл 2023-01-18 Дугаар 2023_4 | VIII.2.3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд орон нутгийн өмчит байгууллагаас татан төвлөрүүлсэн автомашиныг цаашид зайлшгүй шаардлагатай байгаа орон нутгийн өмчит хуулийн этгээдэд шилжүүлэх, худалдах, актлах ажлыг зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт. | Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс орон нутгийн өмчит байгууллагаас татан төвлөрүүлсэн автомашиныг зайлшгүй шаардлагатай байгаа орон нутгийн өмчит хуулийн этгээдэд шилжүүлэх, худалдах, актлах ажлыг зохион байгуулахын тулд Аймгийн ИТХ-ын төлөөлөгчдөөр хэлэлцүүлж шийдвэрлэсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолын 1,2,3 дүгээр заалт, Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайдын хамтарсан 2022 оны 95/260 дугаар тушаал, Сүхбаатар аймгийн Засаг даргын 2023 оны А/454 дүгээр захирамжийн дагуу автомашины хэрэглээг хуулиар хязгаарласантай холбогдуулан төрийн үйлчилгээ, тусгай хэрэгцээний автомашин, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд ашиглах автомашинаас бусад орон нутгийн өмчид бүртгэлтэй автомашины үйлчилгээний тоо төрлийг тогтоон, журамд зөвшөөрөгдөөгүй, илүүдэлтэй, 39 тээврийн хэрэгслийн татан төвлөрүүлж үүнээс орон нутгийн өмчит байгууллагууд балансаас баланс руу 2 хөрөнгө шилжүүлсэн. Цаашид ашиглах боломжгүй 2 тээврийн хэрэгсэл актлаж бусад | 100% |
| 114 | 201 | 2023 оны 2 дугаар сарын 1-ний өдөр 6 дугаар тэмдэглэл 2023-02-01 Дугаар 2023_6 | XIY.1.3. Төрийн байгууллагууд болон зөвлөх үйлчилгээний захиалгаар хийлгэсэн судалгааны ажлын тайланг судалгааны нэгдсэн сангийн системд байршуулах, хянах, засварлах, хэрэглэгчийн саналыг хүлээн авах ажлыг холбогдох албан тушаалтанд хариуцуулж ажиллуулахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар, төрийн болон төрийн өмчийн оролцоот хуулийн этгээд, компани, үйлдвэрийн газрын удирдлагад; | Гадаадын хөрөнгө оруулалттай болон Төрийн байгууллагуудын зөвлөх үйлчилгээний захиалгаар Сүхбаатар аймагт хийгдсэн судалгааны ажлуудыг нэгтгэн авч цахим системд нийт 9 төрлийн судалгааг бүрэн оруулаад байна. Системд байршуулсан судалгааны мэдээллийг 2024 оны 11 дүгээр сарын байдлаар 9827 иргэн үзэж, 3789 удаа татаж авсан байна. Аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-ээс ирүүлсэн чиглэлийн дагуу хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны хүрээний түүврийг гарган ажилласан ба Улсын хэмжээнд сар бүрт хийж улирлаар үр дүнг тооцдог өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа, ажиллах хүчний судалгаа болон статистикийн тухай хуульд заагдсан амьдрах орчны аюулгүй байдлын судалгааг анх удаа, нийгмийн үзүүлэлтийн судалгаануудыг амжилттай зохион байгуулан ажилласан. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 115 | 202 | 2023 оны 3 дугаар сарын 1-ний өдөр 10 дугаар тэмдэглэл 2023-03-01 Дугаар 2023_10 | XVI.4.2. Мал, амьтны гоц халдварт шүлхий, бог малын мялзан өвчний дэгдэлтийг таслан зогсоох мал эмнэлгийн цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт. | "Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад Мал эмнэлгийн ерөнхий газраас 145,800 м/т, Мал эмнэлгийн газрын нөөцөд байсан 29м/т нийт 174,800м/т вакцинаар 55 ажлын хэсэгт удирдах ажилтан-54 малын эмч-60 санитарч-17 туслах ажилтан-36 жолооч-52 нийт-224 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг гарч 8149 өрхийн 173849 үхэр, 174 гахай нийт 174015 толгой мал хамрагдахаас 4486 өрхийн 160150 үхэр, 142 гахай таригдаж 92.1%-ийн гүйцэтгэлтэй дууссан. Мялзан өвчин 6 дугаар сараас 9 сарын 23 хүртэлх хугацаанд Дарьганга, Эрдэнэцагаан сумдад гарсан. Дарьганга суманд 3 өрхийн 39 хурга, 13 хонь, 55 ишиг, 31 ямаа, нийт 138 толгой мал өвчилснөөс 78 хорогдож 60 мал шинж тэмдэг арилсан. Эрдэнэцагаан суманд 1 өрхийн 22 хурга, 5 хонь, 20 ишиг нийт 47 мал өвчилснөөс 2 хорогдож 45 малын шинж тэмдэг арилсан. Мялзан өвчнийг таслан зогсоохоор өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 45 ажлын хэсэгт удирдах ажилтан-42 малын эмч-48 санитарч-32 туслах ажилтан-39 жолооч-43 нийт-249 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг гарч 5118 өрхийн 1699800 толгой бог мал хамрагдахаас өнөөдрийн байдлаар 5118 өрхийн 1692988 толгой мал | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 116 | 203 | 2023 оны 3 дугаар сарын 07-ний өдөр 11 дугаар | XII.5. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон салбарын бодлого, стратегийн төлөвлөгөө, Жендэрийн үндэсний хорооны 2023 оны ээлжит хуралдаанаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллахыг Засгийн газрын гишүүд, яамдын жендэрийн салбар зөвлөл, орон нутгийн салбар хорооны дарга, Жендэрийн үндэсний хорооны гишүүдэд тус тус даалгав. | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар хорооны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд Жендэрийн үндэсний хорооны төлөвлөгөөнд үндэслэн боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Жендэрийн үндэсний хорооны тогтоолын дагуу аймгийн Жендэрийн салбар хорооны дарга, нарийн бичгийн даргын ажлын байранд үнэлгээ хийж, холбогдох санал дүгнэлтийг Жендэрийн үндэсний хороонд хүргүүлэв. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр орон нутагт үйл ажиллагаа явуулж буй аймгийн Залуучуудын холбоо, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо, Ахмадын холбоо зэрэг иргэний нийгмийн байгууллалага , НҮБ-ын хүүхдийн сан, Японы хүүхдийн ивээх сан, хөтөлбөртэй хамтран ажиллаж байна. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд заасны дагуу Жендэрийн эрх тэгш байдлыг хангах зарим арга хэмжээг иргэний нийгмийн байгууллагатай хамтран гүйцэтгэхээр харилцан санал солилцож байна. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, төрийн албан хаагчдын мэдлэг, мэдээллийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалтыг агентлаг, төсөвт байгууллага, сумдын ЗДТГазар, НҮБ-ын хүүхпдийн сан, Японы хүүхдийн ивээх сан төсөлтэй хамтран зохион байгуулж байна. Төрийн | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 116 | 204 | дүгээр тэмдэглэл 2023-03-07 Дугаар 2023_11 | XII.2.1. Хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамрагдалтын явц, амны хөндийн эрүүл мэндийн өнөөгийн байдлын талаар Эрүүл мэндийн сайд С.Чинзориг Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:<br><br>1.Хүн амыг эрт илрүүлэг, үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг эрчимжүүлэх, аймаг, нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа эрүүл мэндийг дэмжих төвүүдийг ходоодны уян дурангийн аппаратаар нэмэлтээр хангахыг Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, аймаг, нийслэлийн Засаг дарга | Хүн амыг эрт илрүүлэг, үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг орон нутгийн түвшинд зохион байгуулж байна. 2024 оны 11 дүгээр сарын байдлаар 18-с дээш насны эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 41565/12476 буюу 30,0 хувийн хамрагдалтай байна. | 70% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 117 | 205 | 2023 оны 3 дугаар сарын 22-ний өдөр 3 дугаар тэмдэглэл 2023-03-22 Дугаар 2023_13 | IV.2. Нийслэл Улаанбаатар хот, аймаг, сумын төв, бусад суурин газрын хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөлт хийгдээгүй байршилд болон иргэн, аж ахуйн нэгжийн эзэмшиж байгаа газар нь улс, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд өмчлүүлэхээр тусгагдаагүй газарт газар өмчлүүлэх, улсын тусгай хэрэгцээний болон бусдын эзэмшиж, ашиглаж байгаа газартай давхцалтай газарт иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргахгүй байхыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд | Хууль тогтоомж зөрчсөн захирамж шийдвэр гараагүй байна | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 118 | 206 | 2023 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр 17 дугаар тэмдэглэл 2023-04-19 Дугаар 2023_17 | XIX.2.3. Хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн зөрчлийг арилгуулахаар Хүний эрхийн үндэсний комиссын гишүүнээс гаргасан шаардлага, зөвлөмжийг биелүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд болон бүх шатны Засаг дарга нарт тус тус үүрэг болгов | 2024 онд Хүний эрхийн Үндэсний Комисс 1 удаа эрүүлжүүлэх, саатуулах байр, баривчлах байрны үйл ажиллагаатай танилцсан байна. 2024 онд Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос тус аймгийн Засаг даргад 1 шаардлага, 1 зөвлөмж ирснийг хүлээн авч, биелэлтийг хангаж, тухай бүр хариуг эргэн мэдээлж ажилласан. Үүнд: 1. 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 02/07 дугаартай Хүүхдийн эрхийн тухай хууль, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн конвенц, Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн “Хурдан морины уралдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 57 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх, холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох тухай шаардлагын хүрээнд аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн Б/16 дугаар захирамжаар хориглосон хугацаанд харьяалах нутаг дэвсгэрт нь хурдан морины уралдаан зохион байгуулагдсан Онгон сумын Засаг дарга Ө.Мөнхбатад Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.2-т заасны дагуу “нийт ажилтанд зарлах хэлбэрээр нээлттэй сануулах” сахилгын шийтгэл оногдуулж, хүүхдийн эрхийн улсын байцаагчаас хориглосон хугацаанд хурдан морины усэргээ зохион байгуулсан 5 хүнд | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 119 | 207 | 2023 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр 18 дугаар тэмдэглэл 2023-04-26 Дугаар 2023_18 | XIV.7.3. Ой, хээрийн түймэр, болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээлэл, анхааруулгыг олон нийтэд тогтмол хүргэж, бэлэн байдлыг хангуулж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав. | Эрдэнэцагаан суманд Хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2024 оны 04 дүгээр сарын 04-ны өдрөөс эхлэн 2024 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийг хүртэл хугацаанд Онцгой байдлын газраас 5 алба хаагч, Эрдэнэцагаан сумын ЗДТГ-ын 18 алба хаагч, 5 автомашин тус тус хамтран түймэр гарах эрсдэлтэй Эрдэнэцагаан сумын Хөндлөн хайлааст 1-р баг, Хонгор 3-р баг, Бадрах 4-р баг, Жаргалант 6-р баг, Хадын булан 7-р багийн Уртын цагаан, цоржин, Хангай, Шудалдай уул, Нүхт, Хөшөөт, Хэрэстэй хоолой, Шилийн цагаан, Оросын айраг, Энгэр шанд, Бор өнлөр, Модон гуу, зэрэг газруудад хаваржиж байгаа 230 малчин өрхийн 806 иргэнд брошур, гарын авлага тарааж айл өрхийн 3-н үгт хаяг байршил, утасны дугааруудыг бүртгэж хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж өгч, тээврийн хэрэгслийн галын аюулгүй байдал хангах, үнс нурмаа ил задгай газар асгахгүй байх талаар зөвлөн туслах үйлчилгээ өгч, what 3 words апплейкшний ач холбогдол ажиллах зарчмын талаар мэдээлэл хүргэж нийт 1.368.000 төгрөгийг урьдчилан сэргийлэх ажилд зарцуулж ажилласан. | 100% |
| | 208 | 2023 оны 5 | XVIII.2.3. Монгол Улсын хөгжлийн бодлого, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хүний хөгжил, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд эерэг үр нөлөөтэй байхад чиглүүлэн бодитой, үр дүнтэй хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав. | ХБТТУТ хуулийн дагуу үр дүнд суурилсан төлөвлөлтийн арга зүйгээр батлагдсан журмын аргачлалын дагуу аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө, аймгийн ЗДҮАХ болон таван жилийн үндсэн чиглэлийн баримт бичгийг боловсруулж байна. Энэ хүрээнд хөгжлийн зорилт арга хэмжээ бүр хүний хөгжил, эдийн засаг, нийгэм байгаль орчинд гарч буй эерэг өөрчлөлтийг хэмжих үзүүлэлт буюу шалгуур үзүүлэлтээр биелэлтийг хэмжихэд анхаарч байна. Ингэснээр хөгжлийн үр дүнг хангах үр дүн, арга хэмжээг төлөвлөж, тэдгээрийг хэмжих шалгуур үзүүлэлтийн дагуу биелэлтээ хянаж, хэмжиж байна. Төсвийг бүрэн энэ тал руу чиглүүлэхэд ахиц дэвшил гарч байна | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 120 | 209 | 2023 оны 5 дугаар сарын 17-ны өдөр 21 дүгээр тэмдэглэл 2023-05-17 Дугаар 2023_21 | XVIII.3.3. Газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангах асуудлын хүрээнд газрын тосны хайгуул, судалгааны ажлыг эрчимжүүлж, шинээр нөөцийг тогтоох үйл ажиллагааг бүх талаар дэмжиж ажиллах, газар ашиглуулах шийдвэр гаргаж, гэрээг байгуулж ажиллахыг Дорнод аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн, Сүхбаатар аймгийн Засаг дарга М.Идэрбат, Дорноговь аймгийн Засаг дарга О.Батжаргал, Өмнөговь аймгийн Засаг дарга Р.Сэддорж нарт. | Газрын тос дамжуулах чиг, чигийн дагуух зурвас газар, газрын тос олборлох хоолойн нь Сүхбаатар аймгийн Баяндэлгэр, Халзан, Асгат, Баруун-Урт сумдын нутаг дэвсгэрийг дамжин өнгөрч байна. Иймд Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны төрийн нарийн бичгийн дарга, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар ерөнхий газрын дарга, аймгуудын Засаг дарга нарын хороонд байгуулах гурвалсан гэрээний төсөлтэй танилцан холбогдох газарт саналыг хүргүүлж ажилласан. | 100% |
| 121 | 210 | 2023 оны 5 дугаар сарын 24-ний өдөр 22 дугаар тэмдэглэл 2023-05-24 Дугаар 2023_22 | XXI.5.3. Гамшгийн улмаас хорогдсон малын сэг, зэм булшлах, устгах ажлыг шуурхай зохион байгуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, аймгийн Засаг дарга нарт тус тус даалгав. | Монгол Улсын Засгийн Газрын 2024 оны 02 сарын 28-ний өдрийн 8 дугаар тогтоол, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2024 оны 03 дугаар сарын 01 -ны 02 дугаар албан даалгавар, аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/173 дугаар захирамжын хэрэгжилтийг хангах хүрээнд өвөлжилт, хаваржилтын хүндрэлээр зүй бусаар хорогдсон малын сэг, зэмийг цуглуулах, устгах, бэлчээр, бууц, хашаа хороо, уст цэг, усны эх булгийг цэвэрлэх, халдваргүйтгэх ажил хийгдээд байна. 2024 онд Аймгийн хэмжээнд 1.818.876 мал хорогдсон бөгөөд, хорогдсон малын 1.673.091 толгойг буюу 92,0 хувийг цуглуулж, булшлан 1,6сая м.кв талбайг халдваргүйтгээд байна. Энэ арга хэмжээнд нийт: - Малын эмч 31 - Сумын ЗДТГ-аас 249 хүн Орон нутгаас 906 хүн, Зэвсэгт хүчний 40 алба хаагч нийт 1226 хүн хүч. Техник: - Суудлын 98 - Ковш 24 - Экскoватор 14 Ачааны 261, бүгд 397 автомашин ажиллаж шатах тослох материалд 472,3 сая төгрөгийг зарцуулаад байна.томилолт болон бусад зардалд 882.7 сая төгрөг нийт 1.3 тэрбум төгрөг зарцуулаад байна. Аймгийн ОК-ын 6-р хуралдаанаас 50,0 сая төгрөг, Дэлхийн зөн ОУ-ын байгууллагаас 99,5 сая төгрөгийн бензиний талон зэргийг сумдад | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 122 | 211 | 2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөр 23 дугаар тэмдэглэл 2023-05-31 Дугаар 2023_23 | XXII.2.. “Шил ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br><br>Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, холбогдох мэдээлэл хариуцагч байгууллагын удирдлагуудад тус тус үүрэг болгов:<br><br>1.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан байнга ил тод, нээлттэй байлгах мэдээллийг өөрийн | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны “2023-2024 оныг авлигатай тэмцэх жил болгон зарлах тухай” 49 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны “Шил ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” 01 дүгээр болон 2024 оны “2024 оны эхний хагас жилд хэрэгжилтийг эрчимжүүлэх төсөл, арга хэмжээний тухай” 01 дүгээр тус тус албан даалгаврыг хэрэгжүүлэх хүрээнд аймгийн агентлаг, төсөвт байгууллага, сумдын ЗДТГазрын нээлттэй мэдээлэл, шинэчлэх байршуулах албан хаагчдын мэдээллийг авч холбогдох байгууллагад хүргүүлэн shilen.gov.mn 2.0 системд эрхүүдийг нээлгэж, системийн хэрэглэгчдэд зориулсан 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн цахим сургалтын талаар мэдээллийг албан бичгээр хүргүүлж нийт 30 гаруй байгууллагын албан хаагчдыг хамруулллаа. 2024 оны хагас жилд 37 байгууллага системд бүртгэлтэйгээс 16 байгууллага тайлан илгээж, 3 байгууллага бүртгэсэн, 17 байгууллага огт тайлан илгээгээгүй байна. Тус арга хэмжээг эрчимжүүлэх чиглэлээр сум, агентлаг, албадад 2 удаа чиглэл хүргүүлж холбогдох арга хэмжээг авч ажилласан. 2024 оны 12 дугаар сарын байдлаар нээлттэй мэдээллийн нэгдсэн системд 37 байгууллага бүртгэлтэйгээс хагас жилийн | 70% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 123 | 212 | 2023 оны 6 дугаар сарын 14-ний өдөр 25 дугаар тэмдэглэл 2023-06-14 Дугаар 2023_25 | XIII.5.2. 2. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийг ард иргэд, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг аймаг, дүүргүүдэд зохион байгуулахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, | Энэ онд Алсын хараа 2050-н хүрээнд бүх багийн засаг дарга нарт сургалт зохион байгуулагдсан. Удирдлагын академитай хамтран 2 өдөр нийт 67 багийн Засаг дарга нарт сургалт зохион байгуулж Алсын хараа 2050 бодлогын баримт бичгийг сурталчлан таниулах ажлыг хэрэгжүүлсэн. Мөн 10-р сард Удирдлагын академитай хамтран “Монгол улсын хөгжлийн бодлого, хэрэгжилт: үр дүнд суурилсан төлөвлөлт, гүйцэтгэл” цахим танхим хосолсон сургалтыг орон нутгаас бэлтгэгдсэн 4 сургагч багш аймаг, сумын холбогдох 82 албан хаагчийг хамруулан зохион байгууллаа. Уг сургалтаар Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр хэрхэн боловсруулах арга зүй, үр дүнд суурилсан төлөвлөлтийн шинэ аргачлал, мөн түүнд уялдсан стратеги төлөвлөгөө, гүйцэтгэлийн төлөвлөгөө хэрхэн боловсруулах талаар мэдлэг ойлголтыг өгсөн.<br><br>Хяналтаас хасуулах санал : тухайн ажил арга хэмжээ хийгдэж, холбогдох тайлан мэдээ зааасан хугацаанд илгээгдсэн тул хасах саналтай | 100% |
| | 213 | | XIII.5.3. Зөвлөлдөх уулзалтад оролцогчдын манлайллаар “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийг сурталчлан таниулах, санал авах хурлыг баг, хороо бүрд зохион байгуулж, хурлуудаас гарсан бүтээлч санал, санаачилгыг нэгтгэн шалгаруулж, тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав. | “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийг сурталчлан таниулах, санал авах хурлыг баг, хороо бүрд зохион байгуулж, холбогдох мэдээллийг ЗГХЭГ-т хүргүүлсэн.<br><br>Хяналтаас хасуулах санал : ЗГ-аас чиглэл болгосны дагуу арга хэмжээг зохион байгуулж холбогдох тайлан мэдээллийг хүргүүлсэн тул хасах саналтай | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 214 | | XIII.10.. “Цахим аймаг” бодлогын зөвлөмжийн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br><br>Үүнтэй холбогдуулан “Цахим аймаг” бодлогын зөвлөмжийг аймаг, нийслэл, сум, дүүрэгт хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад, бодлогын дэмжлэг үзүүлж ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нарт тус тус даалгав. | Цахим хөгжил, харилцааны холбооны яамнаас гаргасан цахим аймаг бодлогын зөвлөмжийн дагуу “Цахим Сүхбаатар” хөтөлбөрийн ажлын хэсгийг Аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн А/570 захирамжаар 11 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, хөтөлбөрийг ажлын хэсгийн бүрэлдэхүүнээр 2 удаа хэлэлцэж хөтөлбөр, ажлын төлөвлөгөөний боловсруулалтыг хийж гүйцэтгэсэн. 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн ээлжит хуралдаанд "Цахим Сүхбаатар" дэд хөтөлбөрийг танилцуулан батлуулсан . Уг хөтөлбөрийн хэрэгжилтийг 2024-2026 онд хэрэгжүүлэхээр тусгасан ба тус хөтөлбөрийн зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар агентлаг албадын дарга, холбогдох мэргэжилтнүүдэд танилцуулах үйл ажиллагааг 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулж 126 албан хаагчийг хамруулж ажиллалаа. “Цахим Сүхбаатар” дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах чиглэлээр 2024 оны 09 сарын 06-ны 04/1023 тоот албан бичгээр хөтөлбөр, шалгуур үзүүлэлтийн хамтаар сумд,агентлаг, албадад төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системээр дамжуулан хүргэж, хэрэгжилтийг хангуулахаар | 70% |
| | 215 | | XVIII.8.1. 1. Ургац хураалтын ажлыг шуурхай зохион байгуулах, ургацыг цаг агаарын гамшигт үзэгдэл болон малаас хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахыг тариалан бүхий аймгийн Засаг дарга нарт; | 2024 онд Сүхбаатар сумын “Дорнод шим агро” ХХК 10 га тариалангийн талбайг малын хөлөөс хамгаалах зорилгоор хашаалсан. Ургац хураалтын ажил хэвийн явагдсан | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 124 | 216 | 2023 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр 39 дүгээр тэмдэглэл 2023-09-26 Дугаар 2023_39 | XVIII.1.1. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авахыг холбогдох Засгийн газрын гишүүд, барилга байгууламжийн захиалагч нарт даалгав: 1.2024 онд шилжэн хэрэгжих төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд тавих хяналтыг эрчимжүүлж, гэрээт ажлын тоо хэмжээ, гүйцэтгэлийг хянаж, үнийн өсөлтийг бодитойгоор тооцож, дүгнэхийг захиалагч нарт; | 2024 онд шинээр хэрэгжих болон шилжин хэрэгжиж буй 19 төсөл арга хэмжээ, 2024 онд санхүүжих дүн 28787,3 сая төгрөг үүнээс эхний 10 сарын байдлаар 8170,4 сая төгрөгийн гүйцэтгэлтэй буюу 28,4 хувийн хэрэгжилттэй. 2 төсөл арга хэмжээний тендер зарлагдан гүйцэтгэгч тодроогүй байна. 2024 онд төсвийн хуулиар шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ их байсан ба зарим төсөл арга хэмжээнд 2-4 удаа тендер шалгаруулалт зарлаад гүйцэтгэгч орж ирэхгүй байсан мөн төсөл арга хэмжээнүүд нь магадлалаар батлагдсан зураг төсөвгүйгээс тендер шалгаруулалт оройтож зарлагдан хөрөнгө оруулалтын ажлуудын гүйцэтгэл удаашрах нөхцөл болж байна. | 70% |
| | 217 | | XVIII.1.2. Хуульд заасан хугацаанд хэрэгжээгүй, 2023 онд ажлын гүйцэтгэл дутуу барилга байгууламжийн гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хүрээнд гүйцэтгэлийг 2023 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар дүгнэж, зайлшгүй шаардлагатай бол гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авахыг захиалагч нарт | 2023 онд огт ажил хийгдээгүй Баяндэлгэр сумын 300 суудалтай соёлын төвийн барилга угсралт, Дарьганга зусланг орчин үеийн стандартад нийцсэн аялал жуулчлалын цогцолбор болгон шинэчлэх ажил гэсэн 2 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг цуцлан дуусгавар болгохоор аймгийн Засаг даргын хугацаатай албан бичгийг хүргүүлсэн. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 218 | | XVIII.1.4. Зураг төсөл зохиогч, гүйцэтгэгчийн буруутай үйл ажиллагааны улмаас хуулиар тогтоосон хугацаанд ашиглалтад оруулаагүй зохиогч, гүйцэтгэгчийн тусгай зөвшөөрлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хүчингүй болгох арга хэмжээ авахыг тусгай зөвшөөрөл олгосон төрийн захиргааны төв байгууллагуудад, зураг төсөл зохиогч, гүйцэтгэгчийг хар жагсаалтад оруулахыг Сангийн сайд Б.Жавхланд, холбогдох мэдээллийг Сангийн яаманд хүргүүлж ажиллахыг захиалагч | Дарьганга сумын зуслангийн тохижилт, шугам сүлжээний ажил, Баяндэлгэр сумын 300 хүний суудал бүхий соёлын төв, Боловсролын яамтай гэрээтэй Эрдэнцагаан, Баяндэлгэр сумын 200 хүүхдийн цэцэрлэг нь он дамжин гүйцэтгэгч байгууллагын санхүүгийн чадавхи, ажиллах хүчний дутагдалтай байдал гүйцэтгэгчийн буруутай үйл ажиллагаанаас болж тус 4 төсөл арга хэмжээнд зогсонги байдалд байна. Иймд холбогдох газруудад мэдэгдэл хүргүүлэн гэрээ цуцлах ажлыг хийж гүйцэтгэсэн. одоогоор Сангийн яаманд хар жагсаалтад явуулах саналыг хүргүүлээгүй байна. | 70% |
| | 219 | | XVIII.1.10. Зураг төсөл нь батлагдсан, газар эзэмших, ашиглах зөвшөөрөлтэй, инженерийн дэд бүтэц нь шийдэгдсэн барилга, байгууламжийн төслийг улсын төсвөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналд тусгаж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт; | Улсын төсвийн хуульд санал болгож буй барилга байгууламжуудын ажлын зураг төслийн урьдчилан хийж магадлалаар баталгаажуулан Сангийн яамны цахим системд шивэлт хийх ажлын тогтмол хугацаанд хүргүүлэн хэвшсэн. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 125 | 220 | 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдөр 40 дүгээр тэмдэглэл 2023-10-04 Дугаар 2023_40 | 2.6. Ипотекийн зээлийг орон нутаг руу түлхүү чиглүүлэх, шилжин суурьшиж байгаа нарийн мэргэжлийн ажилтныг орон сууцаар хангах асуудлыг судлан үзэж, арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, аймгийн Засаг дарга нарт; | Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлагдсан Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж буй болон эрэлттэй мэргэжлээр шилжин ирж суурьшиж буй төрийн албан хаагчдад орон сууцны дэмжлэг үзүүлэх ажлыг 2023 оноос зохион байгуулан нийт 7 багш нарт тус бүр 20 сая, эрүүл мэндийн салбарт ажиллаж буй 2 сувилагч гэр бүлд тус бүр 10 сая төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлээд байна. 2024 онд Баруун-Урт сумын 7 багт Баяншарга өргөө ХХК барьж гүйцэтгэсэн 29 айл, Голден би ти эс ХХК Шинэ тэмүүлэл хотхоны 56 айл, Хатантуул хөгжил ХХК Хос өргөө хотхон 84 айл, Онц оргил констракшн ХХК Соёмбо хотхон 75 айлын орон сууцны барилга угсралтын ажил гүйцэтгэгдэн шинээр ашиглалтад ороод байна. 248 айлын орон сууцны барилга ашиглалтад ороод байна.Ипотикийн зээлийг орон нутаг руу түлхүү чиглүүлэх, шилжин суурьшихтай холбоотойгоор Сүхбаатар аймгийн хэмжээнд орон нутаг руу шилжин суурьшиж ипотикийн 3 хувийн зээлд хамрагдсан 9 өрх байна. | 70% |
| | 221 | | 2.22. Улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлдэг мал эмнэлгийн ажил, үйлчилгээний үнэ тарифыг шинэчлэх асуудлыг судалж шийдвэрлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Сангийн сайд Б.Жавхлан, аймаг, нийслэлийн Засагдарга нарт; | Сангийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын хамтарсан 2024 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн "Мал эмнэлгийн үйлчилгээний зарим зардлын норматив батлах тухай тушаалын хавсралтад өөрчлөлт оруулах тухай" А/116, А/418 дугаар тушаал гарсан. Тус тушаалд үйлчилгээний хөлсийг бод малд 1000 төгрөг, бог малд 350 төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоосон. Орон нутгийн төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх мал эмнэлгийн ажил, үйлчилгээний үнэ тарифыг шинэчлэх асуудлыг аймгийн ИТХ-аар оруулж хэлэлцүүлэхээр Мал эмнэлгийн газар бэлтгэл ажлаа хангаж ажиллаж байна. | 70% |
| | 222 | | 2.28. Аймаг, сумын баяр наадам тэмдэглэх зардлыг нэмэгдүүлэх боломжийг судлан, саналаа холбогдох төрийн захиргааны төв байгууллагад танилцуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | Аймаг , сумын баяр наадам тэмдэглэх зардлыг нэмэгдүүлэх саналыг 2024 оны төсвийн төсөлд тусган 2023 оны 8 дугаар сард Сангийн яаманд хүргүүлсэн. 2024 оны төсөвт сумдын баяр наадмын зардлыг өмнөх оноос нэг дахин нэмэгдүүлж хянасан. Аймгийн баяр наадмын төсвийн холбогдох тооцооллыг хийж ИТХурлаар хэлэлцүүлэн , тухайн зардлыг 2024 оны төсөвт 350.0 сая төгрөгөөр батлуулсан. 2024 оны 3 дугаар сард уг зардлыг нэмэгдүүлэх санал болон судалгааг Сангийн яаманд хүргүүлсэн болно. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 223 | | 2.94. Энэ тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар (Б.Баасандорж)-т, хэрэгжилтийн явц, тайланг хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нээлттэй цахим системд оруулж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.” гэжээ. | Тус тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг даалгаварыг холбогдох сум агентлаг, нэгжид хуваарилан, хэрэгжилтэнд хяналт үнэлгээ хийж, хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр холбогдох албан тушаалтанд үүрэг чиглэл өгч ажилласан ба хэрэгжилтийн явц тайланг хугацаанд системд оруулан тайлагнаж байна. Үйл ажиллагааны хэрэгжилт үр дүнг сайжруулах зорилтын хүрээнд Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс сумдад бүсчилсэн хэлбэрээр мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалт зохион байгуулсан. Мөн Удирдлагын академаас зохион байгуулсан "Үр дүнд суурилсан бодлого, төлөвлөлт" сургалтад 4 мэргэжилтэн хамрагдаж сургагч багш болсон ба сум, агентлагийн нийт 80 албан хаагчдад төлөлвлөлт, хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр сургалт зохион | 100% |
| 126 | 224 | 2023 оны 10 дугаар сарын 11-ний өдөр 41 дүгээр тэмдэглэл 2023-10-11 Дугаар 2023_41 | XVII.1. Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлын асуудалд хяналт тавьж, хог хаягдалгүй, цэвэр орчин бүрдүүлэх үр дүнтэй арга хэмжээг шуурхай авч, хэрэгжүүлж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт | Аймгийн хэмжээнд бүх нийтийн нэгдсэн цэвэрлэгээг жилд 2 удаа нийт 26 удаа цэвэрлэгээг хийж нийт 7000 иргэн, 306 ААНБ хамрагдаж 1200 тн хог хаягдлыг цэвэрлэж хог хаягдлыг хогийн нэгдсэн цэгт төвлөрүүлсэн байна. Мөн шинээр 87 ширхэг ангилан ялгадаг хогийн сав нийтийн эзэмшлийн гудамж талбайд байршуулсан байна. Цэвэрлэгээнд нийт 34.8 сая төгрөг зарцуулагдсан. Мөн зүй бусаар хорогдсон мал амьтны сэг зэмийг цуглуулж устгах, орчны цэвэрлэгээ халдваргүйтгэлийг хийх аймгийн Засаг даргын А/173 тоот захирамжийн хэрэгжилтийг хангаж аймгийн хэмжээнд 1818876 мал хорогдсоныг 300 гаруй төлөвлөсөн цэгт 1.673.091 мал цуглуулж устгах булшилж, ариутгал халдваргүйтгэлийг устгалын цэгийн 1.6 сая м2 талбайд хийсэн. Дээрх ажилд 1244 хүн, 397 техник ажилласан мал амьтны сэг зэм устгалын ажилд түлш шатахуунд нийт 472.3 сая томилолтын бусад зардалд 882.7 сая төгрөг нийт 1.3 тэрбум төгрөг зарцуулагдсан байна. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 127 | 225 | 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр 45 дугаар тэмдэглэл 2023-11-08 Дугаар 2023_45 | XI.1.1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй, хэрэгжээгүй зорилт, арга хэмжээний шалтгаан нөхцөлийг судалж, төлөвлөсөн хугацаа, үр дүнг тооцож, хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав; | Хагас жилийн байдлаар давхцалтай хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн судалгаа жагсаалтыг заалтыг системээс хасуулахаар Хяналтыг хэрэгжүүлэх газарт хүргүүлсэн. Сар бүр системд нэмэгдсэн заалтуудыг холбогдох газруудад хуваарилж, хугацаа өнгөрсөн заалтуудыг хяналтаас хасаж байна. Мөн тайлангийн ирц, чанарын талаар тодорхой заалтуудад дүгнэлт зөвлөмж бичииж байна. Хагас жилээр үнэлж бүх байгууллага, сумдад зөвлөмж хүргүүлсэн. | 100% |
| 128 | 226 | 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдааны 48 дугаар тэмдэглэл 2023-11-29 Дугаар 2023_48 | XIX.2. Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй шийдвэрт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн үр дүнгийн тайлангийн дүгнэлтийн хүрээнд ач холбогдлоо алдаж дагаж мөрдөхгүй болсон, эрх зүйн үйлчлэлийн хугацаа дууссан, хууль тогтоомжтой давхардсан, зөрчилдсөн шийдвэрүүдийг хүчингүй болгох арга хэмжээ авч Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэх, хуулиар тусгайлан эрх олгогдсон боловч Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлээгүй 81 шийдвэрийг зохих журмын дагуу бүртгүүлэх арга хэмжээг тус тус 2024 оны 1 дүгээр улиралд багтаан авахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны | умын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргаас баталсан захиргааны хэм хэмжээний актуудын хуульд нийцүүлэх, зөрчлийг арилгах ажлын хүрээнд 2011 оноос 2024 онуудад сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргаас баталсан захиргааны хэм хэмжээний актуудын судалгаа, түүврийг гаргаж, шийдвэрүүдийн хуулбарыг авч хянасан. Судалгаанд 13 сумын мэдээлэл нэгтгэгдсэн бөгөөд нийт дүнгээр нь авч үзвэл сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 46, Засаг даргаас 3, нийт 49 захиргааны хэм хэмжээний акт баталсан бөгөөд эдгээрийн 51.1% нь хүчин төгөлдөр бус буюу ХЗДХЯ-д хянагдаагүй, улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдээгүй гэсэн судалгаа гарсан. Захиргааны хэм хэмжээний актыг хуульд нийцүүлэх, шинээр батлах, хэрэгжилтийг хангахад хууль зөрчихөөс сэргийлж, 13 сум тус бүрт 30 хоногийн хугацаатай зөвлөмж боловрсуулан 2024.04.12-ны өдөр Хууль, эрх зүйн хэлтсийн даргын албан бичгээр хүргүүлэн, зөвлөмжийн биелэлтийн хариуг авч нэгтгэсэн. Зөвлөмж хүлээн авсан 13 сумаас 7 сум зөвлөмжийг хэрэгжүүлсэн талаар албан бичгээр хариу ирүүлсэн бөгөөд Асгат, Баяндэлгэр, Сүхбаатар, Түмэнцогт, Халзан, Эрдэнэцагаан сумд хариу ирүүлэх талаар утсаар удаа дараа | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 129 | 227 | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 49 дүгээр тэмдэглэл 2023-12-06 Дугаар 2023_49 | XIII.2. Зарим аймагт өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрч байгаатай холбогдуулан гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан, аймаг, нийслэлийн Онцгой комиссын дарга нарт үүрэг болгов.” | Гамшгаас хамгаалах тухай хуулийн 271 дүгээр зүйлийн 271.1.1, 271.1.4, 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалт, Улсын Онцгой комиссын даргын 2023 оны 8 дугаар тушаалыг үндэслэн Аймгийн засаг даргын А/692 захирамжаар өвөлжилтийг даван туулах, цаг агаарын аюулт болон гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, хор уршгийг арилгах, салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах зорилгоор аймгийн Шуурхай штабыг байгуулж хуваарь гарган 24 цагаар үүрэг гүйцэтгүүлэн ажиллаж УОК-ыг мэдээ мэдээлэлээр ханган ажиллаж банйа2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрөөс 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэн ажилласан.<br><br>Хяналтаас хасуулах санал : 2023-2024 оны өвөлжилтийн нөхцөл байдал хугацааны хувьд өнгөрсөн тул хасах саналтай | 100% |
| | 228 | | XVI.5.2. Нөөцийн махны бэлтгэх, зарцуулах үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, аймаг, нийслэлийн Засагдарга нарт даалгав | Баруун-Урт суманд мах боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй Дарьт шүтээн ХХК, Өндөр хамар хоршоо, Түмэн цагаа хоршоотой эрүүл ахуй, аюулгүй байдал хангасан махны нөөц бүрдүүлэх гэрээ хийх ажлыг зохион байгуулсан. Тус 3 газартай Хүнс, хөдөө аж ахуйн газар гэрээ хийж нийт 40,0 тонн махыг бэлтгэн нөөцөлж 2024 оны 04-06 дугаар саруудад өөрсдийн нэрийн дэлгүүр болон үйлдвэрлэлийн байран дээрээс зах зээлд худалдан борлуулсан. Нөөцийн махны хомсдол үүсээгүй | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 229 | | XXV.4.3. Орон нутгийн иргэдийн эрт илрүүлэх үзлэгт хамрагдалтыг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав | 2024 оны 4 дүгээр сарын 5-с Эрүүл мэндийн сайдын тушаалын дагуу эрт илрүүлэг үзлэг шинжилгээг эрчимжүүлэх зорилгоор “Цэргийн төв эмнэлгийн” нарийн мэргэжлийн эмч нар сумдад үзлэг шинжилгээг хуваарийн дагуу амжилттай зохион байгуулан ажилласан.Нийт 9 суманд үзлэг шинжилгээг зохион байгуулж 2151 иргэнийг үзлэг шинжилгээ, оношилгоонд хамруулсан. Мөнххаан суманд-240 • Уулбаян сум-242 • Түвшинширээ сум -120 - Баяндэлгэр сум-550 - Халзан сум-50 - Онгон сум-274 - Дарьганга сум- 199 - Наран сум - 195 - Эрдэнэцагаан сум - 281 иргэнийг хамруулсан. Иргэд дотор, гэмтэл, мэс засал, зүрх судас, шүд, арьс харшил, нүд, мэдрэл, эмэгтэйчүүд, халдварт гэсэн 10 чиглэлээр үзлэгт орж, ХБДЗ-ын уян дуран, элэгний В,С вирус , ДОХ, Syphilis, ПАП тестийн шинжилгээ өгч оношлуулсан байна.Үзлэгт хамрагдсан иргэдийн дунд тэргүүлэх өвчлөл хоол боловсруулах эрхтэн тогтолцооны эмгэг, дотоод шүүрлийн эмгэг мөн эмэгтэйчүүдийн дунд умайн хүзүүний үрэвсэл , үтрээний үрэвсэл өндөр хувьтай гарсан. 18-с дээш насны иргэдийн хамрагдалт 41565/12476/30,0 хувьтай байна | 70% |
| | 230 | | XXV.5.2. Малчдыг отор, нүүдэл хийх боломжийг бүрдүүлэх, бэлчээрийн даац, нөөц боломжид тулгуурласан отор нүүдлийн зохицуулалтыг тухай бүр хийж, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, аймаг, сумын Засаг дарга нарт даалгав | 2024-2025 оны өвөл- хаврын бэлчээрийн даацыг тооцоолж гаргасан дүнгээс үзвэл: Аймгийн нийт нутгийн 67.0 хувьд мал өвөлжилт, хаваржилт хэвийн байх боломжтой тодорхой тооны мал гаднаас отроор оруулах бэлчээрийн нөөцтэй, 13.0 хувьд гаднаас отрын мал оруулах бололцоогүй тухайн багийн мал өөрийн нутагт өвөлжиж, хаваржихад бэлчээр хүрэлцээтэй, 15.3 хувьд даац 1-3 дахин хэтэрсэн, 4.7 хувьд олон дахин хэтэрсэн. Энэ онд өөрийн аймгийн бусад сумын нутагт -978 өрхийн 98 мянган толгой мал ,хилийн зурвас бүс нутагт-352 өрхийн 223 мян.толгой мал,улсын тусгай хамгаалалттай бүс нутагт 264 өрхийн 72 мян.толгой мал нийт 1609 өрхийн 400 мян.толгой мал отор нүүдлээр өвөлжинө. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 130 | 231 | 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны 51 дүгээр тэмдэглэл 2023-12-20 Дугаар 2023_51 | XXV.3.2.5. Хог хаягдлаас үүсэж буй байгаль орчны бохирдол, доройтол нь агаар, хөрс, усны бохирдлыг ихээр үүсгэж байгаатай холбогдуулан Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | Аймгуудын төвийн хатуу хог хаягдлын менежментийн 9206-МОН төсөл”-ийн хүрээнд Сүхбаатар тохижилт үйлчилгээний газар дахивар хог хаягдлыг цуглуулан боловсруулж байна. Дахин Цуглуулсан хог хаягдал 2022 онд 1598.6 тн, 2023 онд 9665.5 тн, дахин Боловсруулсан хог хаягдал 2023 онд 2040 тн байна. 2023 онд дахивар дахин боловсруулах бичил үйлдвэр нь нийт 2377.1кг хуванцар сав,184.1кг лааз, Гялгар уут 1221кг -ыг худалдан авч нийт 1.156.515 төгрөгийн зардал гаргаж, Үүнээс 306кг буталж шон хийхэд 866кг гялгар уут ашиглан Том хашааны шон 25 ш, жижиг хашааны шон 52 ш нийт 77 шон үйлдвэрлэн 1540000 төгрөгийн борлуулалт хийгээд байна. - Аймгийн хэмжээнд ААНБ-ууд нийтийн эдэлбэр газарт цэвэрлэгээ хийж, айл өрхийг цэвэрлэгээнд уриалж нийтийн эзэмшлийн талбай болон хатуу хучилттай авто зам 53.4 км, явган хүний зам 52048 м2, талбайн хог цэвэрлэгээ тогтмол хийгдэж байна. Хотын өнгө үзэмжийг сайжруулах, иргэдийн эрүүл, цэвэр цэмцгэр орчинд ажиллаж амьдрах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор Баруун-Урт сумын Засаг даргын А/263 тоот захирамжаар “Маргаашийн хоггүй хуудсыг хамттай эргүүлцгээе" уриан дор нэрийн бүх нийтийн цэвэрлэгээг 2024 | 100% |
| | 232 | | XXV.3.2.11.. Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд нийтийн болон амины орон сууцны бүсийг тогтоох, шинэчлэн боловсруулах арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт | Аймгийн газар зохион байгуулалтын 2023-2030 он хүртэлх ерөнхий төлөвлөгөөг газар дэлхий ХХК-н хийж гүйцэтгэсэн ба 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 05 дугаар тогтоолын 1,2 дугаар хавсралтаар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулсан. Уг төлөвлөгөөнд нийтийн болон амины орон сууцны бүсийг 771,31 га газарт төлөвлөн тогтоосон. Тус төлөвлөлтийн эхний шатны төсөл хөтөлбөр болох 2 дугаар багийн нутаг дэвсгэрт 17 га газарт 960 айлын орон сууцны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, 3-р багийн нутаг дэвсгэрт 7,3 га газарт амины орон сууцны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулаад байна. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 233 | | XVII.2.4.. Орон нутагт мах худалдан авах явуулын цэг ажиллуулах боломжийг судалж, холбогдох шийдвэрийг гарган арилжааны банкуудтай хамтран ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав. | 2024 оны 1-р улиралд Баруун-Урт хоногт 1000 бог, 400 бог малын мах боловсруулах хүчин чадал бүхий хувийн хэвшлийн 20,0 тэрбум төгрөгийн үйлдвэр ашиглалтанд орж үйл ажиллагаагаа явуулж байна. Өнөөдрийн байдлаар аймгийн хэмжээнд Баруун-Урт суманд 5, Баяндэлгэр суманд 1 мах боловсруулах үйлдвэр, мал нядлах 13 цех, мах худалдан борлуулах 3 цэг тасралтгүй үйл ажиллагаа явуулж байна. | 100% |
| 131 | 234 | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны 52 дугаар тэмдэглэл 2023-12-27 Дугаар 2023_52 | XL.3.3. Батлагдсан төсөвт эх үүсвэрийнхээ хүрээнд мал, махны борлуулалт, худалдан авалтыг нэмэгдүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав | 2024 оны байдлаар аймгийн хэмжээнд нийт мах боловсруулах 6 үйлдвэр, мал нядлаж 13 цех үйл ажиллагаа явуулж мах бэлтгэн зах зээлд нийлүүлж байна . Мөн "Шинэ хоршоо" хөдөлгөөний хүрээнд 13 сумын 28 хоршоо мал мах бэлтгэх, худалдан борлуулах чиглэлээр нийт 2,8 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл авсан байна. | 100% |
| | 235 | | XXXX.11.4. Монгол Улсад 2024 онд зохион байгуулах олон улсын арга хэмжээний цаглабрыг гадаадад сурталчлах арга хэмжээ авахыг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Соёлын сайд Ч.Номин нарт, цаглабарт тусгасан арга хэмжээний хэрэгжилтийг хангуулж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ болон Засгийн газрын холбогдох гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав.” | “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивальд Сүхбаатар аймгаас Удирдамжийн дагуу Дарьганга, Үзэмчин угсаатан ястаны язгуур урлаг, Боловсролын хөтөлбөр, гар урлал үзэсгэлэн, Дарьганга угсаатны соёл, зүүн 3-н аймгийн хамтарсан Сэцэн ханы хурд зүүн бүсийн хурдан морины соёл, уяа сойлго зэргийг таниулан сурталчилах зориулалттай 5-8 ханатай 3-н гэр, бэлтгэн оролцсон. Ардын урлаг, боловсролын хөтөлбөр, соёлын өвийн арга хэмжээнд 6 ай савын хүрээнд ардын авьяастан, соёлын биет бус өвлөн уламжлагч 13, Жаахан шарга театрын уран бүтээлч 20, гар урлал үзэсгэлэн 4, зохион байгуулалт, аж ахуйн албаны 8 нийт 45 хүний бүрэлдэхүүнтэй оролцлоо. “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивальд оролцоход Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын яам 10 сая, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газар 10 сая, Сүхбаатар аймгийн Засаг даргын тамгийн газраас 20 сая төгрөгний дэмжлэг үзүүлсэн.Цагалбарт тусгагдсан Агтана хүрээт арга хэмжээ 11 сарын 16-17 өдрүүдэд амжилттай зохион байгуулагдсан. Хунгийн баяр зохион байгуулагдаагүй. Засгийн газрын тогтоолоор аялал жуулчлалын салбар нь Соёлын яаманд харьяалагдах болсон тул хяналтаас хасуулах саналтай байна. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 132 | 236 | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн хуралдааны 5 дугаар тэмдэглэл 2024-01-31 Дугаар 2024_5 | 12.9.2. Орон нутагт мал, мах худалдаалах зориулалтын цэг байгуулах арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт | 2024 оны 1-р улиралд Баруун-Урт хоногт 1000 бог, 400 бог малын мах боловсруулах хүчин чадал бүхий хувийн хэвшлийн 20,0 тэрбум төгрөгийн үйлдвэр ашиглалтанд орж үйл ажиллагаагаа явуулж байна. Өнөөдрийн байдлаар аймгийн хэмжээнд Баруун-Урт суманд 5, Баяндэлгэр суманд 1 мах боловсруулах үйлдвэр, мал нядлах 13 цех, мах худалдан борлуулах 3 цэг тасралтгүй үйл ажиллагаа явуулж байна. | 100% |
| 133 | 237 | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн хуралдааны 8 дугаар тэмдэглэл 2024-02-28 Дугаар 2024_8 | 22.6.2. Зудын улмаас хорогдсон малын сэг, зэм булшлах, устгах ажлыг өргөн хүрээтэй, шуурхай зохион байгуулж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, аймгийн Засаг дарга нарт тус тус | Аймгийн Засаг даргын "Мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгах, орчны цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн арга хэмжээ зохион байгуулах тухай" А/173 дугаар захирамж гарган сумдын Засаг дарга нарт болон холбогдох байгууллагуудад 3 сарын хугацаанд 310 цэгт булшлаж устгахыг чанартай хийж гүйцэтгэсэн.<br><br>Хяналтаас хасуулах санал : 2023-2024 оны өвөлжилт, хаваржилт цаг хугацааны хувьд өнгөрсөн тул хасах саналтай | 100% |
| | 238 | | 22.10.3. Орон нутгийн хэмжээнд бэлтгэсэн махны чанар, аюулгүй байдалд хяналт, шалгалт хийх, стандартын шаардлага хангасан махыг төв, суурин газрын хүн амын хүнсний хэрэгцээнд нийлүүлэх ажлыг шуурхай зохион байгуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны салбарын хяналтын газрын салбарын ерөнхий байцаагчийн баталсан 08-00-02/29 дугаартай удирдамжийн дагуу мал төхөөрөх 2 объект, мах боловсруулах 1 объект, нийт 2 аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус шалгалт хийж 78 зөрчил илрүүлэн 56.0 хувийг газар дээр арилгуулан улсын ахлах байцаагийн 38 заалттай 2 албан шаардлага хүргүүлэн биелэлт 85 хувьтай байна. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 134 | 239 | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны 12 дугаар тэмдэглэл 2024-03-27 Дугаар 2024_12 | 14.8. Үүнтэй холбогдуулан Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн хуралдааны 06 дугаар тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоот хуулийн этгээд, компани, үйлдвэрийн газрын захирал, дарга нарт, үр дүнг нэгтгэж 2024 оны 06 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгаланд тус тус даалгав." (Үндэсний судалгааны нэгдсэн | Аймагт хамааралгүй | Х.Б |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 135 | 240 | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдааны 13 дугаар тэмдэглэл 2024-04-03 Дугаар 2024_13 | 22.6.1.. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулах, эрхэлсэн салбар, харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийгмийн ач холбогдол, эдийн засгийн үр ашгийн талаар мэдээллийг олон нийтэд сурталчлан таниулах арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу тус тус авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт;(.Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтийн 2024 оны 1 дүгээр улирлын яви | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 18 нэр төрлийн 58,933,700,00 төгрөгийн бараа ажил үйлчилгээний төсөл арга хэмжээ эрх шилжиж ирснээс 17 нэр төрлийн 58,597,700,000 төгрөгийн бараа ажил үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, 17 ААН-тэй 58,415,072,857 төгрөгийн гэрээ байгуулсан. Үлдсэн 1 төсөл арга хэмжээг 4 дэх удаагаа зарлаж байгаа бөгөөд хүлээн авах хугацаа болоогүй байна. Бусад эрх шилжиж ирсэн бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааг 100% зохион байгуулсан байна. Төсөл сонгон шалгаруулалтаас төсөвт 182,627,143 төгрөгийн хэмнэлт үүсгэсэн байна. | 100% |
| 136 | 241 | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн | 14.17.1.1. Газрын нэгдмэл сангийн өөрчлөлт, шилжилт хөдөлгөөнийг бүртгэх болон газар эзэмшүүлэх, ашиглуулах эрх олгохтой холбогдсон үйл ажиллагааг Газрын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, журмын дагуу хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.(.Монгол Улсын газрын нэгдмэл сангийн 2023 оны улсын нэгдсэн тайлангийн талаар ) | Газрын кадастрын мэдээллийн санд гэрээний хугацаа сунгуулж засварлах 15, хувийн хэрэгт бүрдэл хангахгүй хавсралт хэсэгт буруу оруулсан болон засварлан зөвөөр оруулсан 156 нэгж талбар гэрээний төлөв өөрчлүүлсэн 10 нэгж талбаруудыг газрын нэгдмэл сангийн цахим системд засварлагдсан. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 136 | 242 | хуралдааны 14 дүгээр тэмдэглэл 2024-04-10 Дугаар 2024_14 | 14.17.1.2. Бэлчээрийн газар ашиглалт, түүний даацыг тохируулах, өнжөөн сэлгэх, хүчтэй элэгдэл, эвдрэлд өртсөн тариалангийн газрыг нөхөн сэргээх, хот суурин газрын хөрсний бохирдлыг бууруулах арга хэмжээг жил бүрийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж, холбогдох хууль тогтоомж, журмын дагуу хэрэгжилтийг зохион байгуулан ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав; | 024 онд Сүхбаатар сум сэлгэж ашиглах бэлчээрээр 7 байршлын 271.9га, Мөнххаан сум 11 байршлын 262.3га, Дарьганга, Мөнххаан, Сүхбаатар сумд дахин эргэлтэд оруулах атаршсан газрын төлөвлөлтөөс нийт 6 байршилд 1338.3га, Асгат, Мөнххаан, Сүхбаатар, Халзан усны эх булаг, эрэг орчмын газрыг хашиж хамгаалах 9 байршлын 54.07га арга хэмжээнүүдийг 2024 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулан батлуулсан. Хэрэгжилт 2024 оны 12 дугаар сарын 16-ны байдлаар Сүхбаатар, Мөнххаан сумдад сэлгэж ашиглах бэлчээрээр төлөвлөсөн газрын биелэлт 100 хувь хэрэгжсэн. Дахин эргэлтэд оруулах атаршсан газрын төлөвлөлтийн биелэлтийн явц 1 нэгж талбарын 152.47 га газрыг дуудлага худалдаагаар Сүхбаатар сум олгоод байна. | 100% |
| 137 | 243 | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдааны 15 дугаар тэмдэглэл 2024-04-17 Дугаар 2024_15 | 20.11.1. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд байнга ил тод, нээлттэй байлгахаар заасан мэдээллийг “Нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)”-д байршуулах ажлыг хариуцсан салбар, нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, мэдээллийг тухай бүр шинэчилж ажиллахыг төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой байгууллагуудын удирдлага, аймаг, нийслэлийн Засагдарга нарт;(Шил” ажиллагааны хэрэгжилтийн талаар ) | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны “2023-2024 оныг авлигатай тэмцэх жил болгон зарлах тухай” 49 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны “Шил ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” 01 дүгээр болон 2024 оны “2024 оны эхний хагас жилд хэрэгжилтийг эрчимжүүлэх төсөл, арга хэмжээний тухай” 01 дүгээр тус тус албан даалгаврыг хэрэгжүүлэх хүрээнд аймгийн агентлаг, төсөвт байгууллага, сумдын ЗДТГазрын нээлттэй мэдээлэл, шинэчлэх байршуулах албан хаагчдын мэдээллийг авч холбогдох байгууллагад хүргүүлэн shilen.gov.mn 2.0 системд эрхүүдийг нээлгэж, системийн хэрэглэгчдэд зориулсан 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн цахим сургалтын талаар мэдээллийг албан бичгээр хүргүүлж нийт 30 гаруй байгууллагын албан хаагчдыг хамруууллаа. 2024 оны хагас жилд 37 байгууллага системд бүртгэлтэйгээс 16 байгууллага тайлан илгээж, 3 байгууллага бүртгэсэн, 17 байгууллага огт тайлан илгээгээгүй байна. Тус арга хэмжээг эрчимжүүлэх чиглэлээр сум, агентлаг, албадад 2 удаа чиглэл хүргүүлж холбогдох арга хэмжээг авч ажилласан. 2024 оны 12 дугаар сарын байдлаар нээлттэй мэдээллийн нэгдсэн системд 37 байгууллага бүртгэлтэйгээс хагас жилийн | 70% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 138 | 244 | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдааны 16 дугаар тэмдэглэл 2024-04-24 Дугаар 2024_16 | 26.3.5. Шатахуун түгээх болон автомашин хийгээр цэнэглэх станцын аюулгүйн бүсийг зөрчиж газар олгохгүй байхыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт; | Сумдын 2024 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд шатахуун түгээх станцын хамгаалалтын зурваст газар төлөвлөгдөөгүй болно | 100% |
| | 245 | | 26.3.6. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор газрын тосны бүтээгдэхүүний агуулах, шатахуун түгээх болон автомашин хийгээр цэнэглэх станцад орчны дүрс бичлэгийн техник, хэрэгслийг байршуулж, цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбох арга хэмжээ авахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр болон бүх шатны Засаг дарга нарт; | Аймгийн хэмжээнд Петровис, МТ, Шунхлай, Жаст ойл, Тэс зэрэг 33 шатахуун түгээх станц, 3 газ түгээгүүрийн газар, нийт 36 ШТС-ууд үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд эдгээр газрууд нь дүрс бичлэгийн техник хэрэгсэл болох теле камерыг байршуулж, "Теле камерын хяналтын нэгдсэн төв"ийн системд холбох ажил 100 хувь хийгдсэн байна. | 100% |
| 139 | 246 | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн хуралдааны 17 дугаар тэмдэглэл 2024-05-01 Дугаар 2024_17.1 | 28.3.1.. “Нийгмийн түншлэлийг хэрэгжүүлэх хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг хангаж аймаг, нийслэл, салбарын түвшинд ажил олгогчийн болон ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах байгууллагатай хэлэлцээ хийж хамтын хэлэлцээр байгуулан, ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт | Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, хүн амын нийгмийн баталгааг хангах, нийгмийн түншлэгч талуудын хамтын ажиллагааг сайжруулахад баримтлах баримт бичгийг аймгийн Засаг дарга, Үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга, Ажил олгогч эздийн холбооны тэргүүн нар хамтран баталсан. Энэхүү хэлэлцээр батлагдсан цаг үеэсээ эхлэн иргэдийн хөдөлмөрлөх эрх ашгийг хамгаалж, иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин нэмэгдүүлэх, хүн амын нийгмийн баталгааг хангах, нийгмийн түншлэгч талуудын хамтын ажиллагааг сайжруулахад баримтлах баримт бичиг болсон | 70% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 140 | 247 | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн хуралдааны 18 дугаар тэмдэглэл 2024-05-08 Дугаар 2024_18.1 | 19.3.2.. Уг төлөвлөгөөнд туссан үйл ажиллагааг эрхэлсэн салбар, харьяалах нутаг дэвсгэрийн хүрээнд хэрэгжилтийг зохион байгуулах, шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжийн хүрээнд шийдвэрлэж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн холбогдох байгууллагын төсвийн шууд захирагч нарт даалгав. | төлөвлөгөө тодорхой бус | Х.Б |
| 141 | 248 | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааны 19 дүгээр тэмдэглэл 2024-05-15 Дугаар 2024_19.1 | 22.5.2. Хот байгуулалтын норм, стандартын дагуу цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн барилга барих зориулалтаар газар чөлөөлөх, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль бариагүй орон сууцны хотхон, хорооллыг ашиглалтад хүлээн авахгүй байх, ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнд тухайн орон нутгийн боловсрол, шинжлэх ухааны газраас төлөөлөл оруулж, хяналтыг сайжруулах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав | Аймгийн Засаг даргын захирамжаар улсын болон орон нутаг, хувийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа ажлууд дээр барилгын тухай хууль тогтоомжоор улсын комисс томилон ажиллуулж байна. Уг заалттай холбоотой улсын комиссын бүрэлдэхүүнд аймгийн боловсролын газраас холбогдох албан тушаалтанг оруулж хууль тогтоомжийн дагуу ажиллаж байна. 2023 онд ашиглалтын шаардлага хангахгүй болсон улсын байцаагчийн дүгнэлтээр ашиглалтын шаардлага хангахгүй хуучин 7- дугаар цэцэрлэгийн барилгыг буулган газрыг чөлөөлж ажилласан. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 249 | | 2.. Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрийг Зүүн бүсийн “Түүхэн аялал жуулчлалын бүс” болгон зарласантай холбогдуулан “Түүхэн аялал жуулчлалын бүс”-ийг хөгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, Их Хуралдай цогцолборын үйл ажиллагааг идэвхжүүлэх менежментийн төлөвлөгөөг тус тус боловсруулж, Аялал жуулчлалын Үндэсний хорооны хуралдаанд хэлэлцүүлэн батлуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэд, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүд, Хэнтий, Сүхбаатар, Дорнод аймгийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгов. | Монголын Аялал Жуулчлалын Холбооноос 2024 оны 10 сарын 25-аас 27-ний өдрүүдэд “International Travel Mart 2024” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнг “Үндэсний соёл, аялал жуулчлал, технологийн хөгжил” уриан дор 25 дахь жилдээ аялал жуулчлалын бизнес эрхлэгчид хоорондоо туршлага хуваалцах, туршлага судлах, харилцагчид хоорондын уялдаа холбоо, түншлэлийн харилцааг батжуулах, мэдээ мэдээллээр хангагдах, цаашдын чиг хандлагыг тодорхойлох, оновчтой гарц гаргалгааг эрэлхийлсэн олон талт боломжуудыг бий болгосон онцлогтой зохион байгууллаа. Зүүн бүсийг “Түүхэн аялал жуулчлалын бүс” болгон зарласантай холбогдуулан тус үзэсгэлэнд Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймаг хамтран бүсээрээ нэгдэж нэгдсэн талбайгаар хамтран оролцсон нь өмнөх жилийн үзэсгэлэнгээс онцлогтой байлаа. Сүхбаатар аймгаас аймгийн ЗДТГ, Соёл урлаг, аялал жуулчлалын газар, залуучуудын газар, Баруун-Урт сумын Дарьганга цай брэнд, Халзан сумын Батжаргалын Таанын сорс, Дарьганга сумын Аюурзанын Шилийн богд цай, Мөнх сайн үүд ХХК хамтран 7-8 төрлийн 100 гаруй бүтээгдэхүүн, 600 гаруй тараах материалтай оролцлоо. | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 142 | 250 | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн хуралдааны 20 дугаар тэмдэглэл 2024-05-22 Дугаар 2024_20.1 | | 19.1. Үүнтэй холбогдуулан зудын улмаас мал нь хорогдсон малчин өрхүүдийн судалгааг нарийвчлан гаргаж, тэднийг малжуулах хөтөлбөрт хамруулах, малчдын амьжиргааг дээшлүүлэх зорилгоор авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар Засгийн газрын хуралдаан бүрд танилцуулж байхыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуунд, малчныг малжуулах хөтөлбөрт хамруулах арга хэмжээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэх арга хэмжээ авахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, аймгийн Засаг дарга нарт даалгав.(Зудын улмаас мал нь хорогдсон малчин өрхүүдийн | "Гамшгийн улмаас мал нь хорогдсон, малгүй болсон малчдыг малжуулах арга хэмжээнд 13 сумын 507 малчин өрхийг малжуулахаар төсөв батлагдаж ирсэн. Арга хэмжээнд хамрагдахаар 856 малчин хүсэлт ирүүлсэнээс сумдын амьжиргаа зөвлөлтийн хурлаар хэлэлцэн 507 өрхийг хамруулахаар шийдвэрлэж малжуулах арга хэмжээнд хамрагдах өрхүүдэд батламж гардуулан малыг нь хүлээлцэх ажлыг газар дээр нь зохион байгуулж 4,056,000.0 сая төгрөгийн зарцуулсан. Малжуулах арга хэмжээгээр адуу 32, үхэр 970, хонь 9610, ямаа 10110 нийт 20722 толгой малыг нь хүлээлгэн өгсөн. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 251 | | 19.3.2. Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрийг Зүүн бүсийн “Түүхэн аялал жуулчлалын бүс” болгон зарласантай холбогдуулан “Түүхэн аялал жуулчлалын бүс”-ийг хөгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, Их Хуралдай цогцолборын үйл ажиллагааг идэвхжүүлэх менежментийн төлөвлөгөөг тус тус боловсруулж, Аялал жуулчлалын Үндэсний хорооны хуралдаанд хэлэлцүүлэн батлуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэд, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүд, Хэнтий, Сүхбаатар, Дорнод аймгийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгов. | Монгол улсад 2024 онд зохион байгуулах олон улсын арга хэмжээний цаглабарт тусгагдсан “Агтана хүрээт” монгол туургатны адуун соёлын их наадам найм дахь жилдээ уламжлал ёсоор 11-р сарын 16, 17 ний өдрүүдэд Шилийн богд уулын ар бэлд “Соёлтой наадая залуучуудын манлайлал” уриан дор амжилттай зохион байгуулагдсан. Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газраас энэ удаагийн арга хэмжээнд 5 хүний бүрэлдэхүүнтэй оролцож, “Соёлтой залуус”, “Бид соёлыг түгээнэ”, “Өв соёлоо дээдэлье” уриалга, газрын албан хаагчид Соёлыг түгээе гарын бүч хийж зүүж нөлөөллийн ажил хийхээс гадна уул усандаа хэрхэн зөв хүндэтгэл үзүүлэх үү, хээрийн түймрээс урьдчилан сэргийлье зэрэг 300 орчим санамжуудыг тарааж ажилласан. Мөн Агтана хүрээт “Нэг-хором” гэрэл зургийн уралдааныг зарлаж эхний гурван байрыг шалгаруулж өргөмжлөл мөнгөн шагналаар шагнасан. Тус эвентэд 12 аймаг болон БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөлөнбуйр, Шилийн гол аймаг зэрэг нийт 2500-3000 орчим хүн ирж оролцсон томоохон арга хэмжээ болсон. Хамгийн хол нь Увс, Ховд аймгаас адуучид ирж оролцсоноороо онцлогтой байлаа. Агтана хүрээт эвентийг зохион байгуулснаар монгол адууны өв соёлыг залуучуудад | 70% |
| 143 | 252 | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 22 дугаар тэмдэглэл 2024-06-06 Дугаар 2024_22 | 37.1.1. “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлж, малчдад зөвлөн туслах үүрэг бүхий багийг орон нутагт үргэлжлүүлэн ажиллуулж, холбогдох албан хаагчдын албан томилолтын болон замын зардал, тээврийн хэрэгслийг шуурхай шийдвэрлэх арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, агентлагийн дарга, төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга (захирал) нарт | “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлж, малчдад зөвлөн туслах үүрэг бүхий багийг орон гишүүд сургагч багшийн сургалтанд хамрагдаж бэлтгэгдсэн. Сургагч багш нар сумын бүрт багийн уулзалт өдөрлөг арга зохион байгуулж, Шинэ хоршоо хөдөлгөөний талаарх төрийн бодлого, малчдад зөвлөн туслах хоршоо байгуулах зөвлөмж, арга зүйн дэмжлэг тогтмол өгч ажилласан. Орон нутгийн хэмжээнд 5319 өрхийн 13822 гишүүнд мэдээлэл өгсөн. Сүхбаатар аймагт Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд 200 шинэ хоршоо байгуулагдаж, 1800 малчин хоршооны гишүүнээр элссэн байна. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 144 | 253 | Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн хуралдааны 31 дүгээр тэмдэглэл 2024-09-04 Дугаар 2024_31 | 31.9.6. 2/ Төрийн байгууллагын “gov.mn” нэгдсэн цахим хуудаст мэдээллийг байршуулах, тухай бүр шинэчлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт | Монгол Улсын засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 31 дүгээр хурлын тэмдэглэлийг үндэслэн "И-Монгол академи" УТҮГазраас төрийн байгууллагуудын нэгдсэн цахим хуудасны хөгжүүлэлт, нэвтрүүлэлтийн талаар зохион байгуулсан сургалтад 10 дугаар сард хамрагдлаа. Тус сургалтаар цахим хуудасны бүтэц зохион байгуулалт, мэдээ мэдээлэл оруулах, байгууллага хэрэглэгч бүртгэх эрхүүдийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авч ажилласан. Төрийн нэгдсэн цахим хуудсанд байгууллага нэмэх, хариуцах албан тушаалтанд эрх нээх чиглэлийг сумд болон агентлаг, төсөвт байгууллагуудад 10 сард хүргүүлж холбогдох мэдээллийн дагуу 15 байгууллагад админ эрхийг нээн өгч ажилласан.<br><br>Хэрэгжилт удааширсан шалтгаан: Урт хугацааны туршид хэрэгжих | 30% |
| 145 | 254 | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдааны 32 дугаар тэмдэглэл 2024-09-11 Дугаар 2024_32 | 32.6.2.. 2.1.3асгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны 50 дугаар тэмдэглэлээр өгсөн даалгаврыг хэрэгжүүлж, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгүй сумдын төлөвлөгөөг боловсруулж, батлуулах ажлыг эрчимжүүлж, шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт тусган шийдвэрлүүлэхийг холбогдох аймаг, сумын Засаг дарга нарт, төлөвлөгөөний харилцан уялдааг зохицуулж, мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллахыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурьд() | Аймагт сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийгдээгүй 3 сум үлдсэн ба хөрөнгийг 2025 оны орон нутгийн төсөвт 450,000 сая төгрөрийг тусгасан. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 146 | 255 | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн хуралдааны 35 дугаар тэмдэглэлд 2024-10-02 Дугаар 2024_35 | 14.7.2.. Газрын эрхийн давхцалтай 6206 зөрчлийг арилгах, тусгай хамгаалалттай газар нутагт олгогдсон 4953 нэгж талбар газрын эрх болон уул уурхай, ашигт малтмалын зориулалтаар олгогдсон 447 нэгж талбар газрын эрхийг баталгаажуулах ажлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах арга хэмжээ авахыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт даалгав; | Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газраас ирүүлсэн албан тоотын хүрээнд тус аймгийн 3 суманд илэрсэн зөрчил дутагдлыг арилгах зорилгоор сумдын Засаг дарга хугацаатай чиглэл хүргүүлсэн | 70% |
| 147 | 256 | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдааны 39 дүгээр тэмдэглэл 2024-11-13 Дугаар 2024_39 | 39.29.11.3. Энэ тэмдэглэлийн 2.1, 2.2, 2.3 дахь хэсэгт зааснаас гадна захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй байгаа өөрийн салбарын бусад шийдвэрийг дараах чиглэлээр хянан үзэж, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бичгээр хариу мэдэгдэхийг бүх шатны захиргааны байгууллагын удирдлагад даалгав: (Үүнд :3.1.хүчингүй болсон тушаал, захирамж, тогтоол байгаа эсэх;<br>3.2.ач холбогдлоо алдсан, дагаж мөрдөгдөхгүй тушаал, захирамж, тогтоол байгаа эсэх;<br>3.3.нэмэлт, өөрчлөлт оруулсан буюу хөдөлгөөн хийгдээгүй тушаал, захирамж | Албан даалгаварын хэрэгжилтийг хангах чиглэлээр ажиллаж байна. | Х.Б |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 257 | | 39.29.12.3. Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллага кибер аюулгүй байдлыг хангах чиг үүргээ тодорхой албан тушаалтанд хариуцуулж, үйл ажиллагааны болон кибер аюулгүй байдлыг хангахад шаардагдах зардлыг жил бүрийн төсвийн төсөлд тусгаж байхыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт | Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагуудад тус асуудлыг анхаарч ажиллахыг чиглэл болгосон | Х.Б |
| 148 | 258 | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдааны 40 дүгээр тэмдэглэл 2024-11-20 Дугаар 2024_40 | 40.19.5.3. “Өвлийн идэш” арга хэмжээнд малчдын хоршоодын оролцоог хангахад дэмжпэг үзүүлж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.” гэжээ. | Арга хэмжээнд хоршоодыг татан оролцуулж, дэмжлэг үзүүлж ажиллахыг ХХААЖДҮ-ийн газарт үүрэг болгосон. Хугацааны хувьд хэрэгжилтийг дүгнэх боломжгүй байна. | Х.Б |
| | 259 | | 40.19.7.2. Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа аймаг, сум, нийслэл, дүүргийн хилийн цэсийг тогтоосон Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлиг, Улсын Их Хурлын тогтоолыг сахин мөрдөж, тэдгээрээс зөрүүтэй газар зүйн нэр, зургийг үндэслэн аливаа хилийн цэстэй холбоотой маргаан үүсгэхгүй байх талаар онцгой анхаарч ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт тус тус үүрэг болгов. | Аймаг, сумын хилийн цэсийг тогтоосон Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлиг, Улсын Их Хурлын тогтоолыг сахин мөрдөж байна. Хийлийн хийлийн цэстэй холбоотой маргаан гараагүй байна. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 149 | 260 | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуралдааны 43 дугаар тэмдэглэл 2024-12-04 Дугаар 2024_43 | 43.6.2.. Төсвийн жилд багтаан барьцаа хөрөнгийн данснаас чөлөөлөх боломжгүй, хэрэгжилт удаашралтай, зогссон төслүүдийн гэрээг дүгнэж, эцсийн тооцоог баталгаажуулан барьцаа хөрөнгийн данс дахь санхүүжилтийн үлдэгдлийг улсын төсөвт буцаан төвлөрүүлэхийг төсвийн холбогдох ерөнхийлөн захирагч, аймаг, нийслэлийн Засагдарга нарт даалгав | Барьцаа хөрөнгийн данснаас чөлөөлөх боломжгүй, хэрэгжилт удаашралтай, зогссон төслүүдийн гэрээг дүгнэх ажил хийгдэж байна. | Х.Б |
| ЗГ-ын албан даалгавар | | | | | |
| 150 | 261 | Цахим шилжилтийг эрчимжүүлэх тухай 2022-07-04 Дугаар 2022_3 | 2. Энэ албан даалгаврын 1-д заасан төлөвлөгөөнд тусгах нийтийн мэдээллийн дэд бүтцэд хамаарах төсөл, хөтөлбөр, арга хэмжээг төлөвлөхдөө Цахим хөгжил, харилцаа холбооны яамны санал, зөвлөмжийг заавал авч байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай. | Цахим хөгжил, харилцааны холбооны яамнаас гаргасан цахим аймаг бодлогын зөвлөмжийн дагуу “Цахим Сүхбаатар” хөтөлбөрийн ажлын хэсгийг Аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн А/570 захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг "Цахим Сүхбаатар" дэд хөтөлбөр, төлөвлөгөөний боловсруулалтыг хийж Цахим хөгжил, харилцаа холбооны яамны сайдын зөвлөх Б.Ганбат-д цахим хэлбэрээр илгээн зөвлөгөө мэдээлэл авч ажиллаж 2024 оны 4 дүгээр сарын 29-нд дэд хөтөлбөрийг аймгийн ИТХуралдаанаар батлуулж, хэрэгжилтийн биелэлтийг жилийн эцсээр дүгнэн ажиллахаар төлөвлөн ажиллаж байна. | 70% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 151 | 262 | Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийг сурталчлан таниулах тухай 2022-07-05 Дугаар 2022_6 | 1. 1.1. ""Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого", "Шинэ сэргэлтийн бодлого"-ын зорилго, зорилт, үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар харъяа байгууллагын албан хаагчдад сургалт зохион байгуулах;<br><br>1.2.""Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого", "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хэрэгжилтийн явцын талаар иргэд, олон нийтэд таниулах, сурталчлах ажлыг салбарынхаа хэмжээнд зохион байгуулах; | 2024 онд Алсын хараа 2050-н хүрээнд бүх багийн засаг дарга нарт сургалтыг Удирдлагын азадемитай хамтран 2 өдөр зохион байгуулж, нийт 67 багийн засаг дарга нарт сургалт зохион байгуулж Алсын хараа 2050 бодлогын баримт бичгийн сурталчлан таниулах ажлыг хэрэгжүүлсэн.<br><br>Хяналтаас хасуулах санал : Товлосон хугацаанд ажил арга хэмжээг зохион байгуулж, тайлан мэдээг илгээсэн тул хасах саналтай | 100% |
| 152 | 263 | Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсантай холбогдуулан 2024 онд багтаан хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тухай 2024-09-18 Дугаар 2024_01_1 | 1.14.. Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг нэмэгдүүлэх, эрсдэлийн удирдлагын реформыг хэрэгжүүлэхийг Шадар сайд (бүсчилсэн хөгжил, онцгой байдлын асуудал хариуцсан) С.Амарсайхан, Батлан хамгаалахын сайд С.Бямбацогт, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт. | 2024 оны 11 дүгээр сарын 21, 22-нд Улаанбаатар хотод зохион байгуулагдах Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын удирдах бүрэлдэхүүн, удирдах ажилтны зөвлөгөөнд Цэргийн штабын дарга оролцож 2025 онд Үндэсний сөрөн тэсвэрлэх чадвахыг нэмэгдүүлэх талаар гарах журам хөтөлбөр төлөвлөлтийн баримт бичгийн дагуу орон нутагт хэрэгжилтийг хангах талаар ажиллаж байна. | 70% |
| | | | | | |